

НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019

Захиалагч: Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар,
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр

Гүйцэтгэгч: “Эм Эм Си Жи” ХХК



ASIA
PACIFIC
RESEARCH
COMMITTEE



ESOMAR¹⁹
corporate



НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА

Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” /2017-2020/ төслийн хүрээнд **“НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААРХ ИРГЭД ОЛОН НИЙТИЙН САНАА БОДЛЫН СУДАЛГАА”**-г үндэсний судалгааны “Эм Эм Си Жи” ХХК хийж гүйцэтгэлээ.

Судалгааг олон улсын судалгааны ёс зүйн ESOMAR -ын стандарт; гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, санаа бодлын болон нийгмийн судалгааны ISO 20252:2019 стандартын дагуу Улаанбаатар хотын 9 дүүрэг, орон нутгийн төлөөлөл болох 6 аймагт 2019 оны 11 дүгээр сард хийж гүйцэтгэв.



АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	8
УДИРТГАЛ.....	9
ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ.....	10
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	12
1.1. Судалгааны аргачлал.....	12
1.2. Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт	12
1.3. Судалгааны хяналтын процесс.....	19
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	21
2.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	21
2.2. Иргэдийн сонгуулийн идэвх болон сонгуулийн тогтолцооны талаарх санаа бодол ...	26
2.2.1. Иргэдийн сонгуулийн идэвх, оролцоо.....	26
2.2.2. Одоогийн орон нутгийн сонгуулийн тогтолцооны талаарх үнэлгээ	30
2.3. ИТХ -ын талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээ	32
2.3.1. ИТХ -ын талаарх нийтлэг ойлголт.....	32
2.3.2. ИТХ -ын талаарх мэдээлэл авах байдал	36
2.3.3. Аймаг/Нийслэлийн ИТХ -ын талаарх ойлголт, хандлага	41
2.3.4. Сум/Дүүргийн ИТХ -ын талаарх үнэлгээ.....	48
2.3.5. Иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох байдал.....	61
2.4. ИТХ -ын төлөөлөгчдийн талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээ.....	69
2.4.1. Аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчдийн талаарх нийтлэг ойлголт.....	69
2.4.2. Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдийн талаарх ойлголт	72
2.5. Баг/хорооны ИНХ -ын талаарх иргэдийн оролцоо.....	88
2.5.1. Баг/хорооны ИНХ -д оролцсон байдал.....	88
2.5.2. Баг/хорооны хурлын талаарх мэдээлэл авсан суваг.....	90
БҮЛЭГ 3. ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	93
3.1. ИТХ-ын төлөөлөгчид тулгардаг асуудал, бэрхшээл	93
3.1.1. ИТХ болон засаг дарга хоорондын эрх мэдлийн тэнцвэрийг зохистой хангах байдал	93
3.1.2. Дээд шатны байгууллагаас дэмжлэг үзүүлэх байдал	95
3.1.3. ИТХ -ын зүгээс гаргасан шийдвэр оновчтой байж чаддаг эсэх	97

3.1.4.	Иргэдийн ИНХ -д оролцох байдлыг үнэлж буй байдал.....	97
3.1.5.	ИНХ -д бүх насны, нийгмийн бүх түвшний хүмүүсийн төлөөллийг оролцуулахын тулд хийгддэг ажлууд	101
3.1.6.	ИТХ -ын 2019 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл	102
3.1.7.	ИТХ -ын талаарх иргэдийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхийн тулд хийгддэг ажил	104
3.2.	ИТХ-ын талаарх бодлогын шинэчлэлтэй холбоотой санал хүсэлт	105
3.2.1.	ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, түүний шалгуур үзүүлэлт	105
3.2.2.	Сумын ИТХ -ын тогтоох боломжтой гэж үзэж буй татварын төрөл.....	107
3.2.3.	Сум, дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдийн сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэхгүй тохиолдолд эрхийг шилжүүлэх боломжтой субъект	107
3.2.4.	Хот тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын эзэмших боломжтой эрх	108
3.2.5.	Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангахын тулд нэмэх шаардлагатай эрх.....	108
3.2.6.	Сумын өөрийн удирдлагад төсвийн талаар бие даах асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх боломж	109
3.2.7.	Багийг 10 өрхийн, хороог хэсгийн зохион байгуулалтад оруулахын эерэг ба сөрөг үр дагавар	110
3.2.8.	Аймгийн төвийн сумыг хот болгон өөрчилснөөр уг хотын захирагчийн үүргийг аймгийн засаг дарга гүйцэтгэхийг дэмжиж буй байдал.....	111
3.2.9.	Шат шатны хурлын тэргүүлэгчид үндсэн хуулийн бус эрх хэмжээтэй болох тохиолдолд хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтад орох өөрчлөлтийн талаарх төсөөлөл	112
3.2.10.	Орон нутгийн төсөвт татварын орлогыг нэмэгдүүлэхэд дутагдаж буй эрх зүйн зохицуулалт	113
3.2.11.	Төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн тодорхой хэсгийг санхүүгийн дэмжлэгт оруулахад шаардагдаж буй эрх зүйн зохицуулалт.....	116
	НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	118

I ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үр дүнгийн хураангуй.....	10
Хүснэгт 2: Сумдыг сонгосон шалгуур үзүүлэлт.....	13
Хүснэгт 3: Сонгогдсон сумдын түүврийн хэмжээ.....	14
Хүснэгт 4: Хороог сонгосон шалгуур үзүүлэлт.....	15
Хүснэгт 5: Сонгогдсон хороодын түүврийн хэмжээ.....	16
Хүснэгт 6: Нас, хүйсийн квотод суурилсан түүвэр, Улаанбаатар хот, хороогоор.....	17
Хүснэгт 7: Нас, хүйсийн квотод суурилсан түүвэр, Хөдөө орон нутаг, сумаар.....	18
Хүснэгт 8: Чанарын судалгааны түүвэрлэлт.....	18
Хүснэгт 9: Хяналтын төрөл, хувиар.....	19
Хүснэгт 10: Улаанбаатар хотын судалгаанд оролцогчид, дүүргээр, n=501.....	21
Хүснэгт 11: Хөдөө орон нутгийн судалгаанд оролцогчид, сумаар, n=711.....	21
Хүснэгт 12: Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа, байршлаар, n=1212.....	22
Хүснэгт 13: Иргэдийн сонгуулийн оролцоо, идэвх, n=1212.....	26
Хүснэгт 14: Тойргоос сонгогдсон болон намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдал, байршлаар, n=1212.....	31
Хүснэгт 15: Иргэдийн ИТХ -ын талаарх мэдээлэл авахыг хүсдэг болон одоо мэдээлэл авч буй суваг, тэдгээрийн зөрүү, байршлаар, n=1212.....	36
Хүснэгт 16: Мэдээлэл авахыг хамгийн их хүсэж буй таван суваг, нас, хүйс, байршлаар, n=1212.....	37
Хүснэгт 17: ИТХ -ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдал, нас, хүйс, байршлаар n=1212.....	40
Хүснэгт 18: Аймаг/Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, нас, хүйс, байршлаар, n=1212.....	42
Хүснэгт 19: Аймаг/Нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, нас, хүйс, байршлаар, n=1212.....	43
Хүснэгт 20: Аймаг/нийслэлийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүд, байршлаар, n=1212.....	44
Хүснэгт 21: Аймаг/нийслэлийн ИТХ -аас гаргасан шийдвэрийг нэрлэх байдал, байршлаар, n=1212.....	45
Хүснэгт 22: Аймаг/Нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлэх байдал, нас, хүйс, байршлаар, n=1212.....	47
Хүснэгт 23: Дүүргийн ИТХ үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, дүүргээр, n=501.....	48
Хүснэгт 24: Сумын ИТХ үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, аймаг, сумаар, n=711.....	49
Хүснэгт 25: Дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, дүүргээр, n=501.....	49
Хүснэгт 26: Сумын ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, сумдаар, n=711.....	50

Хүснэгт 27: Сум/Дүүргийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлэсэн байдал, n=1212	52
Хүснэгт 28: Дүүргийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлэсэн байдал, дүүргээр, n=501	53
Хүснэгт 29: Сумын ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүд, n=711	55
Хүснэгт 30: Сум/дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлэх байдал, n=1212.....	57
Хүснэгт 31: Сумын ИТХ орон нутагт татвар тогтоох боломжтой байх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал, аймаг, сум, дүүргээр, n=1212	59
Хүснэгт 32: Иргэдийн оролцохыг хүсэж буй шийдвэр гаргах ажиллагаа, n=1212	61
Хүснэгт 33: Улаанбаатар хотын иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол 5 үйл ажиллагаа, дүүргээр, n=501	61
Хүснэгт 34: Сумын иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол 5 үйл ажиллагаа, дүүргээр, n=711	62
Хүснэгт 35: ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй хэлбэр, n=1212.....	62
Хүснэгт 36: Улаанбаатар хотын иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол таван хэлбэр, дүүргээр, n=501	63
Хүснэгт 37: Хөдөө орон нутгийн иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол таван хэлбэр, дүүргээр, n=711	64
Хүснэгт 38: ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй хэлбэрүүд, n=1212.....	64
Хүснэгт 39: ИТХ -ын хуралдаанд биечлэн оролцох сонирхол, n=1212	68
Хүснэгт 40: ИТХ -ын төсөв батлах үйл ажиллагаанд оролцсон байдал, n=1212	69
Хүснэгт 41: Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, хугацаа, n=1212.....	70
Хүснэгт 42: Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан хэлбэр, байршлаар, n=494	71
Хүснэгт 43: Сонгогдсон сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, байршлаар, n=1212	72
Хүснэгт 44: Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан хэлбэр, n=591	73
Хүснэгт 45: Дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан хэлбэр, дүүргээр, n=174.....	74
Хүснэгт 46:ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдсон арга зам, байршлаар, n=196	75
Хүснэгт 47: Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдөд өгсөн үнэлгээ, байршлаар, n=1212.....	83
Хүснэгт 48: Сумын ИТХ -ын төлөөлөгч нарыг үнэлэх байдал, аймгаар, n=711	84
Хүснэгт 49: Баг/хорооны ИНХ -д оролцож үзсэн байдал, байршлаар, n=1212	88
Хүснэгт 50: Баг/хорооны ИНХ -д оролцсон байдал, нас, хүйс, орлогоор, n=1212	89

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1: Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа, n=1212	22
График 2: Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хувиар, n=1212	22
График 3: Ажил эрхлэлтийн байдал, байршлаар, n=1212	23
График 4: Боловсролын түвшин, байршлаар, n=1212	24
График 5: Өрхийн сарын дундаж орлого, байршлаар, n=1212	24
График 6: Оршин суугаа хаяг дээрээ амьдарч буй хугацаа, байршлаар, n=1212	25
График 7: Сууцны төрөл, байршлаар, n=1212	25
График 8: 2016 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, n=288	28
График 9: 2016 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, насны бүлгээр, n=288	29
График 10: Ирэх 2020 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхгүй гэсэн шалтгаан, n=36	30
График 11: Одоогийн орон нутгийн сонгуулийн тогтолцооны талаарх үнэлгээ, n=1212	31
График 12: Тойргоос сонгогдсон болон намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдлын үнэлгээ, n=1212	31
График 13: ИТХ -ын талаарх ойлголтуудтай санал нийлэх байдал, n=1212	35
График 14: ИТХ -ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материал хүлээж авсан байдал, n=1212	39
График 15: ИТХ -ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материалтай уншиж танилцсан байдал, n=221	39
График 16: ИТХ -ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдал, n=1212	40
График 17: Аймаг/Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, байршлаар, n=1212	41
График 18: Аймаг/Нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, байршлаар, n=1212	43
График 19: Аймаг/Нийслэлийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандсан байдал, n=1212	46
График 20: Аймаг/Нийслэлийн ИТХ мэдээллээ ил тод өгсөн эсэх, n=79	46
График 21: Сум/Дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, байршлаар, n=1212	48
График 22: Дүүргийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандсан байдал, n=501	52
График 23: Сумын ИТХ орон нутагт татвар тогтоох боломжтой байх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал, n=1212	59
График 24: ИТХ -ын хуралдаанд биечлэн оролцох сонирхол, n=1212	68
График 25: ИТХ -ын төсөв батлах үйл ажиллагаанд оролцсон байдал, n=1212	68
График 26: Аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчийг нэрлэх байдал, n=1212	70
График 27: Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг нэрлэх байдал, n=1212	72
График 28: Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдсон байдал, n=1212	75



График 29: ИТХ -ын төлөөлөгчтэй уулзсан шалтгаан, байршлаар, n=196	77
График 30: Орон нутгийн ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдоход хүндрэлтэй байдал, байршлаар, n=196	78
График 31: ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон асуудал бүрэн шийдэгдэх байдал, байршлаар, n=196	79
График 32: Орон нутгийн хөгжил, дэд бүтэц зэрэгтэй холбоотой асуудал тулгарахад хандах байгууллага/албан тушаалтан, хувиар, n=1212.....	81
График 33: ИТХ -ын төлөөлөгчид тавих шалгуур, чухалчилж буй хүчин зүйлс, хувиар, n=1212	86
График 34: ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой эсэх, n=1212	87
График 35: ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой эсэх, хүйсээр, n=1212.....	87
График 36: Баг/хорооны ИНХ -д оролцоогүй шалтгаан, n=755.....	90
График 37: Баг/хорооны хурлын талаарх мэдээлэл авсан суваг, байршлаар, n=453	91
График 38: Баг/хорооны ИНХ -аар хэлэлцсэн асуудал, байршлаар, n=453	92
График 39: Баг/хорооны хурлын урилга авбал оролцох байдал, n=1212.....	92



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: SurveyToGo программ дээр судалгааны дата харагдах байдал	19
Зураг 2: SurveyToGo программ дээр ярилцлага нэг бүрийн харагдах байдал	20
Зураг 3: SurveyToGo программ дээр судлаачдын судалгаа авсан GPS байршлын харагдах байдал, Улаанбаатар хот.....	20
Зураг 4: SurveyToGo программ дээр судлаачдын судалгаа авсан GPS байршлын харагдах байдал, Хөдөө орон нутаг.....	20
Зураг 5: Дүүргийн социал группийн жишээ, ХУД.....	51

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
НӨУБ	Нутгийн Өөрөө Удирдах Байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГЯ	Гүнзгийрүүлсэн ярилцлага
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
АН	Ардчилсан Нам
МАН	Монгол Ардын Нам
ТББ	Төрийн Бус Байгууллага
МАА	Мал Аж Ахуй

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр хамтран сүүлийн 6 жилийн хугацаанд “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” /2012-2016/ болон “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” /2017-2020/ төслийг хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд дараах үндсэн дөрвөн үр дүнд хүрэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Нутгийн удирдлагын эрх зүйн орчныг сайжруулах
2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалтын чадавхыг сайжруулах
3. Орон нутгийн сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох
4. Сонгогдсон төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх УИХ -ын тамгын газрын чадавхыг сайжруулах

Тус хөтөлбөрийн хүрээнд “Нутгийн Өөрөө Удирдах Байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа” -г хоёр дах удаа хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны гол зорилго нь иргэд олон нийтийн ИТХ -ын талаарх ойлголт, мэдлэг, хандлага, оролцоог тодруулж, мэдээлэл авах байдлыг судалж цаашид иргэдийн оролцоог сайжруулах, шийдвэр гаргалтад оролцох, саналаа дэвшүүлэх идэвхийг нэмэгдүүлэх явдал юм.



ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Хүснэгт 1: Үр дүнгийн хураангуй

Гол үр дүнгүүд	2019 он		2015 он		Өөрчлөлт	
	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг
Өнгөрсөн УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгсөн	89.2%	87.1%	86.6%	90.7%	2.6%	-3.6%
Өнгөрсөн орон нутгийн сонгуульд (Сум, дүүргийн ИТХ) оролцож саналаа өгсөн	67.1%	82.0%	66.4%	83.1%	0.7%	-1.1%
Дараагийн орон нутгийн сонгуульд (Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ) оролцож саналаа өгөх	90.4%	90.9%	90.6%	92.0%	-0.2%	-1.1%
Одоогийн ОРОН НУТГИЙН сонгуулийн тогтолцоог оновчтой гэж үзэж буй	49.3%	46.6%	-	-	-	-
Тойргоос сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид ард иргэдийг төлөөлж чадна гэж үзэж буй	36.5%	35.7%	33.6%	46.0%	2.9%	-10.3%
Намын жагсаалтаар сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид ард иргэдийг төлөөлж чадна гэж үзэж буй	15.4%	27.3%	13.6%	18.3%	1.8%	9.0%
ИТХ -ын талаар ерөнхий ойлголттой иргэд	43.2%	51.8%	68.0%	29.0%	-24.8%	22.8%
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Орон даяар гардаг ТВ/	47.5%	16.5%	53.0%	18.6%	-5.5%	-2.1%
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Орон нутгийн ТВ/	20.0%	29.4%	7.2%	22.0%	12.8%	7.4%
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Сошиал суваг -facebook, twitter гэх мэт/**	30.5%	24.8%	-	-	-	-
ИТХ -ын талаар мэдээлэл авдаг суваг /Сонин, бусад хэвлэмэл материал/	17.2%	10.4%	10.8%	11.3%	6.4%	-0.9%
www.khural.mn веб сайтын талаар сонссон	20.2%	19.0%	23.2%	26.6%	-3.0%	-7.6%
Аймаг/нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзэж буй	41.7%	52.7%	40.8%	45.3%	0.9%	7.4%
Аймаг/нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлдэг гэж үзэж буй	45.3%	58.4%	48.4%	45.5%	-3.1%	12.9%
Аймаг/нийслэлийн ИТХ -аас гаргасан шийдвэрүүдийг нэрлэж чадаж буй*	50.5%	61.6%	34.0%	23.0%	16.5%	38.6%
Аймаг/нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагааг "маш сайн" болон "зарим талаараа сайн" гэж үнэлсэн	16.6%	24.3%	18.4%	27.3%	-1.8%	-3.0%
Сум/дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзэж буй	41.1%	66.2%	45.6%	57.6%	-4.5%	8.6%
Сум/дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлдэг гэж үзэж буй	41.7%	62.7%	36.0%	54.6%	5.7%	8.1%
Сум/дүүргийн ИТХ -аас гаргасан шийдвэрүүдийг нэрлэж чадаж буй*	48.1%	71.6%	19.0%	34.6%	29.1%	37.0%

Гол үр дүнгүүд	2019 он		2015 он		Өөрчлөлт	
	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг
Сум/дүүргийн ИТХ-ын үйл ажиллагааг "маш сайн" болон "зарим талаараа сайн" гэж үнэлсэн	19.8%	33.1%	18.8%	34.2%	1.0%	-1.1%
Өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчийг зөв нэрлэсэн	6.0%	24.0%	4.8%	23.7%	1.2%	0.3%
Өөрийн тойргоос сонгогдсон сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг зөв нэрлэсэн	8.0%	25.0%	6.4%	26.3%	1.6%	-1.3%
Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй ямар нэгэн зорилго/асуудлаар уулзаж байсан	7.8%	22.1%	14.0%	5.0%	-6.2%	17.1%
Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй уулзахад хүндрэлтэй байсан	61.5%	22.3%	20.8%	2.0%	40.7%	20.3%
Иргэдийн илэрхийлсэн хүсэлт, асуудал, санал гомдол үр дүнтэй шийдэгдсэн байдал	25.6%	28.7%	20.8%	48.5%	4.8%	-19.8%
Сум/дүүргийнхээ ИТХ-ын төлөөлөгчийг "маш сайн" болон "зарим талаараа сайн" гэж үнэлсэн	18.2%	30.0%	15.0%	32.7%	3.2%	-2.7%
Баг/хорооны ИНХ -д оролцож үзсэн	20.6%	49.2%	28.0%	56.7%	-7.4%	-7.5%
Өнгөрсөн жил баг/хорооны ИНХ -д оролцсон	20.2%	49.1%	28.0%	56.7%	-7.8%	-7.6%
Баг/хорооны хурлын урилга, мэдээлэл ирвэл оролцох хандлага	47.1%	63.2%	51.8%	70.0%	-4.7%	-6.8%

* Хариултын хувилбар санал болгосон

** Шинээр асуусан

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэгт Нутгийн Өөрөө Удирдах Байгууллагын талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, оролцоог торлуулах зорилгоор хийж гүйцэтгэсэн судалгааны аргачлал, хамрах хүрээ, түүвэрлэлтийн арга зүйн талаар авч үзэх болно.

1.1. Судалгааны аргачлал

Иргэдийн ойлголт, мэдлэг, оролцоог тодруулахын тулд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан иргэд олон нийт мөн түүнчлэн иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ын төлөөлөгч, засаг дарга нараас чанарын судалгааны аргаар гүнзгийрүүлсэн ярилцлага хийж гүйцэтгэлээ.

Тоон судалгаа

Тоон судалгааг нүүр тулсан ярилцлага (Face-to-face) -ын аргаар судалгааны онлайн платформ /SurveyToGo/ ашиглан батлагдсан асуулгын хүрээнд иргэд олон нийттэй ярилцлага хийж мэдээллийг цуглуулав.

Чанарын судалгаа

Батлагдсан ярилцлагын удирдамжийн дагуу зорилтот бүлгийн иргэд, ИТХ-ын төлөөлөгч, засаг дарга нартай дараах хоёр төрлийн ярилцлагыг хийж гүйцэтгэлээ.

- **Гүнзгийрүүлсэн ярилцлага /ГЯ/:** Судалгааны түүвэрт сонгогдсон сум, дүүрэг, баг, хорооны засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч нартай гүнзгийрүүлсэн ярилцлага хийж мэдээллийг боловсруулав. Тус ярилцлагаар албан хаагчдын асуудал бэрхшээл, иргэдийн хандлага, ойлголт, оролцоог тодруулав.
- **Фокус бүлгийн ярилцлага /ФБЯ/:** Сонгогдсон сум, дүүргийн иргэд олон нийтийн төлөөллөөс тодорхой шалгуур тавин ярилцлагад урьж, цаг товлон судалгааны зорилгын дагуу илүү нарийвчилсан ярилцлага хийж гүйцэтгэв. ФБЯ -ын хүрээнд иргэдийн ойлголт, хандлага, мэдлэг, оролцоог илүү нарийн судлав.

1.2. Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт

Судалгааны түүврийн дизайн

Судалгааны түүврийн хэмжээг Улаанбаатар хотын 30 хорооноос 500 өрх, хөдөө орон нутгийн 19 сумаас 700 өрх буюу нийт 1200 түүвэртэйгээр тооцож судалгааг авав.

2018 оны эцэст Монгол Улсын хүн ам 3,238,500, үүнээс 18 болон түүнээс насны хүн ам 2,104,500 гэж бүртгэгдсэн. Энэ нь нийт хүн амын 65 хувийг эзэлж байна. Статистикийн тооцооллын аргачлал дээр үндэслэн судалгааны түүврийн хэмжээг дараах байдлаар томъёолж байна. Үүнд, Z-Итгэх завсар (95%), e-алдааны түвшин 0.027 (2.7%) байхад n-нийт түүврийн хэмжээ 1199 байхаар тооцоологдож байна.

$$n = \frac{Z^2 P(1-P)}{e^2} \quad n = \frac{(1.96)^2 \times (0.65)(1-0.65)}{(0.027)^2}$$

$$n = \frac{0.8742}{0.000729} \quad n = 1199$$

Судалгааны түүврийн аргачлал

Судалгаанд хамрагдах сум, дүүргийг сонгохдоо *бүлэглэсэн түүвэрлэлтийн аргачлал (Stratum sampling)*-ыг ашиглав.

Сумдыг сонгосон байдал: Судалгааны түүвэрт сонгогдсон аймаг, сумыг сонгохдоо нэгдүгээрт бүс нутгийн төрөл, хоёрдугаарт 2016 оны сонгуулийн үр дүнд сонгогдсон олонхын саналыг авсан намын төрөл, гуравдугаарт хүн амын тоог шалгуур болгов.

Хүснэгт 2: Сумдыг сонгосон шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Ангилал		
Газар зүйн код	Бүс нутгийн код: Нэгдүгээр төвийн бүс (1), Хоёрдугаар төвийн бүс (2), Зүүн бүс (3), Баруун бүс (4)		
Олонхын саналыг авсан намын төрөл, 2016 оны сонгуулийн үр дүн	Намын код: (1) МАН- Монгол Ардын Нам, (2) АН -Ардчилсан Нам, (3) Эвсэл, (4) Бие даагч		
Сумдын хүн амын тоо, ангилал	Хүн амын тоо		Код
	1-1999		1
	2000-4999		2
	5000-8999		3
	9000 болон түүнээс дээш		4

Дээрх шалгуур үзүүлэлтүүдэд суурилан нийт 330 сум тус бүрийг стратумд хуваасан. Жишээлбэл, Өмнөговь аймгийн Даланзадгад сум нь “стратум 2/1/4” (Хоёрдугаар төвийн бүс/Олонх нам-АН/ 9000 -аас дээш хүн амтай) гэж кодлогдоно.

Дараа нь бүх сумдыг стратумын кодоор эрэмбэлэн байршуулж санамсаргүй байдлаар стратум тус бүрээс сумыг сонгоно. Түүвэрт нийт 6 аймгийн 19 сум сонгогдсон бөгөөд тус тоог **Нейманы хуваарилалтын аргын дагуу** тооцоолсон. Олон төрлийн ялгаатай шинж чанар бүхий бүлэглэсэн томоохон эх олонлогийн бүлэг тус бүрээс сонгогдох нэгжийн тоог Нейманы хуваарилалтын аргаар тодорхойлох нь илүү ач холбогдолтой байдаг. Энэхүү хуваарилалтын арга нь шинж чанарын хэлбэлзэл ихтэй буюу стандарт хазайлт ихтэй бүлгийн хувьд сонгогдох нэгжийн тоо олон, хэлбэлзэл багатай бүлгийн хувьд сонгогдох нэгжийн тоо харьцангуй цөөн байхаар хуваарилдаг.

Нейманы хуваарилалтын аргаар нийт орон нутгийн төлөөлөл болгож 700 өрхийг сонгосон. Нэг судалгаанд хамрагдсан өрх дунджаар 724 өрхийг, нэг судалгаанд хамрагдсан иргэн дунджаар 1600 иргэнийг төлөөлж байна.

Хүснэгт 3: Сонгогдсон сумдын түүврийн хэмжээ

Аймаг	Сум	Стратум код	Стратум дах өрхийн тоо	Стратум дах ХА -ын тоо	Стратум дах 18-аас дээш насны ХА -ын тоо	Эзлэх хувь	Түүврийн тоо (Пропорциональ аргаар)	Түүврийн тоо (Тэнцүү хуваарил алтын аргаар)	Түүврийн тоо (Нейманы хуваарил алтын аргаар)	Жин-01 (Өрхөөр)	Жин-02 (Хүн амын тоогоор)
Дундговь аймаг	Адаацаг сум	1/1/2	39700	127223	116998	7.3	51	37	44	902.273	2659.045
Дундговь аймаг	Сайнцагаан сум	1/1/4	110681	386209	149178	22.2	155	37	96	1152.927	1553.938
Дундговь аймаг	Өлзийт сум	1/2/2	13043	41370	38725	2.4	17	37	27	483.074	1434.259
Дундговь аймаг	Эрдэнэдалай сум	1/2/3	13443	45473	26578	2.6	18	37	27	497.889	984.370
Дундговь аймаг	Өндөршил сум	1/4/1	487	1421	969	0.1	1	37	20	24.350	48.450
Төв аймаг	Эрдэнэсант сум	1/3/2	9212	28266	39485	1.6	11	37	24	383.833	1645.208
Төв аймаг	Батсүмбэр сум	1/3/3	2115	7052	1449	0.4	3	37	20	105.750	72.450
Хөвсгөл аймаг	Арбулаг сум	2/1/2	47737	157013	104340	9.0	63	37	50	954.740	2086.800
Хөвсгөл аймаг	Мөрөн сум	2/1/4	69596	231585	113415	13.3	93	37	65	1070.708	1744.846
Хөвсгөл аймаг	Тосонцэнгэл сум	2/2/2	20119	66322	57420	3.8	27	37	32	628.719	1794.375
Хөвсгөл аймаг	Жаргалант сум	2/2/3	5206	19977	12349	1.1	8	37	22	236.636	561.318
Хэнтий аймаг	Баян-Адарга сум	3/1/2	17563	54984	46503	3.2	22	37	29	605.621	1603.552
Хэнтий аймаг	Хэрлэн сум	3/1/4	29005	96984	110315	5.6	39	37	38	763.289	2903.026
Хэнтий аймаг	Биндэр сум	3/2/2	13236	43461	26774	2.5	17	37	27	490.222	991.630
Хэнтий аймаг	Батноров сум	3/2/3	8188	27141	15351	1.6	11	37	24	341.167	639.625
Ховд аймаг	Мянгад сум	4/1/2	36885	139258	134179	8.0	56	37	46	801.848	2916.935
Ховд аймаг	Жаргалант сум	4/1/4	44492	177219	67917	10.2	71	37	54	823.926	1257.722
Завхан аймаг	Тэлмэн сум	4/2/2	16808	58252	36887	3.3	23	37	30	560.267	1229.567
Завхан аймаг	Улиастай сум	4/2/4	9527	32468	20840	1.9	13	37	25	381.080	833.600
Нийт			507043	1741678	1119672	100.0	700	700	700	724	1600

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо -2018

Улаанбаатар хотод хороодыг сонгосон байдал: Улаанбаатар хотын хороог сонгохдоо нэгдүгээрт хорооны байршлын төрөл, хоёрдугаарт 2016 оны сонгуулийн үр дүнд сонгогдсон олонхын саналыг авсан намын төрөл, гуравдугаарт хүн амын тоог шалгуур болгов.

Хүснэгт 4: Хороог сонгосон шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Ангилал		
Хорооны төрөл	Хорооны ангилал: Төвийн дүүргийн орон сууцтай хороо (1), төвийн дүүргийн гэр хороололтой хороо (2), Төвийн дүүргийн орон сууц болон гэр хороололтой хороо (3), Хотын захын дүүргийн орон сууцтай хороо (4), Хотын захын дүүргийн гэр хороололтой хороо (5) Хотын захын дүүргийн орон сууц болон гэр хороололтой хороо (6)		
Олонхын саналыг авсан намын төрөл, 2016 оны сонгуулийн үр дүн	Намын код: (1) МАН- Монгол Ардын Нам, (2) АН -Ардчилсан Нам, (3) Эвсэл, (4) Бие даагч		
Хүн амын тоо		Хүн амын тоо	Код
		1-4999	1
		5000-7999	2
		8000-9999	3
		10000-12999	4
		13000 болон түүнээс дээш	5

Дээрх шалгуур үзүүлэлтүүдэд суурилан 152 хороо тус бүрийг стратум болгон кодолсон. Жишээлбэл, Чингэлтэй дүүргийн 1-р хороо “Стратум 1/1/1” (Төвийн дүүргийн орон сууцтай хороо/Олонх нам-МАН/1-4999 хүн амтай) гэж кодлогдсон байна.

Хороодыг стратумын кодоор нь эрэмбэлж, дараагаар нь стратум тус бүрээс санамсаргүй байдлаар хороог сонгоно. Судалгаанд 9 дүүргийн 30 хороо сонгогдсон ба тус тоог Нейманы хуваарилалтын аргачлалаар тооцоолсон болно.

Нейманы хуваарилалтын аргаар Улаанбаатар хотын 500 өрхийг сонгосон. Нэг судалгаанд хамрагдсан өрх дунджаар 775 өрхийг, нэг судалгаанд хамрагдсан иргэн дунджаар 1882 иргэнийг төлөөлж байна.

Хүснэгт 5: Сонгогдсон хороодын түүврийн хэмжээ

Дүүрэг	Хороо	Стратум код	Стратум дах өрхийн тоо	Стратум дах ХА -ын тоо	Стратум дах 18-аас дээш насны ХА -ын тоо	Эзлэх хувь	Түүврийн тоо (Пропорциональ аргаар)	Түүврийн тоо (Тэнцүү хуваарилалтын аргаар)	Түүврийн тоо (Нейманы хуваарилалтын аргаар)	Жин-01 (Өрхөөр)	Жин-02 (Хүн амын тоогоор)
Багануур дүүрэг	3-хороо	1/3/2001	4937	16880	11188	1.2	6	17	11	448.818	1017.0909
Багахангай дүүрэг	1-хороо	4/1/2001	716	2403	1541	0.2	1	17	9	79.556	171.2222
Багахангай дүүрэг	2-хороо	6/1/2001	556	1996	1291	0.1	1	17	10	55.6	129.1
Баянгол дүүрэг	18-хороо	1/4/2002	19770	79747	52182	5.5	28	17	22	898.636	2371.9091
Баянгол дүүрэг	3-хороо	1/5/2002	41203	151909	97125	10.5	53	17	35	1177.229	2775
Баянгол дүүрэг	22-хороо	2/3/2002	14631	54061	35348	3.8	19	17	18	812.833	1963.7778
Баянзүрх дүүрэг	10-хороо	2/2/2002	12397	44650	29799	3.1	16	17	16	774.781	1862.4375
Баянзүрх дүүрэг	21-хороо	2/4/2002	25992	93164	60587	6.5	32	17	24	1083	2524.4583
Баянзүрх дүүрэг	12-хороо	2/5/2002	31850	112457	73637	7.8	39	17	28	1137.5	2629.8929
Налайх дүүрэг	2-хороо	4/2/2001	2559	7475	5697	0.5	3	17	10	255.9	569.7
Налайх дүүрэг	6-хороо	5/1/2001	3058	8008	6401	0.6	3	17	10	305.8	640.1
Налайх дүүрэг	1-хороо	5/2/2001	4989	17410	11918	1.2	6	17	11	453.545	1083.4545
Сонгинохайрхан дүүрэг	15-хороо	1/2/2001	9385	37188	24597	2.6	13	17	15	625.633	1639.7667
Сонгинохайрхан дүүрэг	30-хороо	2/2/2001	13411	50508	33503	3.5	18	17	17	788.882	1970.7647
Сонгинохайрхан дүүрэг	31-хороо	2/4/2001	15648	59217	38654	4.1	21	17	19	823.579	2034.3947
Сонгинохайрхан дүүрэг	22-хороо	2/5/2001	23846	87084	55151	6	30	17	23	1036.761	2397.8478
Сүхбаатар дүүрэг	2-хороо	1/1/2002	6608	25377	17290	1.8	9	17	13	508.308	1330
Сүхбаатар дүүрэг	6-хороо	1/2/2002	8281	33128	22102	2.3	12	17	14	591.5	1578.7143
Сүхбаатар дүүрэг	1-хороо	1/3/2002	18138	69757	46428	4.8	24	17	20	906.9	2321.4
Сүхбаатар дүүрэг	19-хороо	2/1/2002	2547	6924	4915	0.5	2	17	9	283	546.1111
Сүхбаатар дүүрэг	12-хороо	2/2/2002	12397	44650	29799	3.1	16	17	16	774.781	1862.4375
Хан-Уул дүүрэг	1-хороо	1/4/2001	8134	31986	20895	2.2	11	17	14	581	1492.5
Хан-Уул дүүрэг	11-хороо	1/5/2001	20252	77750	48268	5.4	27	17	22	920.545	2194
Хан-Уул дүүрэг	16-хороо	2/4/2001	15648	59217	38654	4.1	21	17	19	823.579	2034.3947
Чингэлтэй дүүрэг	2-хороо	1/1/2001	3011	12495	8228	0.9	4	17	10	301.1	822.8
Чингэлтэй дүүрэг	4-хороо	1/2/2001	9385	37188	24597	2.6	13	17	15	625.633	1639.7667
Чингэлтэй дүүрэг	8-хороо	2/1/2001	5479	17262	11709	1.2	6	17	11	498.091	1064.4545
Чингэлтэй дүүрэг	14-хороо	2/2/2001	13411	50508	33503	3.5	18	17	17	788.882	1970.7647
Чингэлтэй дүүрэг	15-хороо	2/3/2001	15371	62473	41043	4.3	22	17	19	809	2160.1579
Чингэлтэй дүүрэг	17-хороо	2/5/2001	23846	87084	55151	6	30	17	23	1036.761	2397.8478
Нийт			387453	1439954	941198	100.0	500	500	500	775	1882

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо -2018

Тоон судалгаанд оролцогчдыг сонгосон байдал

Тоон судалгаанд оролцогчийг сонгохдоо сонгогдсон баг, хорооны хүн амын нас, хүйсийн квотод суурилсан гудамжинд санамсаргүй зогсоох (Street Intercept) аргачлалыг ашиглав. Нас, хүйсийн квотыг тооцоолохдоо сонгогдсон баг, хорооны 2018 оны эцсийн байдлаар албан ёсоор бүртгэлтэй хүн амын нас, хүйсийн бүтцэд суурилан түүврийн хэмжээг тооцоолсон болно.

Хүснэгт 6: Нас, хүйсийн квотод суурилсан түүвэр, Улаанбаатар хот, хороогоор

Дүүрэг	Хороо	Хүйс		Насны бүлэг					Нийт
		Эрэгтэй	Эмэгтэй	18-24	25-34	35-44	45-54	55-64	
Багануур дүүрэг	3-р хороо	7	6	2	2	2	4	3	13
Багахангай дүүрэг	1-р хороо	4	4	1	2	2	2	1	8
	2-р хороо	5	6	2	3	2	3	1	11
Баянгол дүүрэг	3-р хороо	18	18	5	12	10	6	3	36
	18-р хороо	11	11	2	8	6	4	2	22
	22-р хороо	9	9	2	4	5	2	5	18
Баянзүрх дүүрэг	10-р хороо	8	8	2	6	4	2	2	16
	12-р хороо	10	9	2	8	4	2	3	19
	21-р хороо	12	12	4	7	7	4	2	24
Налайх дүүрэг	1-р хороо	6	5	2	3	2	2	2	11
	2-р хороо	6	5	2	3	2	2	2	11
	6-р хороо	5	5	1	2	3	2	2	10
Сонгинохайрхан дүүрэг	15-р хороо	8	7	2	4	5	2	2	15
	22-р хороо	11	13	2	8	7	5	2	24
	30-р хороо	10	8	2	6	4	4	2	18
	31-р хороо	9	10	2	6	4	3	4	19
Сүхбаатар дүүрэг	1-р хороо	10	10	3	4	7	4	2	20
	2-р хороо	7	6	3	2	3	3	2	13
	6-р хороо	7	7	2	4	4	2	2	14
	12-р хороо	9	8	2	5	4	4	2	17
	19-р хороо	4	5	0	1	2	3	3	9
Хан-Уул дүүрэг	1-р хороо	7	7	1	3	5	3	2	14
	11-р хороо	12	12	1	6	7	3	7	24
	16-р хороо	9	10	2	9	4	2	2	19
Чингэлтэй дүүрэг	2-р хороо	5	5	2	2	2	2	2	10
	4-р хороо	7	8	1	5	3	2	4	15
	8-р хороо	5	6	2	3	2	2	2	11
	14-р хороо	10	8	2	6	4	2	4	18
	15-р хороо	10	9	1	6	5	5	2	19
	17-р хороо	12	11	2	8	6	5	2	23
	Нийт	253	248	59	148	127	91	76	501

Хүснэгт 7: Нас, хүйсийн квотод суурилсан түүвэр, Хөдөө орон нутаг, сумаар

Аймаг	Сум	Хүйс		Насны бүлэг					Нийт
		Эрэгтэй	Эмэгтэй	18-24	25-34	35-44	45-54	55-64	
Дундговь аймаг	Адаацаг сум	22	22	10	9	10	8	7	44
	Сайнцагаан сум	48	48	18	28	20	18	12	96
	Өлзийт сум	14	13	5	6	7	4	5	27
	Эрдэнэдалай сум	13	15	7	7	6	4	4	28
	Өндөршил сум	10	11	4	6	4	3	4	21
Завхан аймаг	Тэлмэн сум	15	15	5	7	7	8	3	30
	Улиастай сум	14	12	3	6	7	6	4	26
Төв аймаг	Батсүмбэр сум	10	12	3	6	6	5	2	22
	Эрдэнэсант сум	13	12	2	7	7	5	4	25
Ховд аймаг	Мянгад сум	23	25	8	13	14	9	4	48
	Жаргалант сум	27	26	9	15	12	11	6	53
Хөвсгөл аймаг	Арбулаг сум	25	25	9	17	10	8	6	50
	Мөрөн сум	32	34	11	18	15	13	9	66
	Тосонцэнгэл сум	15	17	6	7	8	7	4	32
	Жаргалант сум	11	12	5	7	5	4	2	23
	Батноров сум	12	12	4	7	7	4	2	24
Хэнтий аймаг	Баян-Адарга сум	14	16	6	6	6	7	5	30
	Биндэр сум	13	14	5	7	6	5	4	27
	Хэрлэн сум	19	20	8	13	8	6	4	39
Нийт		350	361	128	192	165	135	91	711

Чанарын судалгааны түүвэрлэлт

ФБЯ -ыг дараах байршлуудад зохион байгуулав. Тус байршлуудыг сонгохдоо хүн амын тоо, бүс нутаг, олонхын саналыг авсан намын төрөл зэргийг шалгуур үзүүлэлт болголоо.

Хүснэгт 8: Чанарын судалгааны түүвэрлэлт

Байршил			ФБЯ -ын тоо	ФБЯ -д оролцогчийн тоо	Нийт оролцогчдын тоо
Нийслэл хотын түвшинд:					
Улаанбаатар хот			2	8	16
Аймгийн түвшинд:					
Аймаг	Сум	Нам	2	8	16
Завхан аймаг	Улиастай сум	АН			
Хэнтий аймаг	Хэрлэн сум	МАН			
Сумын түвшинд					
Аймаг	Сум	Нам	4	8	32
Ховд аймаг	Мянгад сум	МАН			
Хөвсгөл аймаг	Тосонцэнгэл сум	АН			
Төв аймаг	Эрдэнэсант сум	Эвсэл			
Дундговь аймаг	Өндөршил сум	Бие даагч			
Нийт			8	-	64

1.3. Судалгааны хяналтын процесс

Мэдээлэл цуглуулалтыг онлайнд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулалтын программ болох SurveyToGo программыг ашиглаж хийсэн. Тус программын давуу талыг дурдвал:

- Судалгааны ярилцлага хийгдэж дууссан даруй төв серверт үр дүн ирдэг
- Автомат дуу хураагууртай
- GPS байршил хянагчтай
- Асуулгыг программчилж, шилжилт, үсрэлтийг кодолж өгдөг
- Түүврийн квотыг тогтмол харах боломжтой
- Хөдөө орон нутагт ашиглах боломжтой

Энэхүү мэдээлэл цуглуулалтын программыг android үйлдлийн системтэй таблет дээр ашиглах бөгөөд мэдээлэл цуглуулалтын алдааг хамгийн бага байлгах, хяналтыг дор бүр нь хийх боломжийг олгодог юм.


Судалгааны хяналтыг утсаар эргэж холбогдон, зарим мэдээллийг тулгаж асуух, дуу хураагуур сонсож мэдээллийг тулгах, асуултаа зөв асууж буй эсэхийг шалгах, GPS байршлыг судлаач бүрээр хянах гэсэн үндсэн гурван хэлбэрээр хийсэн.

Хүснэгт 9: Хяналтын төрөл, хувиар

Хяналтын төрөл	Хувь	Тоо
Утсаар эргэж холбогдон, зарим мэдээллийг тулгаж асуух	Санамсаргүй түүврээр 60%	727
Дуу хураагуур сонсох	Эхний 40%	485
GPS байршлыг судлаач бүрээр хянах	Эхний 40%	485
Нийт	100%	1212

Мэдээлэл цуглуулалтын хяналтаар нийт 3 ажилтан ажилласан бөгөөд хяналтын үр дүнд нийт судалгааны 2 хувь буюу 24 судалгааг хүчингүй болгож нөхөж авхуулсан. Судалгааг хүчингүй болгосон шалтгаан нь түр оршин суугч, албан ёсоор бүртгэлгүй оршин суугч, утсаар эргэж холбогдон зарим мэдээллийг тулгаж асуусан асуултад буруу хариулсан зэрэг шалтгаан орно. Алдаа гаргасан судлаач нарт тухай бүр алдааг сануулж, анхааруулга өгөн, дахин алдаа гаргахгүй байх чиг үүрэг өгч, шаардлагатай тохиолдолд дахин сургалтад хамруулах, гэрээг цуцлах зэрэг арга хэмжээг авч ажиллав.


Зураг 1: SurveyToGo программ дээр судалгааны дата харагдах байдал




Зураг 2: SurveyToGo программ дээр ярилцлага нэг бүрийн харагдах байдал

The screenshot shows the 'Requires Approval' interface in SurveyToGo. At the top, there's a navigation bar with tabs: Main, Auto Interview Flagging, Silent Recordings, Custom Variables, Survey Details, and Advanced. The 'Main' tab is active. Below the navigation bar, there's a summary section with fields for Status (Requires Approval), Start (12/2/2019 5:50:30 PM), End (12/2/2019 6:05:58 PM), Net Duration (00:00:15:29), and Location. A 'Question Duration Histogram' is visible on the right. Below this, there's a 'Data' section with tabs: Map, Attachments, Subject Quota, Quality Control Score, Interview Discussion, Scores, and History. The 'Map' tab is active, showing a list of questions and answers. The questions are numbered 1 through 9, and the answers are provided in Mongolian. At the bottom, there's a 'Change status to:' dropdown menu set to 'Requires Approval', a 'Comment:' field, and a 'Display Language:' dropdown menu. There are also buttons for 'Print', 'OK', and 'Cancel'.

Зураг 3: SurveyToGo программ дээр судлаачдын судалгаа авсан GPS байршлын харагдах байдал, Улаанбаатар хот



Зураг 4: SurveyToGo программ дээр судлаачдын судалгаа авсан GPS байршлын харагдах байдал, Хөдөө орон нутаг



БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэгт судалгааны нэгдсэн үр дүнг бүлэг тус бүрээр ангилан анализ хийв. Иргэдийн мэдлэг хандлага ойлголтыг нарийн ойлгох үүднээс тоон үр дүнг нас, хүйс, хот, хөдөө орон нутгаар харьцуулан харахаас гадна гол үр дүнгүүдийг 2015 онд хийгдсэн “НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХАНДЛАГЫН СУУРЬ ТҮВШИН ТОГТООХ СУДАЛГАА”-ны үр дүнтэй харьцууллаа.

Нийт судалгаанд оролцогчдын хувьд оршин суугаа хаяг дээрээ 6 болон түүнээс дээш сар амьдарч байгаа, мөн тухайн хаяг дээрээ албан ёсны бүртгэлтэй байх ёстой гэсэн шалгуур тавьсан байгаа.

2.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 30 хорооноос 501 иргэн, хөдөө орон нутгийн 6 аймгийн 19 сумын 711 иргэн хамрагдсан.

Хүснэгт 10: Улаанбаатар хотын судалгаанд оролцогчид, дүүргээр, n=501

	Тоо	Хувь
Багануур дүүрэг	13	2.6
Багахангай дүүрэг	19	3.8
Баянгол дүүрэг	76	15.2
Баянзүрх дүүрэг	59	11.8
Налайх дүүрэг	32	6.4
Сонгинохайрхан дүүрэг	76	15.2
Сүхбаатар дүүрэг	73	14.6
Хан-Уул дүүрэг	57	11.4
Чингэлтэй дүүрэг	96	19.2
Нийт	501	100.0


Хөдөө орон нутгаас судалгаанд оролцогчдын тоог дараах хүснэгтэд дүрслэв.

Хүснэгт 11: Хөдөө орон нутгийн судалгаанд оролцогчид, сумаар, n=711

Аймаг	Сум	Тоо	Хувь
Дундговь аймаг	Адаацаг сум	44	6.2%
	Сайнцагаан сум	96	13.5%
	Өлзийт сум	27	3.8%
	Эрдэнэдалай сум	28	3.9%
	Өндөршил сум	21	3.0%
Завхан аймаг	Тэлмэн сум	30	4.2%
	Улиастай сум	26	3.7%
Төв аймаг	Батсүмбэр сум	22	3.1%
	Эрдэнэсант сум	25	3.5%
Ховд аймаг	Мянгад сум	48	6.8%
	Жаргалант сум	53	7.5%
Хөвсгөл аймаг	Арбулаг сум	50	7.0%
	Мөрөн сум	66	9.3%
	Тосонцэнгэл сум	32	4.5%
	Жаргалант сум	23	3.2%
Хэнтий аймаг	Батноров сум	24	3.4%
	Баян-Адарга сум	30	4.2%
	Биндэр сум	27	3.8%
	Хэрлэн сум	39	5.5%
Нийт		711	100.0%


Судалгаанд оролцогчдын 49.8 хувь нь эрэгтэй, 50.2 хувь нь эмэгтэй оролцогчид эзэлж байна.

График 1: Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа, n=1212



Судалгаанд оролцогчдын насны бүлгийн хувьд 25-34 насны бүлэг хамгийн өндөр хувь буюу 28 хувийг, 55-64 насны бүлэг хамгийн бага хувь буюу 14 хувийг эзэлж байна.

График 2: Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хувиар, n=1212



Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцааг хот, хөдөө орон нутгаар задлан дараах хүснэгтэд дүрслэв. Нийт судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцааг Үндэсний Статистикийн Хорооны 2018 оны эцсийн тоо бүртгэлд үндэслэн квот тогтоон судалгаанд оролцогчдыг сонгосон тул нийт эх олонлогийг бүрэн төлөөлж чадна.


Хүснэгт 12: Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа, байршлаар, n=1212

	Улаанбаатар хот		Хөдөө орон нутаг		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хүйс:						
Эрэгтэй	253	50.5%	350	49.2%	603	49.8%
Эмэгтэй	248	49.5%	361	50.8%	609	50.2%
Нийт	501	100.0%	711	100.0%	1212	100.0%

	Улаанбаатар хот		Хөдөө орон нутаг		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Насны бүлэг:						
18-24	59	11.8%	128	18.0%	187	15.4%
25-34	148	29.5%	192	27.0%	340	28.1%
35-44	127	25.3%	165	23.2%	292	24.1%
45-54	91	18.2%	135	19.0%	226	18.6%
55-64	76	15.2%	91	12.8%	167	13.8%
Нийт	501	100.0%	711	100.0%	1212	100.0%


Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт, нийгмийн байдал дараах бүтэцтэй байна. Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 28.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 22.4 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 13.2 хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажиллаж байна. Хөдөө орон нутгийн судалгаанд оролцогчдын 23.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 20.4 хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг, 18.6 хувь нь малчин байна.

График 3: Ажил эрхлэлтийн байдал, байршлаар, n=1212




Судалгаанд оролцогчдын боловсролын түвшнийг тодруулахад Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 40.1 хувь нь бүрэн дунд боловсролтой, 35.7 хувь нь бакалаврын болон дипломын боловсролтой. Хөдөө орон нутгийн судалгаанд оролцогчдын 48.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 22.5 хувь нь бакалаврын болон дипломын боловсролтой байна.

График 4: Боловсролын түвшин, байршлаар, n=1212




Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлогыг тодруулбал дараах бүтэцтэй байна.

График 5: Өрхийн сарын дундаж орлого, байршлаар, n=1212




Судалгаанд оролцогчдын тухайн хаяг дээрээ хэдэн жил амьдарч байгааг тодруулбал 11 болон түүнээс дээш жил амьдарч байгаа гэсэн хувь хамгийн өндөр байна.

График 6: Орийн суугаа хаяг дээрээ амьдарч буй хугацаа, байршилаар, n=1212



Судалгаанд оролцогчдын сууцны төрлийн хувьд Улаанбаатар хотод орон сууцны өрх хамрагдсан хувь хамгийн өндөр буюу 45.3 хувь, монгол гэрт амьдардаг 24.6 хувь, сууцны тусдаа байшинд амьдардаг 21.4 хувь байна. Хөдөө орон нутгийн хувьд монгол гэрт 49.6 хувь, сууцны тусдаа байшинд 36.4 хувь, орон сууцанд 7.5 хувь амьдардаг байна. Монгол улсын 2010 оны орон сууц болон гэрт амьдардаг өрхийн бүртгэлд улсын хэмжээнд 45 хувь нь гэрт, 54 хувь нь байшин, орон сууцанд амьдардаг, Улаанбаатар хотын хэмжээнд 29 хувь нь гэрт, 70 хувь нь байшин, орон сууцанд амьдардаг гэж бүртгэгдсэн байна.

График 7: Сууцны төрөл, байршилаар, n=1212



2.2. Иргэдийн сонгуулийн идэвх болон сонгуулийн тогтолцооны талаарх санаа бодол

Энэ бүлэгт иргэдийн УИХ болон орон нутгийн сонгуульд оролцсон байдал, сонгуульдаа оролцоогүй бол түүний шалтгаан, сонгуулийн тогтолцооны талаарх ойлголт, санаа бодол зэргийг тодруулсан.

2.2.1. Иргэдийн сонгуулийн идэвх, оролцоо

Нийт судалгаанд оролцогчдын 88 хувь, Улаанбаатар хотын 89.2 хувь, хөдөө орон нутгийн 87.1 хувь нь 2016 оны УИХ -ын сонгуульд оролцож саналаа өгсөн гэж хариулжээ. Монгол улсын СЕХ-ны дүнгээр УИХ -ын сонгуулийн санал өгсөн хувь 73.58 хувьтай байна. Үүнээс харахад иргэд олон нийтийн сонгуульд оролцсон гэж хариулах хандлага өндөр байна. Нийт судалгаанд оролцогчдын 75.8 хувь, Улаанбаатар хотын 67.1 хувь, хөдөө орон нутгийн 82.0 хувь орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгсөн байна. Үүнээс харахад нийт дүнгээр орон нутгийн сонгуульд оролцох байдал УИХ -ын сонгуульд оролцсон байдлаас бага байна. Хөдөө орон нутгийн иргэдийн оролцооны түвшин Улаанбаатар хотын иргэдийн оролцооны түвшинтэй харьцуулахад 15 хувиар өндөр байна.

Өмнөх 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, УИХ -ын сонгуульд оролцсон байдал Улаанбаатар хотод 2.6 хувиар өсөж, хөдөө орон нутагт 3.6 хувиар буурсан байна. Орон нутгийн сонгуульд оролцсон байдлыг харьцуулбал, Улаанбаатар хотод 0.7 хувиар өсөж, хөдөө орон нутагт 1.1 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл, **хөдөө орон нутагт сонгуульд оролцох байдал буурсан дүр зураг ажиглагдаж байна.**

Ирэх 2020 оны орон нутгийн сонгуульд оролцох байдлыг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 90.7 хувь, Улаанбаатар хотын 90.4 хувь, хөдөө орон нутгийн 90.9 хувь нь оролцож саналаа өгнө хэмээн хариулсан байна. Одоогоор хэлж мэдэхгүй байна гэж нийт оролцогчдын 6.4 хувь нь хариулсан байна. Энэхүү үр дүнг 2015 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, дараа оны сонгуульд оролцоно гэж хариулсан хувь Улаанбаатар хотод 0.2 хувиар, хөдөө орон нутагт 1.1 хувиар тус тус буурчээ.

Сонгуулийн оролцооны байдлыг нас, хүйсээр задлан харвал 2016 оны УИХ -ын сонгуульд 55-64 насны бүлэг хамгийн өндөр буюу 95.2 хувьтай оролцсон байхад 18-24 насны бүлгийн 56.1 хувь буюу хамгийн бага хувьтай оролцсон байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүдийн оролцсон байдал илүү өндөр байна. 2016 оны орон нутгийн сонгуульд оролцсон байдлыг насны бүлгээр харвал мөн адил 55-64 насны бүлэг хамгийн өндөр хувьтай оролцсон байна. 18-24 насны бүлгийн 42.8 хувь нь орон нутгийн сонгуульд оролцжээ. Хүйсээр задлан харвал мөн адил эмэгтэйчүүдийн оролцсон хувь илүү өндөр байна.

2020 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөх байдлыг тодруулахад 18-24 насны бүлгийн оролцоно гэж хариулсан хувь хамгийн өндөр буюу 92.0 хувь байна. Тус насны бүлгийн оролцохгүй гэж хариулсан хувь бусад насны бүлгээс хамгийн өндөр буюу 4.3 хувь байна.


Хүснэгт 13: Иргэдийн сонгуулийн оролцоо, идэвх, n=1212

Сонгуулийн оролцооны байдал	2016 оны УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгсөн байдал			2016 оны орон нутаг (Сум, дүүргийн ИТХ)-ийн сонгуульд оролцож саналаа өгсөн байдал			2020 оны орон нутаг (Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ)-ийн сонгуульд оролцож саналаа өгөх байдал		
	Тийм	Үгүй	Хариулахаас татгалзсан	Тийм	Үгүй	Хариулахаас татгалзсан	Тийм	Үгүй	Одоогоор мэдэхгүй байна
Улаанбаатар хот	89.2%	10.6%	0.2%	67.1%	32.5%	0.4%	90.4%	3.4%	6.2%
Хөдөө орон нутаг	87.1%	12.9%	-	82.0%	17.6%	0.4%	90.9%	2.7%	6.5%
Дүүргээр:									
Багануур	69.2%	30.8%	-	61.5%	38.5%	-	76.9%	-	23.1%

Сонгуулийн оролцооны байдал	2016 оны УИХ-ын сонгуульд оролцож саналаа өгсөн байдал			2016 оны орон нутаг (Сум, дүүргийн ИТХ)-ийн сонгуульд оролцож саналаа өгсөн байдал			2020 оны орон нутаг (Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ)- ийн сонгуульд оролцож саналаа өгөх байдал		
	Тийм	Үгүй	Хариула хаас татгалзс ан	Тийм	Үгүй	Хариула хаас татгалзс ан	Тийм	Үгүй	Одоогоо р мэдэхгүй байна
Багахангай	84.2%	15.8%	-	78.9%	21.1%	-	78.9%	10.5%	10.5%
Баянгол	85.5%	14.5%	-	61.8%	35.5%	2.6%	88.2%	3.9%	7.9%
Баянзүрх	96.6%	3.4%	-	74.6%	25.4%	-	91.5%	1.7%	6.8%
Налайх	84.4%	15.6%	-	71.9%	28.1%	-	90.6%	6.3%	3.1%
Сонгинохайрхан	88.2%	11.8%	-	69.7%	30.3%	-	94.7%	1.3%	3.9%
Сүхбаатар	87.7%	11.0%	1.4%	61.6%	38.4%	-	91.8%	2.7%	5.5%
Хан-Уул	93.0%	7.0%	-	64.9%	35.1%	-	89.5%	3.5%	7.0%
Чингэлтэй	92.7%	7.3%	-	66.7%	33.3%	-	91.7%	4.2%	4.2%
Аймгаар:									
Дундговь аймаг	86.1%	13.9%	-	81.5%	18.5%	-	92.6%	3.2%	4.2%
Завхан аймаг	89.3%	10.7%	-	89.3%	10.7%	-	96.4%	-	3.6%
Төв аймаг	91.5%	8.5%	-	93.6%	6.4%	-	93.6%	2.1%	4.3%
Ховд аймаг	87.1%	12.9%	-	78.2%	20.8%	1.0%	87.1%	4.0%	8.9%
Хөвсгөл аймаг	87.7%	12.3%	-	80.1%	18.7%	1.2%	88.3%	2.3%	9.4%
Хэнтий аймаг	85.0%	15.0%	-	80.8%	19.2%	-	90.8%	2.5%	6.7%
Насны бүлэг:									
18-24	56.1%	43.9%	-	42.8%	56.7%	0.5%	92.0%	4.3%	3.7%
25-34	92.1%	7.9%	-	75.9%	23.5%	0.6%	90.0%	3.8%	6.2%
35-44	93.8%	6.2%	-	80.5%	18.8%	0.7%	91.4%	1.4%	7.2%
45-54	95.1%	4.4%	0.4%	87.2%	12.8%	-	90.7%	2.2%	7.1%
55-64	95.2%	4.8%	-	89.2%	10.8%	-	89.2%	3.6%	7.2%
Хүйс:									
Эрэгтэй	86.9%	13.1%	-	72.6%	26.9%	0.5%	90.4%	2.5%	7.1%
Эмэгтэй	89.0%	10.8%	0.2%	79.0%	20.7%	0.3%	91.0%	3.4%	5.6%
Нийт	88.0%	12.0%	0.1%	75.8%	23.8%	0.4%	90.7%	3.0%	6.4%


2016 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөөгүй оролцогчдоос шалтгааныг тодруулахад 19 хувь нь сонгууль өгөх насанд хүрээгүй байсан, 18 хувь нь завгүй байсан, 10 хувь нь шалтгаанаа мэдэхгүй, санахгүй, 10 хувь нь сонгуулийн талаарх мэдээлэл хангалтгүй байсан, 9 хувь нь нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэл байхгүй байсан зэрэг гол 5 шалтгааныг дурдсан байна.

График 8: 2016 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, n=288




2016 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгааныг насны бүлгээр задлан харвал дараах бүтэцтэй байна. 18-24 насны бүлгийн сонгуульд оролцоогүй хамгийн том шалтгаан нь сонгууль өгөх насанд хүрээгүй байсан, 25-34 насны сонгуульд оролцоогүй гол шалтгаан нь завгүй байсан, 35-44 насны бүлгийн хувьд завгүй байсан, мэдэхгүй/санахгүй байна, нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэл байхгүй байсан, 45-54 насны бүлгийн хувьд өөр газар байсан (хот, хөдөө), 55-64 насны хувьд завгүй байсан, сонгуулийн талаарх мэдээлэл хангалтгүй байсан зэрэг шалтгаан зонхилж байна.

График 9: 2016 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөөгүй шалтгаан, насны бүлгээр, n=288



Ирэх 2020 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхгүй гэсэн оролцогчдын шалтгааныг тодруулбал, 36 хувь нь сонгогдсон хүмүүс нь амлалтаа биелүүлдэггүй, 31 хувь нь аль ч намын төлөөлөгч гарсан ялгаа байхгүй, 25 хувь нь орон нутгийн сонгууль шударга бус явагддаг, 19 хувь нь улс төрөөс залхсан, 19 хувь нь ач холбогдол өгдөггүй, анхаарал хандуулдаггүй, 19 хувь нь нөгөө л хуучин, улиг болсон хүмүүс нь дэвшсэн байдаг зэрэг шалтгааныг дурдсан байна.


График 10: Ирэх 2020 оны орон нутгийн сонгуульд оролцож саналаа өгөхгүй гэсэн шалтгаан, n=36



2.2.2. Одоогийн орон нутгийн сонгуулийн тогтолцооны талаарх үнэлгээ


Судалгаанд оролцогчдоос одоогийн орон нутгийн сонгуулийн тогтолцоо оновчтой эсэх, тойргоос сонгогдсон болон намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдал зэргийг үнэлүүлэв. Үнэлгээнээс харахад одоогийн орон нутгийн сонгуулийн тогтолцоог оновчтой гэж 27 хувь нь, зарим талаар оновчтой гэж 21 хувь нь үзсэн байна. **Ерөнхий дүр зургаар нь харвал одоогийн ОРОН НУТГИЙН сонгуулийн тогтолцоо оновчтой гэж үзэх хандлага өндөр байна.**

График 11: Одоогийн орон нутгийн сонгуулийн тогтолцооны талаарх үнэлгээ, n=1212



Тойргоос сонгогдсон болон намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдлыг үнэлэхэд тойргоос сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдал илүү сайн гэж үнэлсэн байна. **Намын жагсаалтаар сонгогдсон төлөөлөгчид иргэдийг төлөөлж огт чадахгүй гэж нийт судалгаанд оролцогчдын 33 хувь үзсэн байна.** Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 7 хувиар буурсан үзүүлэлт юм.

График 12: Тойргоос сонгогдсон болон намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдлын үнэлгээ, n=1212



Хүснэгт 14: Тойргоос сонгогдсон болон намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийн иргэдийг төлөөлөх байдал, байрилаар, n=1212

	Маш сайн төлөөлж чадна	Зарим талаар төлөөлж чадна	Дунд зэрэг төлөөлж чадна	Зарим талаар төлөөлж чадахгүй	Огт төлөөлж чадахгүй	Мэдэхгүй	Нийт
Тойргоос сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчид							
Улаанбаатар хот	15.4%	21.2%	19.6%	10.2%	19.2%	14.6%	100.0%
Хөдөө орон нутаг	17.0%	18.7%	26.2%	8.9%	17.0%	12.2%	100.0%
Нийт	16.3%	19.7%	23.4%	9.4%	17.9%	13.2%	100.0%
Намын жагсаалтаар сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчид							
Улаанбаатар хот	6.2%	9.2%	16.0%	10.4%	40.7%	17.6%	100.0%
Хөдөө орон нутаг	11.0%	16.3%	21.2%	9.0%	26.9%	15.6%	100.0%
Нийт	9.0%	13.4%	19.1%	9.6%	32.6%	16.4%	100.0%

2.3. ИТХ -ын талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээ

Энэ бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллага болох ИТХ, түүний чиг үүргийн талаарх иргэдийн ойлголт, үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой мэдээллийг авдаг эх сурвалж, хэвлэмэл тайлан материалтай танилцсан байдал, аймаг/нийслэл болон сум/дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлэх байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох байдал, ИТХ -ын төлөөлөгч нарын талаарх ойлголт, баг/хорооны ИТХ -ын талаарх ойлголт, мэдлэг, оролцоо зэргийг тодруулах болно.

2.3.1. ИТХ -ын талаарх нийтлэг ойлголт

Судалгаанд оролцогчдоос ИТХ -ын талаар ямар ойлголттой байдаг талаар тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн 56.8 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 48.2 хувь нь ямар нэгэн ойлголтгүй гэж хариулсан байна. Өмнөх суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад ИТХ -ын талаарх ойлголттой иргэдийн хувь Улаанбаатар хотод 24.8 хувиар буурч, хөдөө орон нутагт 22.8 хувиар өссөн байна. ИТХ -ын талаар иргэд гол төлөв дараах ойлголттой байна. Үүнд:

- Ард иргэдийн дуу хоолой болж, санал бодлыг сонсдог байгууллага
- Ард иргэдийн төлөөллийн байгууллага
- Иргэдэд үйлчлэх байгууллага
- Иргэдийн төлөө ажиллах ёстой байгууллага
- Иргэдийг төлөөлж, иргэдээс сонгогддог байгууллага
- Намын талаар шийдвэр гаргадаг байгууллага
- Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх байгууллага
- Орон нутгийг хөгжүүлэх ёстой байгууллага
- Нутгийн өөрөө удирдах байгууллага
- Төрийн албан хаагчид
- Төсөвт байгууллага
- Хорооны үйл ажиллагааг удирддаг байгууллага зэрэг хариултууд түгээмэл байна.

ФБЯ -ын тэмдэглэлээс:

ИТХ нь яг ямар үйл ажиллагаа явуулах, ямар учиртай байгууллага гэдэг талаар иргэдэд танилцуулж мэдээлэл өгдөггүй. Сум орон нутгийн хэтийн төлөвийг тодорхойлж, чиглүүлдэг байгууллага юм болов уу гэж ойлгодог. ИТХ -ын дарга, төлөөлөгч гэсэн хүмүүс байдаг ч яг ямар чиг үүрэг гүйцэтгэдэг, ард түмэнтэйгээ хэрхэн харьцах ёстой талаар ямар ч ойлголцогүй байгаа. ИТХ дээр үйл ажиллагаагаа дэлгэрэнгүй тайлбарлаж өгдөг байх хэрэгтэй. Орж ирсэн төсвийг хаана, юунд зарцуулж байгаагаа иргэдэд танилцуулдаг байх хэрэгтэй. Ийм төрлийн мэдээ ховор байдаг.

Төв аймаг, Эрдэнэсант сум, Иргэдийн ФБЯ

ИТХ бол ард түмнээ төлөөлсөн бидний саналыг цааш нь дамжуулах зорилготой байгууллага. Ард түмэн тэр болгоныг мэддэггүй. ИТХ -ын төлөөлөгч ард түмнээсээ сонгогддог боловч амьдрал дээр өөрийн эрх ашгийн төлөө ажилладаг. Засаг дарга сонгох, ИТХ-ын дарга сонгохыг иргэд ойлгодог болсон. Би фермерийн аж ахуйтай болъё гэж төсөл бичихэд ИТХ дээр орно. ИТХ дээрээс орж ирсэн мөнгө төгрөгийг хуваарилаад хийх ёстой ажлуудыг нь удирдаж хийлгэх ёстой.

Төв аймаг, Эрдэнэсант сум, Иргэдийн ФБЯ

ИТХ бол орон нутгаас ард түмний итгэл хүлээлгэж сонгосон, тэдгээр хүмүүсийн дуу хоолой болж цаашид аймаг, улсын хэмжээнд зуучлах байгууллага юм. Энэ орон нутагт болж байгаа үйл ажиллагааг дэмжиж, хүмүүсийн амьдрал ахуйг дээшлүүлж, асуудлыг нь шийддэг байгууллага.

Ховд аймаг, Мянгад сум, Иргэдийн ФБЯ

ИТХ-ын дарга гэж сонгож байгаа. Тэр хүн бол бидэнтэй ойр байх ёстой. Иргэдээс санал хүсэлт авч, цааш нь дамжуулдаг байх ёстой. Гэтэл бодит амьдрал дээр сонгуулийн үеэр л гарч ирээд, сонгогдохвол алга болчихдог. Дараа нь сонгууль болох үеэр дахиад л гэнэт гараад ирдэг.

Завхан аймаг, Улиастай сум, Иргэдийн ФБЯ

Анхан шатны байгууллага хорооны тусгай алба нь хүмүүс биднийг төлөөлж чадна. Гэхдээ бид нарын ашиг сонирхол үзэл бодлыг хамгаалах, дэмжих гэхээр хороонд төсөв байдаггүй. Одоо дүүрэгт төсөв батлаад өгсөн боловч хороонд байхгүй. Анхан шатны байгууллагууд дээр ямар ч төсөв байхгүй. Тэгээд асуудал шийдэгдэхгүй гацдаг. Гудамжинд камер тавих зэрэг асуудлыг хамгийн эхэнд хэсэг дээр хэсгийн ахлагчид хэлнэ. Хэсгийн ахлагч цааш уламжилж дүүргийн төлөөлөгчтэй нь холбогдоход хэцүү байдаг.

Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ

ИТХ бол маш чухал алба. Дүүргийн төлөөлөгч, нийслэлийн иргэдийн төлөөлөгч гэж байдаг. Эдгээр хүмүүс бидэнд УИХ -ын гишүүдээс илүү чухал ач холбогдолтой. Гэтэл иргэд бид өөрсдөө мэддэггүй учраас ач холбогдол өгдөггүй. Бид идэвхтэй байж хурал зөвлөгөөнд нь оролцож, хэлэлцэж асуудлуудын хүрээнд санал бодлоо илэрхийлдэг байх ёстой. Одоо энэ хороо дүүрэгт хамгийн эхний ээлжид хөгжүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн санг батлах, замын татварыг 5 дахин нэмэгдүүлэх талаар хурал хийгээд байгаа. Иргэд хаанаас эдгээр ажлыг хийдгийг ч мэдэхгүй байгаа.

Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ


Судалгаанд оролцогчдоос ИТХ -ын талаарх зөв, буруу, сөрөг ойлголтуудтай санал нийлж буй эсэхийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 60 -аас дээш хувь нь зөв ойлголтуудтай санал нийлж байна. Нийт судалгаанд оролцогчдын хамгийн их санал нийлж буй ойлголтуудыг дурдвал, 91 хувь нь “Ард иргэдийн дундаас сонгогдон ажиллаж байгаа иргэдийн төлөөллийн байгууллага”, 83 хувь нь “Ард иргэдийн санал хүсэлтийг авч, холбогдох газарт уламжлан шийдвэрлэж өгдөг байгууллага”, 79 хувь нь “Тухайн нутаг дэвсгэрт оршин суугч иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж, шийдвэрлэдэг байгууллага”, 79 хувь нь “Иргэдийн амьжиргаа, нутаг орны хөгжлийг сайжруулах байгууллага”, 76 хувь нь “Ард түмний улс төрийн оролцоог нэмэгдүүлэх ёстой байгууллага” гэж ИТХ -ыг ойлгодог байна.

ИТХ -ын талаарх буруу ойлголтуудын хувьд нийт оролцогчдын 69 хувь нь “Орон нутагт төрийн үйлчилгээг үзүүлэгч хамгийн дээд байгууллага”, 62 хувь нь “ИТХ, ИНХ нь төрийн эрх барих байгууллага”, 42 хувь нь “ИТХ, ИНХ нь улсын чанартай асуудлыг бие даан шийдвэрлэж чадна”, 28 хувь нь “Хууль баталдаг байгууллага” гэж ойлгодог байна.

ИТХ -ын талаарх сөрөг ойлголтын хувьд нийт судалгаанд оролцогчдын 34 хувь нь “Ажил хийдэггүй байгууллага”, 32 хувь нь “Мөнгө иддэг байгууллага” гэж хариулжээ.

ИТХ -ын талаарх ойлголтыг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаар харьцуулан харвал хөдөө орон нутгийн иргэд илүү зөв ойлголттой, Улаанбаатар хотын иргэд илүү сөрөг ойлголттой байгаа нь харагдаж байна. Тодруулбал, Улаанбаатар хотын иргэдийн 40 хувь нь ИТХ бол “Мөнгө иддэг байгууллага” гэдэгтэй санал нийлсэн байна. ИТХ -ын талаарх буруу ойлголтуудтай хөдөө орон нутгийн иргэд илүү их санал нийлсэн байна.

График 13: ИТХ-ын талаарх ойлголтуудтай санал нийлэх байдал, n=1212



2.3.2. ИТХ -ын талаарх мэдээлэл авах байдал

ИТХ -ын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авдаг болон цаашид авахыг хүсэж буй эх үүсвэрийг тодруулбал дараах бүтэцтэй байна. Зөрүү өндөр (сөрөг утгатай) үзүүлэлт дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

Хүснэгт 15: Иргэдийн ИТХ -ын талаарх мэдээлэл авахыг хүсдэг болон одоо мэдээлэл авч буй суваг, тэдгээрийн зөрүү, байршлаар, n=1212

Мэдээлэл авахыг хүсэж буй сувгаар эрэмбэлбэл	Мэдээллийн суваг	ИТХ -ын талаарх мэдээлэл авахыг хүсдэг эх үүсвэр			ИТХ -ын талаарх мэдээлэл авдаг эх үүсвэр			Зөрүү (Мэдээлэл авдаг - Мэдээлэл авахыг хүсдэг)		
		Улаанбаат ар хот	Хөдөө орон нутаг	Нийт	Улаанбаат ар хот	Хөдөө орон нутаг	Нийт	Улаанбаат ар хот	Хөдөө орон нутаг	Нийт
1	Сошиал суваг /facebook, twitter гэх мэт/	41.3%	33.1%	36.5%	30.5%	24.8%	27.1%	-10.8%	-8.3%	-9.3%
2	Телевиз /орон нутгийн/	22.0%	29.7%	26.5%	20.0%	29.4%	25.5%	-2.0%	-0.3%	-1.0%
3	Телевиз /орон даяар цацагддаг/	36.1%	15.0%	23.8%	47.5%	16.5%	29.3%	11.4%	1.4%	5.5%
4	Утсаар	14.6%	18.0%	16.6%	3.4%	9.4%	6.9%	-11.2%	-8.6%	-9.7%
5	Хурал, уулзалтын үеэр	5.0%	16.2%	11.6%	6.8%	17.0%	12.8%	1.8%	0.8%	1.2%
6	Сум/дүүргийн ИТХ-ын ажлын албанаас	9.4%	12.7%	11.3%	8.8%	16.2%	13.1%	-0.6%	3.5%	1.8%
7	Нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн самбараас	4.0%	13.5%	9.6%	3.4%	12.8%	8.9%	-0.6%	-0.7%	-0.7%
8	Хурлын төлөөлөгчдөөс шууд	6.8%	11.4%	9.5%	3.4%	6.5%	5.2%	-3.4%	-4.9%	-4.3%
9	Хэвлэмэл тараах материал, сурталчилгааны хуудас	9.2%	6.9%	7.8%	5.8%	4.6%	5.1%	-3.4%	-2.3%	-2.7%
10	Сонин	8.8%	6.5%	7.4%	11.4%	5.8%	8.1%	2.6%	-0.7%	0.7%
11	Хөрш айл эсвэл ойр дотнын хэн нэгнээс	3.2%	9.1%	6.7%	6.0%	15.0%	11.3%	2.8%	5.9%	4.6%
12	Мессеж	11.8%	3.1%	6.7%	1.4%	0.8%	1.1%	-10.4%	-2.3%	-5.6%
13	Сум/дүүргийн ИТХ-ын даргаас	3.0%	8.9%	6.4%	3.0%	8.7%	6.4%	0.0%	-0.1%	-0.1%
14	Бусад вэбсайтаас	7.0%	6.0%	6.4%	6.6%	5.1%	5.7%	-0.4%	-1.0%	-0.7%
15	Радио	6.8%	5.6%	6.1%	4.8%	6.5%	5.8%	-2.0%	0.8%	-0.3%
16	ИТХ-ын вэбсайт /khural.mn/	5.2%	4.6%	4.9%	1.2%	3.0%	2.2%	-4.0%	-1.7%	-2.6%
17	Нутгийн захиргааны байгууллагын вэбсайт/цахим хуудас	4.2%	3.9%	4.0%	1.2%	2.1%	1.7%	-3.0%	-1.8%	-2.3%
18	Аймаг/нийслэлийн ИТХ-ын ажлын албанаас	3.2%	3.0%	3.1%	1.6%	3.5%	2.7%	-1.6%	0.6%	-0.3%
19	И-мэйл	5.0%	1.0%	2.6%	1.0%	0.6%	0.7%	-4.0%	-0.4%	-1.9%
20	Багийн засаг дарга, хороо, нэг цэгийн үйлчилгээ	4.2%	0.8%	2.2%	2.6%	2.3%	2.4%	-1.6%	1.4%	0.2%
21	Аймаг/нийслэлийн ИТХ-ын даргаас	0.8%	2.7%	1.9%	0.8%	1.4%	1.2%	0.0%	-1.3%	-0.7%
22	Мэдэхгүй/санахгүй байна	1.0%	2.3%	1.7%	2.4%	2.5%	2.5%	1.4%	0.3%	0.7%
23	Улс төрийн намын ажилтнаас	1.2%	1.1%	1.2%	2.0%	1.5%	1.7%	0.8%	0.4%	0.6%
	Ямар нэг байдлаар ИТХ -ын талаарх мэдээлэл авдаг				85.0%	87.9%	86.7%			
	Огт мэдээлэл авдаггүй				15.0%	12.1%	13.3%			

Дээрх хүснэгтээс харахад нийт иргэдийн 86.7 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 85 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 87.9 хувь нь ИТХ -ын талаарх мэдээллийг ямар нэгэн байдлаар авдаг байна. Одоо мэдээлэл авч байгаа гол эх үүсвэр нь орон даяар цацагддаг телевиз 29.3 хувьтай, сошиал суваг 27.1 хувьтай, орон нутгийн телевиз 25.5 хувьтай байна. Иргэдийн мэдээлэл авахыг хүсэж буй эх үүсвэрүүдийн хувьд нэгдүгээрт, **сошиал суваг** (facebook, twitter гэх мэт) 36.5 хувьтай, хоёрдугаарт орон нутгийн телевиз 26.5 хувьтай, гуравдугаарт орон даяар цацагддаг телевиз 23.8 хувьтай эрэмбэлэгдэж байна. **Иргэдийн мэдээлэл авахыг хүсэж буй суваг болон одоо мэдээлэл авч буй сувгийн зөрүүг харвал сошиал сувгаар, орон нутгийн телевизээр, утсаар, хурлын төлөөлөгчдөөс хангалттай мэдээлэл хүрэхгүй байна.**

Цаашид мэдээлэл авахыг хүсэж буй гол таван эх үүсвэрийг нас, хүйс, байршлаар задлан дараах хүснэгтэд дүрслэв.

Хүснэгт 16: Мэдээлэл авахыг хамгийн их хүсэж буй таван суваг, нас, хүйс, байршлаар, n=1212

	Сошиал суваг /facebook, twitter гэх мэт/	Телевиз /орон нутгийн/	Телевиз /орон даяар цацагддаг/	Утсаар	Хурал, уулзалтын үеэр
Насны бүлэг:					
18-24	58.3%	21.9%	19.8%	21.4%	5.9%
25-34	49.7%	25.6%	22.9%	16.5%	10.9%
35-44	31.8%	25.3%	22.9%	15.8%	13.0%
45-54	22.1%	28.8%	25.7%	15.9%	13.7%
55-64	12.6%	32.3%	28.7%	13.8%	13.8%
Хүйс:					
Эрэгтэй	34.0%	26.0%	24.7%	13.4%	12.3%
Эмэгтэй	38.9%	26.9%	22.8%	19.7%	10.8%
Аймгаар:					
Дундговь	39.8%	16.2%	5.1%	21.3%	7.4%
Завхан	39.3%	39.3%	19.6%	23.2%	14.3%
Төв	17.0%	14.9%	12.8%	17.0%	19.1%
Ховд	33.7%	36.6%	17.8%	9.9%	19.8%
Хөвсгөл	30.4%	48.0%	24.6%	19.9%	21.6%
Хэнтий	27.5%	23.3%	15.8%	14.2%	20.8%
Дүүргээр:					
Багануур	30.8%	23.1%	15.4%	15.4%	15.4%
Багахангай	42.1%	15.8%	0.0%	0.0%	5.3%
Баянгол	55.3%	22.4%	61.8%	18.4%	7.9%
Баянзүрх	42.4%	30.5%	44.1%	23.7%	5.1%
Налайх	18.8%	3.1%	37.5%	12.5%	3.1%
Сонгинохайрхан	39.5%	42.1%	23.7%	23.7%	6.6%
Сүхбаатар	46.6%	9.6%	21.9%	11.0%	2.7%
Хан-Уул	52.6%	31.6%	43.9%	10.5%	5.3%
Чингэлтэй	29.2%	11.5%	36.5%	7.3%	2.1%
Нийт	36.5%	26.5%	23.8%	16.6%	11.6%

ФБЯ -ын тэмдэглэлээс:

Залуу хүүхэд учраас мэдээллийг цахим ертөнцөөс гол төлөв авдаг. Албан ёсны тайлан байдлаар хүлээн авч байгаагүй.

Мэдээллийг гол төлөв зурагтаар авдаг. Олон нутгийн телевизээр хардаг.

Миний хувьд үндэсний телевиз болон хурал цуглаанаар ИТХ -ын талаарх мэдээллийг авдаг.

Завхан аймаг, Улиастай сум, Иргэдийн ФБЯ

ИТХ -ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг социал суваг, телевиз, багийн хэсгийн ахлагчаас авдаг.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, Иргэдийн ФБЯ

ИТХ -ын талаарх мэдээллийг гол төлөв ам дамжсан яриагаар сонсдог. Нэг мэдэхэд хурал нь зарлагдаад, хийгдээд өнгөрсөн байдаг. Хуралд суусан, суугаагүй хүмүүсийн амнаас ам дамжин, үнэн худал янз бүрийн яриа яригддаг. Хурал дээр нь ажлын тайлан гэж тараадаггүй. Зүгээр л амаар яриад өнгөрдөг. Уг нь сумын телевиз өмнө нь ажилладаг байсан ч одоо огт ажиллахгүй байгаа. Хүний амнаас үнэн худал нь мэдэгдэхгүй янз бүрийн юм сонсож байхаар телевизээр бодитой, баримттай юм сонсмоор байна. Орон нутгийн телевизээрээ сум орон нутагтаа болж байгаа наадам, тэмцээн уралдаан, зар, иргэдийн хурлын зарлал, шийдвэр гээд олон зүйл гаргаж болно шүү дээ.

Ховд аймаг, Мянгад сум, Иргэдийн ФБЯ

ИТХ -ын талаарх мэдээллийг орон нутгийн телевиз, фейсбүүкээр хүргэвэл илүү хурдан хүрнэ.

Төв аймаг, Эрдэнэсант сум, Иргэдийн ФБЯ


ИТХ -ын талаарх мэдээллийг UBS телевизээр голчлон хардаг. Хурлыг шууд дамжуулж байдаг.

Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ

ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материалтай танилцсан байдал


ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материал хүлээн авсан байдал 18 хувьтай байна. Улаанбаатар хотын хувьд хэвлэмэл материал авсан хувь хөдөө орон нутагтай харьцуулахад 3 хувиар өндөр байна.

График 14: ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материал хүлээж авсан байдал, n=1212



Хэвлэмэл материал хүлээн авсан нийт иргэдийн 81 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 84 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 78 хувь нь уншиж танилцсан байна. Өөрөөр хэлбэл, 5 хүн тутмын 4 нь хүлээн авсан хэвлэмэл материалтай танилцсан байна.


График 15: ИТХ-ын үйл ажиллагаатай холбоотой хэвлэмэл материалтай уншиж танилцсан байдал, n=221



ИТХ-ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдал

ИТХ-ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдал 19 хувьтай байна. Үүнээс, уг сайт руу байнга нэвтэрдэг 1 хувь, уг сайт руу нэвтэрч байсан 4 хувь, уг сайт руу нэвтэрч үзээгүй 14 хувь байна. Тус сайтын талаар огт сонсоогүй 81 хувь байна. Өмнөх суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, www.khural.mn сайтын талаар сонсон иргэдийн тоо хэмжээ Улаанбаатар хотод 3 хувиар, хөдөө орон нутагт 7.6 хувиар буурсан байна.

График 16: ИТХ-ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдал, n=1212



ИТХ-ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдлыг нас, хүйс, байршлаар задлан дараах хүснэгтэд дүрслэв. Уг сайтын талаар 45-54 насны бүлэг хамгийн сайн сонссон байна. Аймгийн хувьд Хөвсгөл аймаг, дүүргийн хувьд Хан-Уул дүүргийн иргэд хамгийн бага хувьтай сонсжээ. Багахангай дүүргийн иргэд тус сайтын талаар хамгийн сайн сонссон бөгөөд байнга нэвтэрдэг хувь өндөр байна.

Хүснэгт 17: ИТХ-ын нэгдсэн цахим хуудас болох www.khural.mn -ийн талаар сонссон байдал, нас, хүйс, байршлаар n=1212

	Сонссон, уг сайт руу байнга зочилдог	Сонссон, уг сайт руу зочилж байсан	Сонссон, уг сайт руу зочилж үзээгүй	Огт сонсоогүй
Насны бүлэг				
18-24	1.6%	5.3%	11.8%	81.3%
25-34	0.9%	4.1%	14.1%	80.9%
35-44	<u>2.1%</u>	4.5%	12.7%	80.8%
45-54	0.4%	2.7%	18.1%	78.8%
55-64	-	3.6%	15.6%	80.8%
Хүйс				
Эрэгтэй	1.0%	4.6%	13.1%	81.3%
Эмэгтэй	1.1%	3.4%	15.6%	79.8%
Аймгаар				
Дундговь	0.9%	5.1%	9.3%	84.7%
Завхан	-	-	17.9%	82.1%
Төв	<u>2.1%</u>	-	21.3%	76.6%
Ховд	2.0%	2.0%	16.8%	79.2%
Хөвсгөл	0.6%	2.9%	10.5%	86.0%
Хэнтий	1.7%	9.2%	19.2%	70.0%
Дүүргээр				
Багануур	-	-	38.5%	61.5%
Багахангай	<u>10.5%</u>	10.5%	15.8%	63.2%
Баянгол	1.3%	2.6%	14.5%	81.6%
Баянзүрх	-	6.8%	13.6%	79.7%
Налайх	-	-	18.8%	81.3%
Сонгинохайрхан	1.3%	1.3%	13.2%	84.2%
Сүхбаатар	-	8.2%	11.0%	80.8%

Хан-Уул	-	1.8%	12.3%	86.0%
Чингэлтэй	1.0%	4.2%	18.8%	76.0%
Нийт	1.1%	4.0%	14.4%	80.5%

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Үйл ажиллагааны шийдвэрүүд маань 70-80 хувь нь ил тод байдаг. Хурлаас гарсан тогтоол шийдвэрүүд Сонгинохайрхан дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал <http://songinokhairkhan.ub.khural.mn/> гэсэн сайт дээр мэдээлэл нь тавигддаг. Иргэд сайт уруу орж харах хандлага маш муу байдаг. Мэдээлэл авах нь бага байдаг.


Улаанбаатар хот, СХД, дүүргийн ИТХ -ын дарга

2.3.3. Аймаг/Нийслэлийн ИТХ -ын талаарх ойлголт, хандлага

Аймаг/Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ

Иргэд аймаг/нийслэлийн ИТХ -ын иргэдэд үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд тайлагнадаг гэж нийт иргэдийн 48 хувь үзжээ. Байршлаар харвал хөдөө орон нутагт 53 хувьтай, Улаанбаатар хотод 42 хувьтай байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, аймаг/нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж үзсэн хувь Улаанбаатар хотод 0.9 хувиар, хөдөө орон нутагт 7.4 хувиар өсжээ.

График 17: Аймаг/Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, байршлаар, n=1212



Аймаг/нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагаагаа тайлагнах байдлын үнэлгээг нас, хүйс, байршлаар задлан дараах хүснэгтэд дүрслэв. Насны бүлгийн хувьд 25-34 нас, хүйсийн хувьд эрэгтэй, аймгийн хувьд Завхан аймаг, дүүргийн хувьд Баянзүрх дүүргийн иргэд аймаг/нийслэлийн ИТХ үйл ажиллагаагаа огт тайлагнадаггүй гэж хариулсан хувь өндөр байна. Дундаж үнэлгээ 5 онооноос 1.93 байгаа учраас аймаг/нийслэлийн ИТХ үйл ажиллагаагаа иргэдэд хангалттай тайлагнаж, хүргэж чадахгүй байна гэж үзэж байна.


Хүснэгт 18: Аймаг/Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, нас, хүйс, байршлаар, n=1212

	Бүгдийг нь тайлагнадаг	Дийлэнхийг нь тайлагнадаг	Тал хувийг нь тайлагнадаг	Цөөн хувийг нь тайлагнадаг	Огт тайлагнадаггүй	Мэдэхгүй/санахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Аймаг/хот:							
Улаанбаатар хот	10.6%	7.6%	9.4%	14.2%	30.5%	27.7%	1.70
Хөдөө орон нутаг	13.8%	12.9%	15.0%	11.0%	21.4%	25.9%	2.09
Насны бүлэг:							
18-24	13.4%	13.9%	10.7%	15.5%	18.2%	28.3%	2.04
25-34	11.5%	6.8%	14.7%	8.8%	29.4%	28.8%	1.76
35-44	11.6%	9.2%	13.7%	11.6%	27.7%	26.0%	1.87
45-54	13.3%	11.9%	12.8%	12.4%	21.2%	28.3%	1.99
55-64	13.8%	16.2%	9.0%	16.8%	25.1%	19.2%	2.19
Хүйс:							
Эрэгтэй	9.6%	10.3%	12.3%	11.4%	27.9%	28.5%	1.77
Эмэгтэй	15.3%	11.2%	13.1%	13.1%	22.5%	24.8%	2.09
Аймагаар:							
Дундговь	13.0%	12.5%	10.2%	9.7%	20.8%	33.8%	1.86
Завхан	21.4%	17.9%	8.9%	10.7%	30.4%	10.7%	2.57
Төв	19.1%	2.1%	14.9%	2.1%	29.8%	31.9%	1.83
Ховд	16.8%	16.8%	23.8%	11.9%	13.9%	16.8%	2.60
Хөвсгөл	9.9%	9.4%	15.2%	9.4%	28.1%	28.1%	1.80
Хэнтий	12.5%	17.5%	19.2%	18.3%	11.7%	20.8%	2.38
Дүүргээр:							
Багануур	0.0%	30.8%	7.7%	15.4%	15.4%	30.8%	1.92
Багахангай	26.3%	5.3%	15.8%	15.8%	10.5%	26.3%	2.42
Баянгол	6.6%	9.2%	11.8%	14.5%	28.9%	28.9%	1.63
Баянзүрх	3.4%	3.4%	5.1%	6.8%	32.2%	49.2%	0.92
Налайх	12.5%	6.3%	18.8%	28.1%	15.6%	18.8%	2.16
Сонгинохайрхан	10.5%	3.9%	15.8%	17.1%	35.5%	17.1%	1.86
Сүхбаатар	8.2%	6.8%	6.8%	12.3%	45.2%	20.5%	1.59
Хан-Уул	7.0%	3.5%	5.3%	17.5%	36.8%	29.8%	1.37
Чингэлтэй	19.8%	12.5%	5.2%	10.4%	22.9%	29.2%	2.08
Нийт	12.5%	10.7%	12.7%	12.3%	25.2%	26.7%	1.93

Аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчдийн хурлын гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ

Аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчдийн гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлдэг байдлыг тодруулахад нийт иргэдийн 53 хувь нь тодорхой хэмжээнд мэдээлдэг гэж үзсэн байна. Байршлаар тодруулбал, Улаанбаатар хотын иргэдийн 45 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 58 хувь нь аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчид хурлын гаргасан шийдвэрүүдээ тодорхой хэмжээнд мэдээлдэг гэж үнэлсэн байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, аймаг/нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлдэг гэж үзсэн хувь Улаанбаатар хотод 3.1 хувиар буурч, хөдөө орон нутагт 12.9 хувиар өссөн байна.

График 18: Аймаг/Нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, байршлаар, n=1212



Дээрх үнэлгээг нас, хүйс, байршлаар задлан харвал насны бүлгийн хувьд 25-34 насны бүлэг, эрэгтэй, аймгийн хувьд Төв аймаг, дүүргийн хувьд Сүхбаатар дүүргийн иргэд огт мэдээлдэггүй гэж хариулсан хувь өндөр байна. Дундаж үнэлгээ 2.04 байгаа тул аймаг/нийслэлийн ИТХ иргэдэд мэдээлэл хангалттай өгч чадахгүй байна гэж дүгнэж байна. Ховд аймаг, Багахангай дүүрэг гаргасан шийдвэрүүдээ хамгийн сайн мэдээлдэг гэж үнэлгээ авсан байна.

Хүснэгт 19: Аймаг/Нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, нас, хүйс, байршлаар, n=1212

	Бүгдийг нь мэдээлдэг	Дийлэнхийг нь мэдээлдэг	Тал хувийг нь мэдээлдэг	Цөөн хувийг нь мэдээлдэг	Огт мэдээлдэггүй	Мэдэхгүй/санахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Аймаг/хот:							
Улаанбаатар хот	9.0%	7.2%	13.4%	15.8%	30.7%	24.0%	1.76
Хөдөө орон нутаг	13.5%	14.6%	17.3%	12.9%	20.1%	21.5%	2.24
Насны бүлэг:							
18-24	13.9%	17.1%	15.0%	11.2%	21.9%	20.9%	2.27
25-34	9.1%	8.8%	13.5%	15.6%	26.5%	26.5%	1.79
35-44	9.2%	12.0%	18.2%	12.7%	25.3%	22.6%	1.99
45-54	14.2%	9.7%	14.6%	16.8%	22.6%	22.1%	2.10
55-64	15.0%	12.6%	18.0%	13.2%	24.6%	16.8%	2.30
Хүйс:							
Эрэгтэй	7.8%	11.9%	14.4%	16.4%	27.5%	21.9%	1.90
Эмэгтэй	15.4%	11.2%	16.9%	11.8%	21.5%	23.2%	2.18
Аймгаар:							
Дундговь	12.5%	18.1%	7.9%	9.3%	18.5%	33.8%	1.95
Завхан	21.4%	12.5%	23.2%	5.4%	19.6%	17.9%	2.57
Төв	10.6%	6.4%	23.4%	8.5%	27.7%	23.4%	1.94
Ховд	14.9%	16.8%	19.8%	24.8%	18.8%	5.0%	2.69
Хөвсгөл	12.9%	9.9%	20.5%	10.5%	25.1%	21.1%	2.12
Хэнтий	12.5%	17.5%	22.5%	18.3%	14.2%	15.0%	2.51
Дүүргээр:							
Багануур	0.0%	7.7%	23.1%	38.5%	15.4%	15.4%	1.92
Багахангай	10.5%	21.1%	26.3%	5.3%	21.1%	15.8%	2.47
Баянгол	5.3%	11.8%	17.1%	22.4%	22.4%	21.1%	1.92
Баянзүрх	1.7%	8.5%	5.1%	8.5%	28.8%	47.5%	1.03
Налайх	15.6%	9.4%	25.0%	18.8%	15.6%	15.6%	2.44

	Бүгдийг нь мэдээлдэг	Дийлэнхий г нь мэдээлдэг	Тал хувийг нь мэдээлдэг	Цөөн хувийг нь мэдээлдэг	Огт мэдээлдэгт үй	Мэдэхгүй/с анахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Сонгинохайрхан	11.8%	5.3%	14.5%	14.5%	39.5%	14.5%	1.92
Сүхбаатар	5.5%	6.8%	11.0%	19.2%	41.1%	16.4%	1.67
Хан-Уул	0.0%	5.3%	10.5%	21.1%	36.8%	26.3%	1.32
Чингэлтэй	20.8%	2.1%	10.4%	8.3%	29.2%	29.2%	1.90
Нийт	11.6%	11.6%	15.7%	14.1%	24.5%	22.5%	2.04

- Гүнзгийрүүлсэн ярилцлагад оролцогчдын хувьд биечлэн болон сошиалаар мэдээллээ тавих нь хамгийн оновчтой гэж үзэж байна. Үйл ажиллагаагаа голчлон ИНХ дээр тайлагнадаг бөгөөд сошиал сувгаар өдөр тутам мэдээллээ хүргэж байна. Хөдөө орон нутагт сошиал сувгийг үздэг хүн нь цөөхөн учраас өөр арга хэрэгслийг давхар ашиглах хэрэгтэй байдаг. Гаргасан шийдвэрүүдээ айл өрхөөр явахдаа, хурал зохион байгуулахдаа, сошиал сувагт мэдээлдэг. Хамгийн оновчтой мэдээлэл хүргэх суваг бол айл өрхүүдээр нэг бүрчлэн оруулж өгөх явдал. Гэвч бүх айлуудаар орж чаддаггүй бөгөөд 30-40 хувь нь орхигддог. Орон сууцны айлууд интернэт ашиглан сошиалаар мэдээллээ авчихдаг. Залуу хүмүүс хурал цуглаанд ирдэггүй учраас сошиалаар мэдээллээ сайн хүргэдэг. Настай хүмүүс сошиал сувгийг сайн ашигладаггүй учраас хурал цуглаанаар мэдээллээ хүргэдэг. Иймд **сошиал, хурал цуглаанаар, хэсэгчлэн уулзах байдлаар мэдээлэл түгээх аргыг хослуулан хэрэглэх нь оновчтой байна.**

Аймаг/Нийслэлийн ИТХ-аас гаргасан гол шийдвэрүүдээс нэрлэсэн байдал

Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан гол шийдвэрүүдээс нэрлүүлэхэд нийт иргэдийн 43 хувь хэлж мэдэхгүй, 25 хувь нь “Орон нутгийн төсөв батлах”, 15 хувь нь “Татварын хувь хэмжээ, хураамж тогтоох” гэж хариулсан байна. Дараах үзүүлэлтүүдээс гадна бусад хувилбарт архи дан согтуурахтай холбоотой шийдвэр гаргах, дэд бүтэц зам гүүр тавих, гэрэлтүүлэг хийх, сургууль цэцэрлэг барих, хог цэвэрлэх ажиллагаа зохион байгуулах, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зэрэг хариултуудыг дурдаж байв.

Хүснэгт 20: Аймаг/нийслэлийн ИТХ-аас гаргасан гол шийдвэрүүд, байрилаар, n=1212

	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Нийт
Мэдэхгүй байна	50%	38%	43%
Орон нутгийн төсөв батлах	16%	31%	25%
Татварын хувь хэмжээ, хураамж тогтоох асуудлууд /хог хаягдал, буу гэх мэт/	13%	17%	15%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа	11%	18%	15%
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	17%	14%	15%
Ус, рашаан булгийн эх хамгаалах тухай	7%	20%	15%
Орон нутгийн өмчийг захиран зарцуулах	6%	15%	11%
Газар нутгийг тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах тухай	7%	13%	11%
ОНХС-ийн төсвийг юунд зарцуулах тухай шийдвэр гаргах	4%	11%	8%
Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах	6%	9%	8%
Ойгоос мод бэлтгэх хэмжээ тогтоох	3%	11%	8%
Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоох	4%	7%	6%
Нэрэмжит болгох	6%	4%	4%
Төрийн шагналд тодорхойлох, шагналд уламжлах	3%	4%	4%
Тэгш ой тэмдэглэх	2%	5%	4%
Бусад	2%	1%	2%

ФБЯ -ын тэмдэглэлээс:

Манай Цагаанбуланд зам засах талаар яригдаад багийнхаа төвийг тохижуулсан. Худагтай, түүндээ мод тарьж цэцэрлэгжүүлэх ажил хийх талаар яригдаж байгаа. Багийн төв бас сандалгүй. Сандал тавьж хуралд суухад тав тухтай болгох талаар яригдаж байгаа. Одоо ганц шийдвэрлэсэн асуудал нь ус боогоод байж байна. Ойрд хуралд суугаагүй. Өөр ажлууд яригдаж байж магадгүй юм.

Ховд аймаг, Мянгад сум, Иргэдийн ФБЯ

Батхаан уулыг дархан цаазтай болгох талаар санал асуулга явуулж байсан. Шийдвэр нь албан ёсоор гарсан эсэхийг сайн хэлж мэдэхгүй байна. Хүүхдийн тоглоомын талбай, зарим гудамжинд гэрэлтүүлэг тавьсан. Замын хажуугийн далан тавьсан. Сургуулийн дотуур байрны өрөөг тохижуулсан гэсэн.

Төв аймаг, Эрдэнэсант сум, Иргэдийн ФБЯ

Аймаг/нийслэлийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг аймаг, дүүргээр задлан дараах хүснэгтэд дүрслэв. Аймгийн хувьд Ховд аймгийн иргэд аймгийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдээс хамгийн сайн нэрлэсэн бөгөөд мэдэхгүй гэж хариулсан хувь хамгийн бага буюу 1 хувьтай байна. Дундговь аймгийн иргэд аймгийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг мэдэхгүй гэж хариулсан хувь хамгийн өндөр буюу 69 хувьтай байна.

Дүүргүүдийн хувьд Багануур дүүргийн иргэд аймаг/нийслэлийн ИТХ -аас гаргасан шийдвэрийг мэдэхгүй гэж хариулсан хувь хамгийн бага буюу 0 хувьтай байна. Баянзүрх дүүргийн иргэд мэдэхгүй гэж хариулсан хувь хамгийн өндөр буюу 83 хувьтай байна.

Хүснэгт 21: Аймаг/нийслэлийн ИТХ -аас гаргасан шийдвэрийг нэрлэх байдал, байршлаар, n=1212


	Мэдэхгүй байна	Орон нутгийн төсөв батлах	Татварын хувь хэмжээ, хураамж тогтоох асуудлууд /хог хаягдал, буу гэх мэт/	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Ус, рашаан булгийн эх хамгаалах тухай	Орон нутгийн өмчийг захиран зарцуулах	Газар нутгийг тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах тухай
Аймгаар:								
Дундговь аймаг	69%	25%	7%	9%	5%	11%	11%	14%
Завхан аймаг	41%	38%	23%	29%	13%	13%	14%	4%
Төв аймаг	36%	26%	9%	13%	11%	28%	21%	9%
Ховд аймаг	1%	49%	23%	20%	14%	34%	20%	20%
Хөвсгөл аймаг	32%	28%	20%	21%	15%	22%	17%	8%
Хэнтий аймаг	25%	33%	24%	28%	29%	23%	13%	21%
Дүүргээр:								
Багануур	0%	31%	0%	38%	15%	23%	38%	23%
Багахангай	53%	26%	16%	11%	21%	11%	16%	11%
Баянгол	30%	26%	13%	11%	22%	8%	4%	12%
Баянзүрх	83%	5%	8%	2%	7%	2%	2%	0%
Налайх	16%	25%	16%	25%	28%	19%	9%	16%
Сонгинохайрхан	37%	17%	24%	11%	33%	4%	11%	3%
Сүхбаатар	56%	16%	14%	14%	8%	3%	3%	7%
Хан-Уул	47%	16%	16%	16%	14%	9%	2%	12%
Чингэлтэй	68%	7%	6%	3%	9%	8%	4%	3%

Нийт	43%	25%	15%	15%	15%	15%	11%	11%
------	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----

Аймаг/Нийслэлийн ИТХ-аас мэдээлэл авахаар хандсан байдал


Нийт иргэдийн 7 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 8 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 5 хувь нь аймаг/нийслэлийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандаж байжээ.

График 19: Аймаг/Нийслэлийн ИТХ-аас мэдээлэл авахаар хандсан байдал, n=1212



Мэдээлэл авахаар хандсан иргэдээс аймаг/нийслэлийн ИТХ мэдээллээ ил тод өгсөн эсэхийг тодруулахад 63 хувь нь тийм гэж хариулсан байна. Улаанбаатар хотын мэдээлэл авахаар хандсан иргэдийн 41 хувь нь хүссэн мэдээллээ авч чадсан байна.

График 20: Аймаг/Нийслэлийн ИТХ мэдээллээ ил тод өгсөн эсэх, n=79



Аймаг/Нийслэлийн ИТХ-ын үйл ажиллагааг үнэлсэн байдал

Судалгаанд оролцсон иргэдээр аймаг/нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлүүлэхэд нийт оролцогчдын 21.1 хувь нь маш сайн болон зарим талаараа сайн гэж үнэлсэн. Дундаж үнэлгээ 2.33 оноотой байна. Хөдөө орон нутгийн иргэд Улаанбаатар хотын иргэдээс илүү өндрөөр үнэлсэн байна. Насны бүлгийн хувьд 55-64 насны иргэд хамгийн өндөр, 25-34 насны иргэд хамгийн бага үнэлжээ. Аймгуудаас Ховд аймгийн иргэд хамгийн сайн үнэлсэн бол, Дундговь аймгийн иргэд хамгийн бага үнэлгээ өгсөн байна. Дүүргүүдийн хувьд Багахангай дүүрэг хамгийн өндөр үнэлгээ өгч, Баянзүрх дүүрэг хамгийн бага үнэлгээ өгсөн байна.

Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад аймаг/нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг “маш сайн” болон “зарим талаар сайн” гэж үнэлсэн хувь Улаанбаатар хотод 1.8 хувиар, хөдөө орон нутагт 3 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 22: Аймаг/Нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлэх байдал, нас, хүйс, байршилаар, n=1212

	Маш сайн	Зарим талаар сайн	Дунд	Зарим талаар муу	Маш муу	Мэдэхгүй байна	Хариулах аас татгалзсан	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Аймаг/хот:								
Улаанбаатар хот	5.8%	10.8%	38.3%	8.0%	16.0%	19.6%	1.6%	2.19
Хөдөө орон нутаг	6.9%	17.4%	40.1%	4.5%	9.1%	21.2%	0.7%	2.43
Аймгаар:								
Дундговь	8.8%	14.8%	35.2%	3.2%	11.1%	25.9%	0.9%	2.26
Завхан	10.7%	10.7%	41.1%	3.6%	5.4%	26.8%	1.8%	2.32
Төв	6.4%	17.0%	38.3%	2.1%	12.8%	23.4%	-	2.32
Ховд	6.9%	19.8%	45.5%	5.0%	8.9%	12.9%	1.0%	2.69
Хөвсгөл	2.9%	18.1%	42.7%	7.0%	9.4%	19.9%	-	2.39
Хэнтий	7.5%	22.5%	40.8%	4.2%	5.8%	18.3%	0.8%	2.64
Дүүрэг:								
Багануур	-	23.1%	46.2%	-	15.4%	15.4%	-	2.46
Багахангай	15.8%	21.1%	42.1%	-	15.8%	5.3%	-	3.05
Баянгол	5.3%	7.9%	40.8%	14.5%	7.9%	22.4%	1.3%	2.17
Баянзүрх	1.7%	5.1%	28.8%	6.8%	16.9%	39.0%	1.7%	1.46
Налайх	12.5%	28.1%	40.6%	6.3%	6.3%	6.3%	-	3.16
Сонгинохайрхан	9.2%	9.2%	40.8%	9.2%	13.2%	17.1%	1.3%	2.37
Сүхбаатар	1.4%	11.0%	41.1%	12.3%	19.2%	12.3%	2.7%	2.18
Хан-Уул	-	14.0%	33.3%	7.0%	26.3%	19.3%	-	1.96
Чингэлтэй	9.4%	6.3%	38.5%	3.1%	18.8%	20.8%	3.1%	2.13
Насны бүлэг:								
18-24	7.5%	20.9%	34.8%	6.4%	5.9%	22.5%	2.1%	2.44
25-34	4.1%	14.1%	38.5%	6.2%	13.2%	22.6%	1.2%	2.18
35-44	8.6%	12.0%	36.3%	7.9%	12.3%	21.9%	1.0%	2.28
45-54	5.8%	12.8%	42.0%	3.5%	12.4%	23.0%	0.4%	2.26
55-64	7.2%	16.2%	47.9%	4.8%	15.0%	8.4%	0.6%	2.69
Хүйс:								
Эрэгтэй	5.0%	13.6%	41.6%	6.0%	14.4%	18.6%	0.8%	2.31
Эмэгтэй	7.9%	15.8%	37.1%	5.9%	9.5%	22.5%	1.3%	2.35
Нийт	6.4%	14.7%	39.4%	5.9%	12.0%	20.5%	1.1%	2.33

Аймаг/Нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг сайн үнэлсэн шалтгааныг тодруулбал:

- **Ажлаа хугацаандаа сайн хийдэг**
- Хийсэн ажлуудаа сайн мэдээлдэг
- Иргэд оршин суугчдад хүрч ажилладаг
- Гаргасан шийдвэрүүд нь иргэдэд хүрсэн
- ИНХ -ыг сайн зохион байгуулдаг
- Нүдэнд харагдахуйц бодитой ажил хийдэг зэрэг шалтгааныг түгээмэл дурдаж байв.

Аймаг/Нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг муу үнэлсэн шалтгаан нь:

- **Мэдээлэл маш муу**
- Идэвхгүй
- Ажлаа хангалттай хийж чаддаггүй
- Иргэд оршин суугчдаа сонсдоггүй
- Иргэд оршин суугчдадаа хүрч ажилладаггүй
- Хүнд суртал гаргадаг
- Худаг, гэрэлтүүлэг гэх мэт ганц нэг төрлийн ажил хийгээд бусад тулгамдсан асуудлыг орхигдуулдаг
- ИНХ зохион байгуулах талаар мэдээлэл ирдэггүй


- Сонгуулийн үеэр идэвхжээд, бусад үед алга болдог зэрэг шалтгааныг голчлон дурдсан байна.

2.3.4. Сум/Дүүргийн ИТХ -ын талаарх үнэлгээ

Сум/Дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ

Сум/дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдлыг ард иргэд дараах байдлаар үнэлжээ. Нийт судалгаанд оролцогчдын 56 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 41 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 66 хувь сум/дүүргийнхээ ИТХ -ыг тодорхой хэмжээнд үйл ажиллагаагаа тайлагнадаг гэж дүгнэсэн байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, сум/дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал Улаанбаатар хотод 4.5 хувиар буурч, хөдөө орон нутагт 8.6 хувиар өссөн байна.

График 21: Сум/Дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, байршлаар, n=1212



Дүүргийн ИТХ -ын үйл ажиллагаагаа тайлагнах байдлыг дүүргээр задлан харвал Багануур дүүргийн иргэдийн үнэлгээ хамгийн өндөр, Баянзүрх дүүргийн иргэдийн үнэлгээ хамгийн бага байна. Улаанбаатар хотын нийт иргэдийн 29.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Хүснэгт 23: Дүүргийн ИТХ үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, дүүргээр, n=501

	Бүгдийг нь тайлагнадаг	Дийлэнхийг нь тайлагнадаг	Тал хувийг нь тайлагнадаг	Цөөн хувийг нь тайлагнадаг	Огт тайлагнадаггүй	Мэдэхгүй/санахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Улаанбаатар хот	10.2%	8.8%	11.0%	11.2%	28.9%	29.9%	1.70
Дүүргээр:							
Багануур	30.8%	23.1%	15.4%	7.7%	0.0%	23.1%	3.08
Багахангай	21.1%	21.1%	15.8%	10.5%	5.3%	26.3%	2.63
Баянгол	6.6%	17.1%	10.5%	15.8%	25.0%	25.0%	1.89
Баянзүрх	1.7%	3.4%	13.6%	6.8%	28.8%	45.8%	1.05
Налайх	3.1%	18.8%	25.0%	15.6%	28.1%	9.4%	2.25
Сонгинохайрхан	14.5%	6.6%	15.8%	13.2%	28.9%	21.1%	2.01
Сүхбаатар	4.1%	2.7%	9.6%	15.1%	43.8%	24.7%	1.34
Хан-Уул	3.5%	7.0%	3.5%	10.5%	42.1%	33.3%	1.19
Чингэлтэй	20.8%	5.2%	5.2%	5.2%	21.9%	41.7%	1.73

Сумын ИТХ -ын үйл ажиллагаагаа тайлагнах байдлыг аймаг, сумаар задлан харвал Хэнтий аймгийн иргэд хамгийн өндрөөр үнэлсэн байна. Хэнтий аймгийн сумдаас Батноров сумын иргэд

хамгийн өндөр үнэлсэн байна. Дундговь аймгийн иргэд хамгийн бага үнэлгээ өгсөн байна. Дундговь аймгийн сумдаас Сайнцагаан сумын иргэд сумын ИТХ -ын үйл ажиллагаагаа тайлагнах байдлыг хамгийн бага үнэлсэн байна.

Хүснэгт 24: Сумын ИТХ үйл ажиллагаагаа тайлагнаж буй байдлын талаарх үнэлгээ, аймаг, сумаар, n=711

	Бүгдийг нь тайлагнадаг	Дийлэнхийг нь тайлагнадаг	Тал хувийг нь тайлагнадаг	Цөөн хувийг нь тайлагнадаг	Огт тайлагнадаггүй	Мэдэхгүй/санахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Хөдөө орон нутаг	24.6%	17.0%	14.1%	10.5%	17.0%	16.7%	2.71
Дундговь аймаг	24.1%	17.6%	9.7%	5.1%	19.0%	24.5%	2.49
Адаацаг сум	27.3%	20.5%	11.4%	-	9.1%	31.8%	2.62
Сайнцагаан сум	11.5%	13.5%	10.4%	6.3%	29.2%	29.2%	1.85
Өлзийт сум	48.1%	25.9%	7.4%	3.7%	7.4%	7.4%	3.81
Эрдэнэдалай сум	42.9%	17.9%	7.1%	3.6%	14.3%	14.3%	3.29
Өндөршил сум	19.0%	19.0%	9.5%	14.3%	14.3%	23.8%	2.42
Завхан аймаг	23.2%	14.3%	12.5%	10.7%	19.6%	19.6%	2.52
Тэлмэн сум	33.3%	16.7%	10.0%	13.3%	13.3%	13.3%	3.03
Улиастай сум	11.5%	11.5%	15.4%	7.7%	26.9%	26.9%	1.92
Төв аймаг	38.3%	10.6%	17.0%	8.5%	12.8%	12.8%	3.15
Батсүмбэр сум	31.8%	4.5%	22.7%	13.6%	9.1%	18.2%	2.81
Эрдэнэсант сум	44.0%	16.0%	12.0%	4.0%	16.0%	8.0%	3.44
Ховд аймаг	19.8%	15.8%	19.8%	17.8%	16.8%	9.9%	2.74
Мянгад сум	29.2%	16.7%	20.8%	14.6%	12.5%	6.3%	3.17
Жаргалант сум	11.3%	15.1%	18.9%	20.8%	20.8%	13.2%	2.36
Хөвсгөл аймаг	19.3%	15.2%	17.0%	11.1%	20.5%	17.0%	2.51
Арбулаг сум	18.0%	12.0%	24.0%	16.0%	16.0%	14.0%	2.58
Мөрөн сум	13.6%	13.6%	12.1%	9.1%	24.2%	27.3%	2.01
Тосонцэнгэл сум	15.6%	21.9%	12.5%	15.6%	21.9%	12.5%	2.56
Жаргалант сум	43.5%	17.4%	21.7%	-	17.4%	-	3.70
Хэнтий аймаг	32.5%	23.3%	12.5%	14.2%	9.2%	8.3%	3.31
Батноров сум	66.7%	20.8%	8.3%	0.0%	4.2%	0.0%	4.46
Баян-Адарга сум	36.7%	16.7%	6.7%	16.7%	16.7%	6.7%	3.21
Биндэр сум	29.6%	11.1%	14.8%	22.2%	-	22.2%	2.81
Хэрлэн сум	10.3%	38.5%	17.9%	15.4%	12.8%	5.1%	3.03

Сум/Дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ

Дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдлыг дараах хүснэгтэд харууллаа. Улаанбаатар хотын иргэдийн мэдэхгүй гэж хариулсан хувь 27.7 хувьтай байна. Дундаж үнэлгээ 1.70 буюу хангалтгүй гэж үнэлсэн байна. Дүүрэг тус бүрээр задлан харвал Багануур дүүргийн иргэд хамгийн өндрөөр, Хан-Уул дүүргийн иргэд хамгийн багаар үнэлсэн байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, сум/дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдал Улаанбаатар хотод 5.7 хувиар, хөдөө орон нутагт 8.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 25: Дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, дүүргээр, n=501

	Бүгдийг нь мэдээлдэг	Дийлэнхийг нь мэдээлдэг	Тал хувийг нь мэдээлдэг	Цөөн хувийг нь мэдээлдэг	Огт мэдээлдэггүй	Мэдэхгүй/санахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Улаанбаатар хот	9.8%	7.6%	11.4%	13.0%	30.5%	27.7%	1.70
Дүүргээр:							
Багануур	23.1%	30.8%	15.4%	7.7%	7.7%	15.4%	3.08
Багахангай	21.1%	21.1%	15.8%	-	5.3%	36.8%	2.42

Баянгол	9.2%	9.2%	13.2%	17.1%	23.7%	27.6%	1.80
Баянзүрх	1.7%	3.4%	13.6%	8.5%	28.8%	44.1%	1.08
Налайх	9.4%	9.4%	21.9%	21.9%	25.0%	12.5%	2.19
Сонгинохайрхан	11.8%	9.2%	14.5%	15.8%	31.6%	17.1%	2.03
Сүхбаатар	1.4%	4.1%	6.8%	13.7%	49.3%	24.7%	1.21
Хан-Уул	-	7.0%	5.3%	7.0%	42.1%	38.6%	1.00
Чингэлтэй	21.9%	4.2%	8.3%	13.5%	25.0%	27.1%	2.03

Сумын ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдлыг аймаг, сумаар задлан харвал хөдөө орон нутгийн иргэдийн 16.9 хувь нь мэдэхгүй байна, дунджаар 2.55 оноогоор үнэлсэн байна. Аймагуудын хувьд хамгийн өндөр үнэлгээ авсан нь Хэнтий аймаг бөгөөд 3.33 оноо авчээ. Сумаар задлан харвал Хэнтий аймгийн Батноров сумын иргэд хамгийн өндөр буюу 4.33 оноогоор үнэлсэн байна.

Хүснэгт 26: Сумын ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлж буй байдлын талаарх үнэлгээ, сумдаар, n=711

	Бүгдийг нь мэдээлдэг	Дийлэнхий г нь мэдээлдэг	Тал хувийг нь мэдээлдэг	Цөөн хувийг нь мэдээлдэг	Огт мэдээлдэг үй	Мэдэхгүй/с анахгүй байна	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Хөдөө орон нутаг	20.5%	16.0%	15.6%	10.5%	20.4%	16.9%	2.55
Дундговь аймаг	22.7%	16.7%	11.1%	7.4%	19.0%	23.1%	2.47
Адаацаг сум	22.7%	18.2%	9.1%	4.5%	18.2%	27.3%	2.41
Сайнцагаан сум	12.5%	13.5%	8.3%	8.3%	27.1%	30.2%	1.85
Өлзийт сум	44.4%	25.9%	11.1%	3.7%	7.4%	7.4%	3.74
Эрдэнэдалай сум	39.3%	14.3%	25.0%	7.1%	7.1%	7.1%	3.50
Өндөршил сум	19.0%	19.0%	9.5%	14.3%	14.3%	23.8%	2.42
Завхан аймаг	14.3%	16.1%	14.3%	10.7%	25.0%	19.6%	2.25
Тэлмэн сум	23.3%	23.3%	13.3%	10.0%	16.7%	13.3%	2.86
Улиастай сум	3.8%	7.7%	15.4%	11.5%	34.6%	26.9%	1.54
Төв аймаг	17.0%	14.9%	19.1%	8.5%	21.3%	19.1%	2.40
Батсүмбэр сум	18.2%	9.1%	22.7%	-	27.3%	22.7%	2.23
Эрдэнэсант сум	16.0%	20.0%	16.0%	16.0%	16.0%	16.0%	2.56
Ховд аймаг	19.8%	10.9%	19.8%	13.9%	26.7%	8.9%	2.56
Мянгад сум	33.3%	8.3%	14.6%	10.4%	20.8%	12.5%	2.85
Жаргалант сум	7.5%	13.2%	24.5%	17.0%	32.1%	5.7%	2.30
Хөвсгөл аймаг	14.6%	11.7%	20.5%	10.5%	21.6%	21.1%	2.24
Арбулаг сум	16.0%	14.0%	22.0%	12.0%	16.0%	20.0%	2.42
Мөрөн сум	7.6%	6.1%	22.7%	9.1%	25.8%	28.8%	1.75
Тосонцэнгэл сум	6.3%	25.0%	9.4%	9.4%	31.3%	18.8%	2.10
Жаргалант сум	43.5%	4.3%	26.1%	13.0%	8.7%	4.3%	3.48
Хэнтий аймаг	30.0%	25.8%	12.5%	14.2%	13.3%	4.2%	3.33
Батноров сум	54.2%	33.3%	8.3%	-	4.2%	-	4.33
Баян-Адарга сум	30.0%	20.0%	13.3%	20.0%	13.3%	3.3%	3.23
Биндэр сум	29.6%	14.8%	11.1%	11.1%	18.5%	14.8%	2.81
Хэрлэн сум	15.4%	33.3%	15.4%	20.5%	15.4%	-	3.13

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Одоо манайхаас тусгай ном гаргадаг болсон. Асуулт хариулт гэсэн. Энэхүү номоороо хууль дүрэм, журмаа сурталчилдаг. Айл өрхийн тоогоор хийгээд бүх албан хаагчид болон иргэдэд хамааралтай энгийн асуулт хариулт маягаар хийдэг. Хууль, журмын үг хэллэгээр биш аль болох ойлгомжтой хэлбэрээр асуугаад, албан хаагч маань хариулж байгаа маягаар гарын авлага, ном жилд нэг удаа хийж байгаа. Одоо дөрөв дахь товхимол ажил маань хийгдэж байгаа. Энгийн үедээ ч гэсэн иргэдээс гол төлөв асуудаг. Зайлиггүй иргэд мэдэж байх ёстой гэсэн зүйлүүдийг товч тодорхой оруулж өгдөг.

Дундговь аймаг, Өлзийт сум, засаг даргын орлогч

Багийн ИНХ-р, шилийн мэдээ гээд сонин гаргадаг. Улиралд нэг удаа сониноо гаргадаг. Сонин бол зүгээр. Хөдөө бол уулзалт чухал. Төвийнхөнд цахим мэдээлэл нь товчхон, хурдан шуурхай хүрдэг.

Дундговь аймаг, Өндөршил сум, сумын засаг дарга, сумын ИТХ-ын төлөөлөгч

Цаасан мэдээллээр хүмүүст хүрэх нь уг нь зүгээр. Одоо бас залуучууд сошиалаар мэдээлэл авдаг болсон байна. Тэр нь их төвөгтэй, янз бүрийн болох болохгүй мэдээлэл хүрж ирээд байдаг. Ер нь бол цаас нь оновчтой.

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Үйл ажиллагаагаа 3 сувгаар тайлагнаж байна. ИНХ-аар, хэсэгчлэн иргэдтэй уулзах уулзалтаар хийсэн ажлынхаа үр дүнг танилцуулж байна. Сошиалаар хийж байгаа ажлуудаа долоо хонгоор эсвэл сар сараар нь авч байгаа арга хэмжээнүүдээ цаг алдалгүй танилцуулж байна. Эдгээрээс мэдээлэл хамгийн сайн хүрч байгаа нь сошиал байна. Сошиал дээр залуучууд их, хамгийн дээд тал нь 45-50 насны хүмүүс байдаг. Тэрнээс дээш насны хүмүүс сошиалыг нэг их хэрэглэдэггүй. Хэсэгчилсэн уулзалтаар ахмад настнууд илүү мэдээллийг хүлээж авдаг. Дээд газраас ирсэн шийдвэр болон хорооны ИНХ-аас гарч байгаа, засаг даргаас гарч байгаа шийдвэрүүдийг 19 хэсэгтээ тухайн хэсгийн ахлагчаараа дамжуулан аль болох түргэн шуурхай хүргэж ажилладаг.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

Үйл ажиллагаагаа ихэнхдээ сошиалаар танилцуулдаг. Мэдээлэх, зарлан мэдээлэх, болох гэж байгаа үйл явдлын талаар бол орцны мэдээлэх самбар, тухайн оршин суугчид өөрсдөө мэдээлэл солилцох групп гэж байдаг. Бусад хороо, дүүргийг бодоход манайх 120, 19 комбинат гэсэн 11000 дагагчидтай хаалттай групп байдаг. Тэнд тавьж байгаа мэдээлэл миний харж байгаагаар иргэдэд 30-35% -тай хүрээд байх шиг байна. Гаргасан шийдвэр үйл ажиллагааг иргэдэд тийм хэлбэрээр танилцуулж байгаа.

Улаанбаатар хот, ХУД, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч

Зураг 5: Дүүргийн сошиал группийн жишээ, ХУД

120, 19,
комбинатынхан +
Шинэ Хан
Уулынхан
Private group


36
New posts today
678 in the last 30 days

12,882
Members
+113 in the last 30 days

Сум/Дүүргийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандсан байдал

Дүүргийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандсан байдлыг тодруулахад Багахангай дүүргийн иргэд хамгийн өндөр буюу 16 хувьтай хандсан байна. Налайх дүүргийн иргэд хамгийн бага буюу мэдээлэл авахаар огт хандаагүй байна. Улаанбаатар хотын иргэдийн 4 хувь нь дүүргийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандаж байсан байна. Мэдээлэл авахаар хандсан иргэдээс тухайн ИТХ ил тод мэдээлэл өгсөн эсэхийг тодруулахад 77.8 хувь нь тийм, үлдсэн хувь нь үгүй гэж хариулсан байна.

График 22: Дүүргийн ИТХ -аас мэдээлэл авахаар хандсан байдал, n=501



Сум/Дүүргийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлэх байдал

Нийт судалгаанд оролцогчдын 38.1 хувь нь сум/дүүргийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг хэлж мэдэхгүй байна.

Хүснэгт 27: Сум/Дүүргийн ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлэсэн байдал, n=1212

	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Нийт
Мэдэхгүй	51.9%	28.4%	38.1%
Орон нутгийн төсөв батлах	16.4%	31.9%	25.5%
Ус, рашаан булгийн эх хамгаалах тухай	8.0%	28.0%	19.7%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа	6.8%	22.5%	16.0%
Татварын хувь хэмжээ, хураамж тогтоох асуудлууд /хөг хаягдал, буу гэх мэт/	8.2%	20.8%	15.6%
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	11.4%	17.4%	14.9%
Газар нутгийг тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах тухай	6.4%	19.3%	13.9%
Орон нутгийн өмчийг захиран зарцуулах	6.0%	17.9%	13.0%
ОНХС-ийн төсвийг юунд зарцуулах тухай шийдвэр гаргах	4.2%	14.6%	10.3%
Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах	10.2%	10.1%	10.1%
Ойгоос мод бэлтгэх хэмжээ тогтоох	1.4%	14.3%	9.0%
Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоох	2.2%	9.6%	6.5%
Нэрэмжит болгох	8.0%	5.3%	6.4%
Тэгш ой тэмдэглэх	1.8%	7.7%	5.3%
Төрийн шагналд тодорхойлох, шагналд уламжлах	3.2%	6.2%	5.0%
Бусад	1.0%	1.1%	1.1%

Улаанбаатар хотын иргэдийн хамгийн их дурдсан хариултуудыг дүүргээр задлан дараах хүснэгтэд харуулав. Дүүргийн ИТХ-аас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлүүлэхэд нийт иргэдийн 51.9

хувь нь мэдэхгүй байна. “Орон нутгийн төсөв батлах” гэж 16.4 хувь, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах” гэж 11.4 хувь, “Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах” гэж 10.2 хувь нь хариулсан байна.

Хүснэгт 28: Дүүргийн ИТХ-аас гаргасан гол шийдвэрүүдийг нэрлэсэн байдал, дүүргээр, n=501

	Мэдэхгүй	Орон нутгийн төсөв батлах	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах	Татварын хувь хэмжээ, хураамж тогтоох асуудлууд /хог хаягдал, буу гэх мэт/	Ус, рашаан булгийн эх хамгаалах тухай
Улаанбаатар хот	51.9%	16.4%	11.4%	10.2%	8.2%	8.0%
<i>Дүүргээр:</i>						
Багануур	-	30.8%	-	46.2%	15.4%	38.5%
Багахангай	21.1%	57.9%	21.1%	5.3%	5.3%	10.5%
Баянгол	27.6%	30.3%	14.5%	19.7%	7.9%	6.6%
Баянзүрх	79.7%	5.1%	8.5%	5.1%	11.9%	6.8%
Налайх	6.3%	28.1%	6.3%	25.0%	6.3%	9.4%
Сонгинохайрхан	40.8%	14.5%	25.0%	11.8%	17.1%	13.2%
Сүхбаатар	71.2%	9.6%	8.2%	1.4%	4.1%	-
Хан-Уул	66.7%	12.3%	5.3%	7.0%	1.8%	5.3%
Чингэлтэй	67.7%	7.3%	7.3%	4.2%	6.3%	8.3%

- **ИТХ-аас гаргасан шийдвэрүүдийн оновчтой байдал:** Гол оролцогч талуудын үзэж буйгаар ИТХ-аас гаргасан шийдвэрүүд оновчтой боловч зарим тохиолдолд өөрийн эрх ашгийн төлөө шийдвэр гаргах зүйл ажиллагддаг байна. Жишээлбэл, хөдөө орон нутагт малчид ИТХ-ын төлөөлөгчид олноор сонгогддог. Тэдгээр малчид гол төлөв бага дунд боловсролтой бөгөөд иргэдээс ирсэн саналуудыг эрэмбэлэхдээ бодлогын шинж чанартай асуудлаас илүүтэй өөрсдөдөө ашигтай малын бэлчээр, худаг ус гаргахтай холбоотой асуудалд илүү анхаарал хандуулдаг нь ажиглагддаг байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Жил болгон манайх нэг зорилт барьж ажилладаг. Энэ жилийг иргэдийн амьдрах орчныг сайжруулах жил гэж зарласан. Орцноосоо гараад бидний 2 дахь амьдрах орчин эхэлдэг. Тийм учраас гэрэлтүүлэг, ногоон байгууламж, орон сууцны орц, дээвэр, хүүхдийн тоглоомын талбай гээд гудамжаар явбал бүх байрны асуудал шийдэгдсэн байгаа. Иргэдийн оролцоо санал бодол энэ бүх үйл ажиллагаанд туссан.

Багануур дүүрэг, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч

ИНХ нь хорооны ахмадууд, өндөр настнуудаас төрийн одон медальд уламжлагдаж чадахгүй байгаа иргэдийг төрийн одон медальд уламжлуулах тал дээр түлхүү анхаарч ажилладаг. Манай хорооны нэг онцлог нь газар дахин төлөвлөлтөөр орон сууцжуулах хөтөлбөр нэлээн олон жил явагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор барилгатай холбоотой тулгамдсан асуудлууд их байдаг. Тэрний нэг жишээ нь Амгаланд нэг булаг гардаг тэр нь цэвэр усны хамгаалалтын бүс байдаг. Тэнд барилгын шороо асгах гэсэн хулгайн тээвэр их байдаг. Үүнийг нэг мөр арилгаж шийдвэрлэх зорилготойгоор нийтийн бүс болгон цэцэрлэгт хүрээлэн байгуулан цэцэрлэгжүүлэх ажлын талаар шийдвэр гаргасан. Энд дүүргийн засаг, ИТХ-тай хамтран тус газрыг хамгаалалтад авах, газар дээр газрын бүтэц, усны хайгуул шинжилгээний ажлыг дүүргийн захиалгаар хийлгүүлэх зардлыг шийдүүлсэн. Одоо цаашид ногоон байгууламжуудыг байгуулах, иргэдийг тав тухтай амраах бүтээн байгуулалтуудын саналыг авах ажлыг хийнэ. Тэгээд дараа оны төсөвт суулгах ажлуудыг хийж байна. Энэ нь иргэдийн санал хүсэлт дээр үндэслэн ИНХ-аас гаргаж байгаа шийдвэр юм. Иймэрхүү үйл ажиллагааг иргэд сайнаар хүлээж авч байгаа. Сөрөг хандлага байх нь ч бий. Тиймэрхүү цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн амарч зугаалах газрыг байгуулъя гэхээр наадах чинь дэмий архирид цугладаг газрыг бэлтгэж өгөх гээд байна гэдэг. Аль аль талдаа хяналтыг нь сайжруулаад өгвөл иргэдэд чиглэсэн ажил учраас үр дүнгээ өгөх байх гэж бодож байна.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

2019 онд дүүргийн иргэдийн хурал засаг даргын үйл ажиллагааны үндсэн чиглэл нэлээн хэдэн дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа. Тэдний хүрээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамааруулах, хүн болох багаасаа гэх мэт дүүргийн засаг даргын бөгөөд иргэдийн хурлаас дэвшүүлсэн дэд хөтөлбөрүүд иргэддээ нэлээн таниулж ажилласан. Тухайн дэд хөтөлбөр ч юм уу иргэдийн хурлаас гарч байгаа шийдвэрүүдэд иргэдийн саналыг 80-90 хувьтай тусгаж байгаа.

Улаанбаатар хот, СХД, дүүргийн ИТХ-ын дарга

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж ажлуудад иргэдээс санал авах, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн тайланг цагдаа хүчний байгууллагатай хэлэлцээд шийдвэр гаргах, хорооны иргэдийг шагналд нэр дэвшүүлэх зэрэг ажлуудыг хийсэн.

Улаанбаатар хот, ХУД, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч

Сумын ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүдийг сумдаар задлан дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 29: Сумын ИТХ -аас гаргасан гол шийдвэрүүд, n=711

	Орон нутгийн төсөв батлах	Мэдэхгүй	Ус, рашаан булгийн эх хамгаалах тухай	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа	Татварын хувь хэмжээ, хураамж тогтоох асуудлууд	Газар нутгийг тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах тухай
Хөдөө орон нутаг	31.9%	28.4%	28.0%	22.5%	20.8%	19.3%
<i>Дундговь аймаг</i>						
Адаацаг сум	34.1%	56.8%	20.5%	11.4%	13.6%	15.9%
Сайнцагаан сум	18.8%	68.8%	8.3%	6.3%	4.2%	15.6%
Өлзийт сум	40.7%	48.1%	18.5%	29.6%	14.8%	14.8%
Эрдэнэдалай сум	39.3%	25.0%	32.1%	28.6%	21.4%	28.6%
Өндөршил сум	14.3%	76.2%	4.8%	4.8%	9.5%	-
<i>Завхан аймаг</i>						
Тэлмэн сум	20.0%	30.0%	43.3%	43.3%	23.3%	30.0%
Улиастай сум	26.9%	61.5%	23.1%	3.8%	-	26.9%
<i>Төв аймаг</i>						
Батсүмбэр сум	40.9%	45.5%	18.2%	13.6%	22.7%	18.2%
Эрдэнэсант сум	36.0%	-	52.0%	32.0%	20.0%	4.0%
<i>Ховд аймаг</i>						
Мянгад сум	41.7%	-	45.8%	39.6%	16.7%	33.3%
Жаргалант сум	41.5%	1.9%	28.3%	24.5%	24.5%	13.2%
<i>Хөвсгөл аймаг</i>						
Арбулаг сум	32.0%	28.0%	32.0%	30.0%	26.0%	28.0%
Мөрөн сум	19.7%	-	15.2%	13.6%	18.2%	13.6%
Тосонцэнгэл сум	34.4%	25.0%	46.9%	28.1%	18.8%	9.4%
Жаргалант сум	39.1%	17.4%	43.5%	34.8%	43.5%	21.7%
<i>Хэнтий аймаг</i>						
Батноров сум	75.0%	-	66.7%	50.0%	41.7%	41.7%
Баян-Адарга сум	30.0%	16.7%	13.3%	23.3%	36.7%	23.3%
Биндэр сум	40.7%	29.6%	44.4%	25.9%	40.7%	22.2%
Хэрлэн сум	23.1%	-	28.2%	20.5%	38.5%	12.8%

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Иргэдийн хурлаар орон нутгийн төсвийг баталдаг. Улсаас төсвийг нь шууд тогтоогоод өгчихдөг учраас яг оролцоогоороо нэмж хасах шийдвэрийг тухайн сумын иргэдийн хурал шийдэж чадахгүй байгаа. Батлах гэдэг бэлгэдлийн чанартай юм болдог. Яг батална гэдэг нь хүрэлцэхгүй байгаа төсөв дээр энийг нэмж үр ашиг багатайгаас нь хасъя гэж иргэд боддог. Гэтэл яг орон нутгийн сумын иргэдийн хурал бол цаанаасаа батлагдсан төсвийг хойш урагш нь болгодог. Одоо тулгамдаж байгаа асуудал ажилгүй иргэд нэлээд их байгаа.

Дундговь аймаг, Өлзийт сум, засаг даргын орлогч

Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл хэрэгжилт, төсвийг тооцохоос гадна залуучуудыг дэмжих хөтөлбөр гэж батлагдсан. Залуучуудын чуулга зохион байгуулсан. УБ хотод бас залуучуудтайгаа уулзалт хийгдсэн. Тэндээс гарсан саналуудаас ажил хэрэг болгох нь хөтөлбөрт туссан.

Дундговь аймаг, Өндөршил сум, сумын засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч

Ногоон Тосонцэнгэл хөтөлбөр, эрүүл Тосонцэнгэл хөтөлбөр маань манай сумын иргэдийн хурлаас гаргасан ихээхэн том шийдвэрүүдийн нэг байх гэж боддог. Эрүүл Тосонцэнгэл хөтөлбөр маань шүдний эмч, хүний эмч нар урьж авчирч ажиллуулсан. Их уул гээд ойрхон сумдын иргэдтэй бас хамтарч ажиллаж байгаа. Ер нь бол эрүүл мэндийн үзлэг оношилгоонд иргэдээ манай сум хамруулсан. Ногоон Тосонцэнгэл хөтөлбөрийн хүрээнд мод тарих аяныг ихээхэн үр бүтээлтэй, далайцтай өрнүүлж Тосонцэнгэл сумын тоосжилтыг багасгах тал дээр хурлаас гаргасан том шийдвэрүүдийн нэг гэж боддог. Дээр нь хурлаас гаргаж байгаа том шийдвэрүүд багууд дээр гаргаж байгаа худаг усны, малын байрны асуудлууд, сумууд дээр хийгдэж түлээ модны асуудал, байгалийн баялаг багатай учир байгаа түлээ модоо хайрлах энэ дээр гаргаж байгаа байгаль хамгаалах сантай ажиллаж, дээр нь хурлаас гаргаж байгаа байгууллага болгон дээр ажиллаж байгаа ажлууд үр өгөөжтэй байгаа.

Завхан аймаг, Улиастай сум, ИТХ-ын тэргүүлэгч

2019 оныг аймгаас гэр бүл, хүүхдийн хөгжлийг дэмжих жил гэж зарласан. Сумаас болохоор төрийн үйлчилгээг дэмжиж, сэтгэл санааг засах жил гэж зарласан байгаа. Тэр жилийнхээ хүрээнд иргэд хоорондын уялдаа, нэг нь нийтийн төлөө аян нь манай 2019 оны зорилго байсан. Үүнд иргэдийн санал туссан. Энэ аяны хүрээнд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн гишүүдтэй 6 баг болоод үйл ажиллагаагаа танилцуулж байсан. Сүүлд нь төвийн баг дээрээ хаалтаа хийж мэдээлэл солилцож, уралдаан зарласан. Багийн иргэд нэгэндээ туслах, санхүүгийн дэмжлэг болох тал дээр нь ажилласан.

Хөвсгөл аймаг, Жаргалан сум, засаг даргын орлогч, ИТХ-ын төлөөлөгч

Сум/Дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлэх байдал

Сум/дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг дараах байдлаар үнэлсэн байна. Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийг харьцуулан харвал хөдөө орон нутгийн иргэд сумын ИТХ -ын үйл ажиллагааг илүү сайн үнэлсэн байна. Сумдын хувьд Хэнтий аймгийн Батноров сумын иргэд сумын ИТХ -ын үйл ажиллагааг хамгийн өндрөөр үнэлсэн байна. Харин Дундговь аймгийн Сайнцагаан сумын иргэд хамгийн бага үнэлгээ өгсөн байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, сум/дүүргийнхээ ИТХ -ын үйл ажиллагааг “маш сайн” болон “зарим талаар сайн” гэж үнэлэх байдал Улаанбаатар хотод 1 хувиар өсөж, хөдөө орон нутагт 1.1 хувиар буурсан байна.

Дүүргүүдийн хувьд авч үзвэл Налайх дүүргийн иргэд дүүргийн ИТХ -ын үйл ажиллагаагаа хамгийн өндрөөр үнэлсэн байна. Баянзүрх дүүргийн иргэд хамгийн бага үнэлсэн байна. Насны бүлгээр авч үзвэл 18-24 насны бүлэг хамгийн өндрөөр, 25-34 насны бүлэг хамгийн багаар үнэлжээ. Хүйсийн хувьд эмэгтэй оролцогчид илүү өндөр үнэлсэн байна.

Хүснэгт 30: Сум/дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг үнэлэх байдал, n=1212

	Маш сайн	Зарим талаар сайн	Дунд	Зарим талаар муу	Маш муу	Мэдэхгүй /санахгүй байна	Хариулахаас татгалзсан	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Аймаг/хот:								
Улаанбаатар хот	7.0%	12.8%	35.9%	6.6%	16.2%	20.6%	1.0%	2.23
Хөдөө орон нутаг	11.3%	21.8%	37.6%	5.3%	11.0%	12.8%	0.3%	2.78
Дүүргээр:								
Багануур	15.4%	23.1%	30.8%	7.7%	7.7%	15.4%	-	2.85
Багахангай	26.3%	15.8%	21.1%	5.3%	21.1%	10.5%	-	2.89
Баянгол	5.3%	22.4%	35.5%	9.2%	11.8%	13.2%	2.6%	2.53
Баянзүрх	1.7%	1.7%	33.9%	6.8%	18.6%	35.6%	1.7%	1.49
Налайх	15.6%	18.8%	50.0%	3.1%	9.4%	3.1%	-	3.19
Сонгинохайрхан	9.2%	9.2%	43.4%	5.3%	15.8%	15.8%	1.3%	2.39
Сүхбаатар	1.4%	11.0%	34.2%	12.3%	20.5%	19.2%	1.4%	1.99
Хан-Уул	1.8%	12.3%	29.8%	1.8%	26.3%	28.1%	-	1.77
Чингэлтэй	9.4%	12.5%	35.4%	5.2%	11.5%	26.0%	-	2.25
Аймаг, сумдаар:								
Дундговь	12.0%	17.1%	32.4%	5.6%	14.4%	18.5%	-	2.51
Адаацаг сум	18.2%	13.6%	38.6%	6.8%	9.1%	13.6%	-	2.84
Сайнцагаан сум	5.2%	12.5%	32.3%	5.2%	17.7%	27.1%	-	2.01
Өлзийт сум	18.5%	37.0%	22.2%	7.4%	3.7%	11.1%	-	3.26
Эрдэнэдалай сум	17.9%	28.6%	21.4%	7.1%	21.4%	3.6%	-	3.04
Өндөршил сум	14.3%	4.8%	47.6%	-	14.3%	19.0%	-	2.48
Завхан								
Тэлмэн сум	13.3%	26.7%	26.7%	3.3%	10.0%	16.7%	3.3%	2.70
Улиастай сум	7.7%	7.7%	42.3%	-	7.7%	34.6%	-	2.04
Төв								
Батсүмбэр сум	27.3%	13.6%	45.5%	-	13.6%	-	-	3.41
Эрдэнэсант сум	12.0%	20.0%	44.0%	-	12.0%	8.0%	4.0%	2.84
Ховд								
Мянгад сум	8.3%	29.2%	41.7%	4.2%	14.6%	2.1%	-	3.06
Жаргалант сум	3.8%	18.9%	37.7%	13.2%	13.2%	13.2%	-	2.47
Хөвсгөл								
Арбулаг сум	6.0%	22.0%	54.0%	6.0%	4.0%	8.0%	-	2.96
Мөрөн сум	4.5%	21.2%	42.4%	3.0%	13.6%	15.2%	-	2.54
Тосонцэнгэл сум	3.1%	28.1%	37.5%	12.5%	12.5%	6.3%	-	2.78
Жаргалант сум	4.3%	26.1%	39.1%	4.3%	8.7%	17.4%	-	2.61

	Маш сайн	Зарим талаар сайн	Дунд	Зарим талаар муу	Маш муу	Мэдэхгүй /санахгүй байна	Хариула хаас татгалзса н	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Хэнтий	20.8%	30.0%	34.2%	5.0%	4.2%	5.8%	-	3.41
Батноров сум	45.8%	33.3%	20.8%	-	-	-	-	4.25
Баян-Адарга сум	23.3%	30.0%	30.0%	3.3%	3.3%	10.0%	-	3.36
Биндэр сум	14.8%	25.9%	33.3%	3.7%	11.1%	11.1%	-	2.96
Хэрлэн сум	7.7%	30.8%	46.2%	10.3%	2.6%	2.6%	-	3.24
Насны бүлэг:								
18-24	12.8%	23.0%	34.8%	3.2%	7.5%	17.6%	1.1%	2.74
25-34	6.8%	16.8%	33.8%	8.8%	11.2%	22.1%	0.6%	2.31
35-44	10.6%	19.2%	33.6%	6.2%	16.4%	13.0%	1.0%	2.59
45-54	8.8%	15.9%	44.2%	2.2%	14.6%	14.2%	-	2.60
55-64	10.2%	16.2%	41.3%	7.2%	15.6%	9.6%	-	2.69
Хүйс:								
Эрэгтэй	8.6%	17.2%	37.5%	6.1%	16.3%	13.8%	0.5%	2.53
Эмэгтэй	10.3%	18.9%	36.3%	5.6%	10.0%	18.2%	0.7%	2.57
Нийт	9.5%	18.1%	36.9%	5.9%	13.1%	16.0%	0.6%	2.55

Сум/дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг “Маш сайн” болон “Зарим талаараа сайн” гэж үнэлсэн иргэдээс шалтгааныг тодруулахад,

- Мэдээлэл сайн өгдөг
- Ажлаа сайн хийдэг
- Иргэдтэйгээ тулж ажилладаг
- Хийж байгаа ажил нь нүдэнд ил харагддаг
- Ард иргэдийг сонсдог
- Тохижилт үйлчилгээний ажил хийдэг
- Дэд бүтэц барилга байгууламж барьдаг
- Зам талбай, тохижилтын ажлууд хийдэг
- Иргэдийн хуралдаа гишүүд сайн оролцдог
- Мэдээлэл хүсэхэд сайн өгдөг
- Нүхэн гарц, гүүрэн гарц бий болсон
- Нийтийн тээвэр сайжирсан зэрэг жишээг дурдаж байв.

Сум/дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг “Маш муу” болон “Зарим талаараа муу” гэж үнэлсэн иргэдээс шалтгааныг тодруулахад,


- Мэдээлэл байхгүй
- Ажлаа муу тайлагнадаг
- Ажлаа сайн хийдэггүй
- Ард иргэдтэйгээ харьцдаггүй
- Зам гэрэлтүүлэг сайжирсан ч өөр олон тулгамдсан асуудал байна

ИРГЭД МЭДЭХГҮЙ УЧРААС, МЭДЭЭЛЭЛГҮЙ УЧРААС “маш муу” болон “зарим талаар муу” гэж үнэлж байна.

Сумын ИТХ орон нутагт татвар тогтоох боломжтой байх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал

Судалгаанд хамрагдсан иргэдээс сумын ИТХ орон нутагт татвар тогтоох боломжтой байх ёстой гэдэгтэй санал нийлж буй эсэхийг тодруулахад хөдөө орон нутгийн иргэд илүү санал нийлж байна.

График 23: Сумын ИТХ орон нутагт татвар тогтоох боломжтой байх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал, n=1212



Дээрх үзүүлэлтийг сум, дүүргээр задлан дараах хүснэгтэд харууллаа. Дүүргүүдийн хувьд Налайх дүүргийн иргэд хамгийн их санал нийлж байгаа бол Баянзүрх дүүргийн иргэд хамгийн бага санал нийлж байна. Сумын хувьд авч үзвэл Завхан аймгийн Тэлмэн сумын иргэд хамгийн их санал нийлж байна. Харин Дундговь аймгийн Өндөршил сумын иргэд хамгийн бага санал нийлж байна.

Хүснэгт 31: Сумын ИТХ орон нутагт татвар тогтоох боломжтой байх ёстой гэдэгтэй санал нийлэх байдал, аймаг, сум, дүүргээр, n=1212

	Бүрэн санал нийлж байна	Санал нийлж байна	Дунд зэрэг	Санал нийлэхгүй байна	Огт санал нийлэхгүй байна	Хариулах аас татгалзсан	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Аймаг/хот:							
Улаанбаатар хот	11.4%	23.4%	10.6%	21.8%	27.5%	5.4%	2.53
Хөдөө орон нутаг	14.8%	24.2%	16.7%	17.7%	16.9%	9.7%	2.73
Дүүргээр:							
Багануур	15.4%	30.8%	7.7%	23.1%	23.1%	0.0%	2.92
Багахангай	10.5%	21.1%	10.5%	21.1%	31.6%	5.3%	2.42
Баянгол	13.2%	27.6%	21.1%	13.2%	21.1%	3.9%	2.87
Баянзүрх	5.1%	20.3%	5.1%	22.0%	40.7%	6.8%	2.07
Налайх	40.6%	28.1%	12.5%	9.4%	3.1%	6.3%	3.75
Сонгинохайрхан	9.2%	14.5%	14.5%	39.5%	17.1%	5.3%	2.43
Сүхбаатар	9.6%	24.7%	6.8%	9.6%	42.5%	6.8%	2.29
Хан-Уул	8.8%	24.6%	3.5%	22.8%	35.1%	5.3%	2.33
Чингэлтэй	8.3%	25.0%	9.4%	27.1%	25.0%	5.2%	2.49
Аймаг, сумдаар:							
Дундговь	8.8%	31.5%	9.7%	19.4%	17.6%	13.0%	2.56
Адаацаг сум	6.8%	36.4%	13.6%	18.2%	13.6%	11.4%	2.70
Сайнцагаан сум	7.3%	30.2%	3.1%	22.9%	21.9%	14.6%	2.34
Өлзийт сум	18.5%	33.3%	11.1%	14.8%	7.4%	14.8%	2.96
Эрдэнэдалай сум	10.7%	35.7%	25.0%	7.1%	14.3%	7.1%	3.00
Өндөршил сум	4.8%	19.0%	9.5%	28.6%	23.8%	14.3%	2.10
Завхан	26.8%	21.4%	19.6%	16.1%	14.3%	1.8%	3.25
Тэлмэн сум	30.0%	33.3%	13.3%	10.0%	13.3%	0.0%	3.57
Улиастай сум	23.1%	7.7%	26.9%	23.1%	15.4%	3.8%	2.88
Төв	14.9%	27.7%	17.0%	14.9%	14.9%	10.6%	2.81
Батсүмбэр сум	27.3%	22.7%	13.6%	4.5%	13.6%	18.2%	2.91
Эрдэнэсант сум	4.0%	32.0%	20.0%	24.0%	16.0%	4.0%	2.72

Ховд	9.9%	20.8%	21.8%	29.7%	11.9%	5.9%	2.69
Мянгад сум	12.5%	31.3%	20.8%	20.8%	10.4%	4.2%	3.02
Жаргалант сум	7.5%	11.3%	22.6%	37.7%	13.2%	7.5%	2.40
Хөвсгөл	18.1%	18.7%	18.7%	12.3%	21.1%	11.1%	2.67
Арбулаг сум	14.0%	22.0%	22.0%	14.0%	22.0%	6.0%	2.74
Мөрөн сум	13.6%	18.2%	9.1%	19.7%	22.7%	16.7%	2.30
Тосонцэнгэл сум	34.4%	6.3%	28.1%	3.1%	18.8%	9.4%	3.06
Жаргалант сум	17.4%	30.4%	26.1%	0.0%	17.4%	8.7%	3.04
Хэнтий	19.2%	21.7%	20.8%	14.2%	15.8%	8.3%	2.89
Батноров сум	29.2%	25.0%	20.8%	8.3%	8.3%	8.3%	3.33
Баян-Адарга сум	13.3%	33.3%	30.0%	3.3%	10.0%	10.0%	3.07
Биндэр сум	18.5%	18.5%	14.8%	14.8%	18.5%	14.8%	2.59
Хэрлэн сум	17.9%	12.8%	17.9%	25.6%	23.1%	2.6%	2.69
Нийт	13.4%	23.8%	14.2%	19.4%	21.3%	7.9%	2.65

2.3.5. Иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох байдал

Иргэдийн оролцохыг хүсэж буй шийдвэр гаргах ажиллагааны төрөл

Судалгаанд хамрагдсан иргэд олон нийтээс ИТХ -ын ямар шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй байгаа талаар тодруулахад, нэгдүгээрт “Ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар” оролцох хүсэлтэй байна. Энэ нь хөдөө орон нутагт илүү өндөр хувьтай байна. Хоёрдугаарт “Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар” оролцох хүсэлтэй байгаа бөгөөд Улаанбаатар хотод илүү өндөр хувьтай байна. Гуравдугаарт, “Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар” оролцох хүсэлтэй байна. Тус үзүүлэлт нь Улаанбаатар хотод илүү өндөр хувьтай байна.

Хүснэгт 32: Иргэдийн оролцохыг хүсэж буй шийдвэр гаргах ажиллагаа, n=1212

	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Нийт
Ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар	37.3%	43.6%	41.0%
Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар	40.7%	39.7%	40.1%
Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар	27.1%	24.3%	25.5%
Нийгмийн эмзэг бүлэг, ядуу болон нэн ядуу иргэдийн амьдрал ахуйг анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэх талаар	22.0%	27.4%	25.2%
Залуучуудын асуудлаар	15.6%	20.3%	18.3%
Орон сууцны асуудлаар	23.4%	11.7%	16.5%
Орон нутгийн дэд бүтцийн талаар /зам, талбай, гэрэлтүүлэг, цахилгаан эрчим хүч, тохижилт үйлчилгээ гэх мэт/	22.2%	12.4%	16.4%
Байгаль орчны асуудлаар	15.0%	16.2%	15.7%
Зээлд хамрагдах хүсэлтэйгээр /ЖДҮ-ийг дэмжих төслийн хүрээнд г.м/	14.2%	16.7%	15.7%
Орон нутгийн, улс орны хөгжлийн асуудлаар хэлэлцэж, санаа бодлоо хуваалцах	14.8%	15.5%	15.2%
Хогны менежментийн асуудлаар	15.8%	14.1%	14.8%
Газрын асуудлаар	13.4%	14.9%	14.3%
Сайн бодлого, зөв шийдвэр гаргахад өөрийн саналаа хуваалцах	11.8%	12.9%	12.5%
Тэтгэвэр тэтгэмжийн асуудлаар	14.2%	11.3%	12.5%
Усан хангамжийн асуудлаар	8.6%	11.5%	10.3%
Гэнэтийн аюул, ослын асуудлаар	9.0%	9.7%	9.4%
Огт хүсэхгүй байна	9.2%	9.0%	9.1%
ИТХ -ын төсөв батлах үйл явцад оролцох	9.0%	9.0%	9.0%
Нийтийн тээврийн асуудлаар	9.4%	7.0%	8.0%
Хэлж мэдэхгүй	6.4%	4.2%	5.1%
Шилжилт хөдөлгөөний асуудлаар	5.2%	3.4%	4.1%
Бусад	1.8%	1.3%	1.5%
Хариулахаас татгалзсан	1.4%	0.8%	1.1%

Улаанбаатар хотын иргэдийн нэн тэргүүнд оролцох хүсэлтэй байгаа таван асуудлыг дүүргээр задлан дараах хүснэгтэд харууллаа. Улаанбаатар хотын иргэд ИТХ -ын эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаанд илүү оролцох хүсэлтэй байна. Тэр дундаа Багануур дүүргийн иргэдийн 61.5 хувь нь эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй байна.

Хүснэгт 33: Улаанбаатар хотын иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол 5 үйл ажиллагаа, дүүргээр, n=501

	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар	Ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар	Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар	Орон сууцны асуудлаар	Орон нутгийн дэд бүтцийн талаар
Улаанбаатар хот	40.7%	37.3%	27.1%	23.4%	22.2%
Дүүргээр:					
Багануур	61.5%	61.5%	30.8%	15.4%	15.4%
Багахангай	36.8%	47.4%	42.1%	36.8%	10.5%
Баянгол	53.9%	51.3%	36.8%	35.5%	30.3%
Баянзүрх	37.3%	37.3%	25.4%	22.0%	28.8%
Налайх	31.3%	46.9%	25.0%	15.6%	6.3%

Сонгинохайрхан	43.4%	43.4%	17.1%	25.0%	15.8%
Сүхбаатар	43.8%	35.6%	32.9%	30.1%	24.7%
Хан-Уул	42.1%	29.8%	29.8%	22.8%	24.6%
Чингэлтэй	28.1%	18.8%	19.8%	9.4%	21.9%

Сумын иргэдийн оролцохыг хүсэж буй гол таван ажлыг сумдаар задлан дараах хүснэгтэд харууллаа. Сумын иргэд ажлын байрыг нэмэгдүүлэх асуудалд илүү их анхаарал хандуулж байгаа бөгөөд Завхан аймгийн Улиастай сумын иргэдийн 69.2 хувь нь тус асуудалд анхаарлаа хандуулж байна.

Хүснэгт 34: Сумын иргэдийн ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол 5 үйл ажиллагаа, дүүргээр, n=711

	Ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар	Нийгмийн эмзэг бүлэг, ядуу болон нэн ядуу иргэдийн амьдрал ахуйг анхаарч, тусламж дэмжлэг үзүүлэх талаар	Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар	Залуучуудын асуудлаар
Хөдөө орон нутаг	43.6%	39.7%	27.4%	24.3%	20.3%
Дундговь аймаг					
Адаацаг сум	38.6%	18.2%	20.5%	22.7%	22.7%
Сайнцагаан сум	28.1%	26.0%	17.7%	25.0%	16.7%
Өлзийт сум	33.3%	14.8%	11.1%	11.1%	18.5%
Эрдэнэдалай сум	50.0%	28.6%	25.0%	14.3%	7.1%
Өндөршил сум	14.3%	19.0%	4.8%	0.0%	19.0%
Завхан аймаг					
Тэлмэн сум	63.3%	53.3%	40.0%	30.0%	50.0%
Улиастай сум	69.2%	38.5%	34.6%	3.8%	30.8%
Төв аймаг					
Батсүмбэр сум	31.8%	36.4%	27.3%	22.7%	13.6%
Эрдэнэсант сум	64.0%	48.0%	20.0%	16.0%	8.0%
Ховд аймаг					
Мянгад сум	50.0%	54.2%	45.8%	33.3%	8.3%
Жаргалант сум	41.5%	52.8%	30.2%	43.4%	7.5%
Хөвсгөл аймаг					
Арбулаг сум	46.0%	50.0%	24.0%	32.0%	36.0%
Мөрөн сум	50.0%	42.4%	19.7%	15.2%	21.2%
Тосонцэнгэл сум	53.1%	65.6%	12.5%	31.3%	31.3%
Жаргалант сум	47.8%	52.2%	30.4%	47.8%	34.8%
Хэнтий аймаг					
Батноров сум	54.2%	62.5%	62.5%	29.2%	25.0%
Баян-Адарга сум	26.7%	26.7%	23.3%	16.7%	10.0%
Биндэр сум	44.4%	37.0%	37.0%	18.5%	14.8%
Хэрлэн сум	43.6%	35.9%	51.3%	25.6%	20.5%

Судалгаанд оролцогчдоос ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд ямар байдлаар оролцох хүсэлтэй байгаа талаар тодруулахад нэгдүгээрт, хурал цуглаанд оролцох байдлаар, хоёрдугаарт, цахим хэлбэрээр санал өгөх, гуравдугаарт баг/хорооны засаг даргаар дамжуулж санал өгөх байдлаар оролцох хүсэлтэй байна. Улаанбаатар хотын иргэдийн 8.4 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 5.3 хувь нь огт оролцохыг хүсэхгүй байна.

Хүснэгт 35: ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй хэлбэр, n=1212

	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Нийт
Огт оролцохыг хүсэхгүй байна	8.4%	5.3%	6.6%
Хурал цуглаанд оролцох	26.7%	43.9%	36.8%
Цахим хэлбэрээр санал өгөх	32.9%	21.0%	25.9%
Багийн/Хорооны засаг даргаар дамжуулж санал өгөх	12.4%	30.9%	23.3%

Санал асуулга, судалгаанд оролцох	19.0%	18.8%	18.9%
Нээлттэй утсаар саналаа хэлэх	15.8%	15.5%	15.6%
Нээлттэй, хэлэлцүүлэг, ярилцлагад оролцож саналаа хэлэх	10.4%	10.1%	10.2%
Багийн ИНХ -аар дамжуулж саналаа уламжлах	2.4%	15.6%	10.1%
Хороо, хэсгийн ахлагчаар дамжуулан саналаа уламжлах	14.8%	6.8%	10.1%
Саналын хайрцагээр саналаа хэлэх	10.2%	9.3%	9.7%
Өдөрлөг, олон нийтийн арга хэмжээний явцад саналаа хэлэх	7.4%	10.0%	8.9%
Иргэний танхимаар дамжуулж саналаа хэлэх	6.4%	9.1%	8.0%
Телевизийн шууд нэвтрүүлгийн үеэр саналаа хэлэх	7.4%	4.8%	5.9%
Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж санал өгөх	3.4%	5.6%	4.7%
Төрийн дээд болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлэх	4.4%	2.7%	3.4%
Гарын үсэг цуглуулах замаар	3.8%	2.8%	3.2%
Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд санал бодлоо илэрхийлэх	3.4%	2.7%	3.0%
Иргэний нийгмийн байгууллагаар дамжуулж саналаа хэлэх	2.4%	2.8%	2.6%
Жагсаал цуглаанаар	3.2%	1.1%	2.0%
Бусад	0.8%	0.4%	0.6%
Хэлж мэдэхгүй	4.6%	3.8%	4.1%
Хариулахаас татгалзсан	1.2%	0.3%	0.7%

Улаанбаатар хотын иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол таван арга замыг дүүргээр задлав. Улаанбаатар хотын иргэдийн хувьд цахим хэлбэрээр санал өгөх сонирхол хамгийн өндөр байна. Нэн ялангуяа Багануур, Баянгол, Налайх, Хан-Уул зэрэг дүүргийн иргэд цахим хэлбэрээр оролцохыг 40 гаруй хувьтай дэмжиж байна. Багахангай, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн иргэдийн хувьд хурал цуглаанд оролцох сонирхол хамгийн өндөр байна.

Хүснэгт 36: Улаанбаатар хотын иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол таван хэлбэр, дүүргээр, n=501

	Цахим хэлбэрээр санал өгөх	Хурал цуглаанд оролцох	Санал асуулга, судалгаанд оролцох	Нээлттэй утсаар саналаа хэлэх	Хороо, хэсгийн ахлагчаар дамжуулан саналаа уламжлах
Улаанбаатар	32.9%	26.7%	19.0%	15.8%	14.8%
<i>Дүүргээр:</i>					
Багануур	46.2%	23.1%	15.4%	7.7%	15.4%
Багахангай	15.8%	42.1%	21.1%	15.8%	5.3%
Баянгол	44.7%	22.4%	32.9%	31.6%	35.5%
Баянзүрх	25.4%	23.7%	15.3%	15.3%	15.3%
Налайх	43.8%	15.6%	9.4%	15.6%	15.6%
Сонгинохайрхан	17.1%	43.4%	9.2%	7.9%	5.3%
Сүхбаатар	39.7%	20.5%	24.7%	11.0%	8.2%
Хан-Уул	42.1%	17.5%	14.0%	19.3%	10.5%
Чингэлтэй	28.1%	30.2%	19.8%	12.5%	14.6%

Хөдөө орон нутгийн иргэдийн хувьд дээрх үзүүлэлт харьцангуй өөр байна. Хөдөө орон нутгийн иргэдийн 40 гаруй хувьд хурал цуглаанд оролцох нь илүү таалагдаж байна. Хэнтий аймгийн иргэд баг/хорооны засаг даргаар дамжуулж саналаа өгөх сонирхол хамгийн өндөр байна. Тодруулбал, Батноров сумын иргэдийн 62.5 хувь нь баг/хорооны засаг даргаар дамжуулж санал өгөх сонирхолтой гэж хариулсан байна.

Хүснэгт 37: Хөдөө орон нутгийн иргэдийн ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй гол таван хэлбэр, дүүргээр, n=711

	Хурал цуглаанд оролцох	Багийн/Хорооны засаг даргаар дамжуулж санал өгөх	Цахим хэлбэрээр санал өгөх	Санал асуулга, судалгаанд оролцох	Багийн ИНХ -аар дамжуулж саналаа уламжлах
Хөдөө орон нутаг	43.9%	30.9%	21.0%	18.8%	15.6%
Дундговь аймаг	48.1%	22.7%	26.9%	20.4%	6.9%
Адаацаг сум	54.5%	18.2%	9.1%	20.5%	6.8%
Сайнцагаан сум	49.0%	25.0%	38.5%	20.8%	6.3%
Өлзийт сум	48.1%	29.6%	29.6%	25.9%	7.4%
Эрдэнэдалай сум	46.4%	25.0%	17.9%	25.0%	10.7%
Өндөршил сум	33.3%	9.5%	19.0%	4.8%	4.8%
Завхан аймаг	55.4%	46.4%	12.5%	16.1%	21.4%
Тэлмэн сум	53.3%	30.0%	13.3%	20.0%	30.0%
Улиастай сум	57.7%	65.4%	11.5%	11.5%	11.5%
Төв аймаг	57.4%	29.8%	17.0%	17.0%	8.5%
Батсүмбэр сум	45.5%	31.8%	27.3%	22.7%	9.1%
Эрдэнэсант сум	68.0%	28.0%	8.0%	12.0%	8.0%
Ховд аймаг	44.6%	15.8%	21.8%	20.8%	16.8%
Мянгад сум	50.0%	14.6%	8.3%	16.7%	22.9%
Жаргалант сум	39.6%	17.0%	34.0%	24.5%	11.3%
Хөвсгөл аймаг	43.3%	40.9%	19.3%	13.5%	19.3%
Арбулаг сум	46.0%	44.0%	12.0%	12.0%	22.0%
Мөрөн сум	36.4%	33.3%	28.8%	16.7%	18.2%
Тосонцэнгэл сум	31.3%	59.4%	12.5%	12.5%	21.9%
Жаргалант сум	73.9%	30.4%	17.4%	8.7%	13.0%
Хэнтий аймаг	25.8%	37.5%	17.5%	24.2%	25.0%
Батноров сум	37.5%	62.5%	25.0%	25.0%	37.5%
Баян-Адарга сум	23.3%	33.3%	13.3%	16.7%	16.7%
Биндэр сум	18.5%	37.0%	0.0%	22.2%	29.6%
Хэрлэн сум	25.6%	25.6%	28.2%	30.8%	20.5%

Иргэдийн оролцооны хэлбэрийг нас, хүйсээр задлан дараах хүснэгтэд харууллаа. Залуу насны бүлэг цахим хэлбэрээр оролцох сонирхол өндөр байхад насны бүлэг нэмэгдэх тусам хурал цуглаанд оролцох сонирхол өсөж байна. 55-64 болон 18-24 насны бүлгүүд ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг огт хүсэхгүй байна хамгийн өндөр хувьтай хариулсан байна.

Хүснэгт 38: ИТХ -ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хүсэж буй хэлбэрүүд, n=1212

Оролцооны хэлбэрүүд	Насны бүлэг					Хүйс		Нийт
	18-24	25-34	35-44	45-54	55-64	Эрэгтэй	Эмэгтэй	
Огт оролцохыг хүсэхгүй байна	8.0%	6.5%	4.5%	6.2%	9.6%	6.0%	7.2%	6.6%
Хурал цуглаанд оролцох	29.4%	37.1%	36.3%	44.7%	34.7%	39.1%	34.5%	36.8%
Цахим хэлбэрээр санал өгөх	36.4%	31.5%	28.4%	15.5%	12.6%	24.2%	27.6%	25.9%
Багийн/Хорооны засаг даргаар дамжуулж санал өгөх	16.0%	18.5%	21.6%	29.2%	35.9%	23.1%	23.5%	23.3%
Санал асуулга, судалгаанд оролцох	25.7%	20.6%	15.8%	15.9%	17.4%	18.4%	19.4%	18.9%
Нээлттэй утсаар саналаа хэлэх	13.4%	14.7%	18.5%	18.6%	10.8%	15.1%	16.1%	15.6%
Нээлттэй, хэлэлцүүлэг, ярилцлагад оролцож саналаа хэлэх	10.7%	9.1%	12.7%	10.2%	7.8%	10.4%	10.0%	10.2%
Багийн ИНХ -аар дамжуулж саналаа уламжлах	7.0%	6.8%	11.3%	12.8%	15.0%	10.4%	9.9%	10.1%
Хороо, хэсгийн ахлагчаар дамжуулан саналаа уламжлах	3.7%	7.4%	14.4%	12.4%	12.0%	7.6%	12.5%	10.1%

Саналын хайрцаар саналаа хэлэх	10.7%	10.6%	9.2%	8.0%	9.6%	9.5%	9.9%	9.7%
Өдөрлөг, олон нийтийн арга хэмжээний явцад саналаа хэлэх	7.5%	8.8%	8.2%	9.3%	11.4%	8.3%	9.5%	8.9%
Иргэний танхимаар дамжуулж саналаа хэлэх	3.2%	6.8%	7.2%	11.1%	13.2%	7.3%	8.7%	8.0%
Телевизийн шууд нэвтрүүлгийн үеэр саналаа хэлэх	7.0%	3.8%	7.2%	5.8%	6.6%	6.1%	5.6%	5.9%
Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж санал өгөх	4.8%	4.4%	4.8%	3.5%	6.6%	5.6%	3.8%	4.7%
Төрийн дээд болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр санал бодлоо илэрхийлэх	1.1%	2.9%	3.4%	3.5%	6.6%	3.3%	3.4%	3.4%
Гарын үсэг цуглуулах замаар	2.1%	4.1%	4.5%	1.3%	3.0%	2.0%	4.4%	3.2%
Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд амаар болон бичгээр шууд санал бодлоо илэрхийлэх	1.1%	2.9%	2.4%	2.7%	6.6%	3.0%	3.0%	3.0%
Иргэний нийгмийн байгууллагаар дамжуулж саналаа хэлэх	2.7%	1.8%	2.4%	2.2%	5.4%	2.0%	3.3%	2.6%
Жагсаал цуглаанаар	1.6%	1.8%	2.4%	2.2%	1.8%	2.0%	2.0%	2.0%
Бусад	1.1%	0.0%	0.3%	0.9%	1.2%	1.0%	0.2%	0.6%
Хэлж мэдэхгүй	3.7%	3.8%	5.1%	4.4%	3.0%	4.1%	4.1%	4.1%
Хариулахаас татгалзсан	0.0%	1.2%	0.3%	0.4%	1.2%	0.8%	0.5%	0.7%

- *Иргэдийн оролцоо өссөн, хэвэндээ, буурсан зэргээр гол оролцогч талууд болох засаг дарга, засаг даргын орлогч, ИТХ-ын төлөөлөгч нар янз бүрээр үнэлж байна. Мэдээлэл сайн түгээж, иргэдийн ойлголт нэмэгдэж байгаа учраас өссөн гэж зарим оролцогчид үзэж байхад ИТХ өөрөө асуудлыг шийдэж чадахгүй байгаагаас болж иргэдийн оролцоо буурсан гэж үзсэн оролцогчид ч байна.*

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Манай дээр иргэдийн оролцоо өссөн. Иргэд судалгаандаа болон тойргийн хэсэгчилсэн уулзалтдаа идэвхтэй оролцдог болсон. Иргэд өөрсдийнх нь тулгамдаж буй асуудлуудыг нь шийдээд байгаа болохоор оролцоо сайжирч байгаа.

Багануур дүүрэг, ИТХ -ын төлөөлөгч

Хороон дээр болж байгаа ИНХ-д иргэдийн оролцоо бага хэмжээгээр буурах хандлага ажиглагдаж байгаа. Учир нь иргэд ИНХ дээр ирээд энд эцсийн шийдвэр гарахгүй учраас оролцохоо больчихож байгаа юм. ИНХ нь эцсийн шийдвэр гараад тухайн ажлаа хийж гүйцэтгэх төсөвтэй байсан бол иргэд түлхүү оролцоно. Иргэний гаргасан хүсэлт амьдралд шууд тусахгүй байгаа учраас иргэд оролцохгүй байгаа. Хороо болон дүүргийн зүгээс анхааралдаа авч төрөл бүрийн ажил зохион байгуулдаг. Үүний хүрээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор спортын наадам зохион байгуулж байна. Тухайн хороон дээр байршиж буй төрийн болон хувийн байгууллагуудтай хамтарч ахмадуудтай уулзалт зохион байгуулж байна. Тухайн хороонд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд мэргэжлийн чиг хандлагыг нь сайжруулах зорилгоор аж ахуйн нэгжүүд болон ажлын байрны танилцуулга хийх, мөн цаашид суралцах, ямар мэргэжил сонгоход өөрт нь дөхөм байгаа талаар сургалт сурталчилгааны ажлуудыг нэмж хийж байна. Эрүүл мэндийн хүрээнд өрхийн эмнэлгүүдтэй хамтарч Солонгосын эмнэлгийн байгууллагуудтай хамтарч сүрьеэгийн өвчлөлийг бууруулах чиглэлээр сар гаран мэргэжлийн байгууллага авчирч ажиллуулсан. Иргэдийн асуудлыг нь шийдэх чиглэлээр сар гаран мэргэжлийн байгууллага авчирч ажиллуулсан. Иргэдийн асуудлыг нь шийдэх чиглэлээр ажиллаж байна.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

*Иргэдийн оролцоо ахисан төвшинд байгаа. Энэ нь иргэдийн боловсролын төвшин дээшилсэнтэй холбоотой гэж үзэж байна. Хууль зүйн боловсрол, улс төрийн боловсрол дээшилсэнтэй холбоотой байдаг. Иргэдийн оролцоог дэмжих тал дээр дүүргээс 2019 оны дүүргийн жилийн дэвшүүлсэн зорилт байгаа. Иргэдийн оролцоог дэмжих, боловсролын хүртээмжийг сайжруулах зорилт дэвшүүлсэн. Бүхий л үйл ажиллагаа иргэдийн оролцоонд чиглэсэн. 2019 онд иргэдийн оролцоотой хамгийн үр дүнтэй ажил нь **иргэдээ сонсьё аян, хамтдаа шийдье аян** байсан.*

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын дарга

*Иргэдийн оролцоо сайн болсон. Иргэд өөрсдөө мэдээлэл авах хүсэлтэй байдаг. Иргэдийн оролцоонд **залуучуудын оролцоо муу** байдаг. Ахмад настнууд л оролцоо сайтай, гэртээ очиж сонссон мэдээллээ түгээдэг. Юм хийх хүсэл мөрөөдөлтэй залуучууд цөөнгүй байдаг ч ихэнх залуучууд мэдээлэл авах дээр их дутмаг байдаг*

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын төлөөлөгч

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Иргэдийн оролцоо жил ирэх тусам өсөж байгаа харагддаг. Хөдөөгийн багийн иргэдийн хувьд бэлчээртэй холбоотой асуудал гарвал түлхүү оролцдог. МАА-тайгаа холбоотой асуудлууд дээр түлхүү оролцдог. Жил бүр ИТХ-аас иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг. Оюунлаг иргэн бидний ирээдүй, Монгол бичгээ хэн сайн мэдэх вэ?, Нууц товчоогоо хэн сайн мэдэх вэ? гээд арга хэмжээнүүд зохион байгуулдаг. Эдгээр арга хэмжээнд иргэдээ оролцуулдаг ба хүмүүс ч оролцох дуртай байдаг.

Хэнтий аймаг, Батноров сум, сумын ИТХ-ын дарга

Иргэдийн оролцоо нэмэгдэж байгаа гэж ойлгож байгаа. Манай аймаг иргэдийн оролцоотой тогтвортой амьжиргаа 3 төслийн орон нутгийн иргэдээс санал авах үйл ажиллагаа нэлээн сайжирсан. Үүний үр дүнд иргэдийн оролцоо 60%-д очсон гэж ойлгодог. Тэрнээс өмнө бол хорин хэдэн хувьтай байдаг байсан. Одоо иргэд мэдээлэл сайтай болоод юм ойлгодог болж байна. Энэ төсөл нь иргэдийн оролцоог нэмэгдүүлж, аравтаар ажиллуулж эхэлж байгаа.

Хэнтий аймаг, Баян-Адарга сум, багийн засаг дарга

Иргэдийн оролцоо өссөн. Өмнө ярьсан аравтын системийн зохион байгуулалтын үр дүнд иргэдийн оролцоо сайжирч, хурлын байгууллагын саналд иргэдийн санал нэлээн түлхүү орж ирж байгаа.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, сумын засаг даргын орлогч дарга, аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Би бол багассан гэж бодож байна. Иргэдийн хурал бол орон нутагт байхад хэцүү юм байна. Байхаасаа байхгүй нь их. Манай багийн хурал бол тэргүүлэгчид нь нэг асуудал болгосон тохиолдолд хурал зарлаж хийдэг. Яг иргэдээ чиглүүлээд явж байгаа ажил бол ховор.

Дундговь аймаг, Эрдэнэдалай сум, засаг даргын орлогч

Өмнөх онуудтай харьцуулахад яг ижилхэн идэвх муутай байна. Багийн иргэдийн хурлын дарга нарыг болиулах хэрэгтэй эсвэл цалинг нь нэмээд маш сайн ажиллуулах хэрэгтэй байна. Жилд 1 юм уу 2 цуглуулдаг. Цалин нь сард 150,000 төгрөгийн цалинтай.

Дундговь аймаг, Адаацаг сум, ИТХ-ын төлөөлөгч


Ер нь хэвийн байгаа байх. Яг өссөн юм байхгүй, буурсан ч юм байхгүй. Оролцоог сайжруулахын тулд хурлынхны зүгээс концерт тоглолт маягийн юм бэлдсэн. Хөдөөгийнхөн бол хурал зөвлөгөөн гэхээр ирэхгүй соёл урлагийн арга хэмжээ гэхээр ирдэг. Дунд нь бас хөгжөөнт тэмцээн зохиож иргэдийнхээ оролцоог идэвхжүүлдэг. Энэ жил бол ноднингийн ирцээс арай илүү байсан. Эхний 1, 2 багууд бол хүн багатай байсан. Дараагийн багуудаас ирц нэмэгдэж байсан.

Хөвсгөл аймаг, Арбулаг сум, ИТХ-ын төлөөлөгч

ИТХ-ын хуралдаанд биечлэн оролцох сонирхол

Судалгаанд хамрагдсан иргэд олон нийтээс ИТХ-ын хуралдаан биечлэн оролцох сонирхолтой эсэхийг тодруулахад хөдөө орон нутгийн иргэдийн 56 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 50 хувь буюу хоёр хүн тутмын нэг нь биечлэн оролцох сонирхолтой гэж хариулсан байна.

График 24: ИТХ-ын хуралдаанд биечлэн оролцох сонирхол, n=1212




Дээрх үзүүлэлтийг нас, хүйсээр задлан дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 39: ИТХ-ын хуралдаанд биечлэн оролцох сонирхол, n=1212

	Аймаг/хот		Насны бүлэг					Хүйс		Нийт
	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	18-24	25-34	35-44	45-54	55-64	Эрэгтэй	Эмэгтэй	
Тийм	49.9%	55.6%	50.8%	49.4%	55.8%	57.1%	53.9%	57.9%	48.6%	53.2%
Үгүй	45.7%	41.5%	44.9%	44.7%	42.5%	39.8%	44.3%	39.3%	47.1%	43.2%
Мэдэхгүй байна	4.4%	3.0%	4.3%	5.9%	1.7%	3.1%	1.8%	2.8%	4.3%	3.5%

Судалгаанд хамрагдсан иргэдээс ИТХ-ын төсөв батлах үйл ажиллагаанд оролцож байсан эсэхийг тодруулахад 12 орчим хувь нь оролцож байсан байна.

График 25: ИТХ-ын төсөв батлах үйл ажиллагаанд оролцсон байдал, n=1212



Дээрх үзүүлэлтийг нас, хүйсээр задлан дараах хүснэгтэд харуулав. Насны бүлэг нэмэгдэх тусам оролцоо өндөр байна. Эрэгтэй оролцогчдын оролцсон байдал эмэгтэй оролцогчдоос 4.1 хувиар өндөр байна.

Хүснэгт 40: ИТХ -ын төсөв батлах үйл ажиллагаанд оролцсон байдал, n=1212

	Аймаг/хот		Насны бүлэг					Хүйс		Нийт
	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	18-24	25-34	35-44	45-54	55-64	Эрэгтэй	Эмэгтэй	
Тийм	11.6%	11.8%	7.5%	10.3%	11.6%	15.5%	14.4%	13.8%	9.7%	11.7%
Үгүй	87.0%	88.0%	91.4%	88.5%	87.7%	84.5%	85.6%	85.6%	89.7%	87.6%
Мэдэхгүй байна	1.4%	0.1%	1.1%	1.2%	0.7%	0.0%	0.0%	0.7%	0.7%	0.7%

- Гол оролцогч талууд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь зөв гэж үзэж байна. Иргэдийн оролцоог сайн хангаж байж нутаг орны хөгжил илүү зөв явна гэж оролцогчид харж байна. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь зөв боловч иргэдийн санал хүсэлтийг шүүх хэрэгтэй. Зарим тохиолдолд иргэд дураараа хүссэн зүйлээ шийдүүлэх гээд байдаг. Тэр тал дээр иргэдэд зөв ойлголт өгөх нь чухал гэдгийг дурдаж байв.
- **Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хийгддэг ажил:** Хөдөө орон нутагт иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд урлаг, спортын наадам, замын хөдөлгөөний авто уралдаан, мэргэн буудлагын тэмцээн, цагаан идээний үзэсгэлэн худалдаа, малчдын чуулган, айргийн баяр, ахмадын цэнгүүн, тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээ, нарийн мэргэжлийн эмч, хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг, иргэдийн хурлаар сугалаа явуулах, бэлчээр ашиглалтын хэсгүүдийн дунд хэвлэмэл материалтай богц явуулах, 10-тын системээр ажиллах, төрийн үйлчилгээг малчны хотхонд аян зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг бөгөөд эдгээр нь тун үр дүнтэй байдаг байна.
- **Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд хийгддэг ажил:** Улаанбаатар хотын хувьд ИНХ -аа олон сувгаар зарлах, сургалт явуулах, спорт урлагийн арга хэмжээ зохион байгуулах, мод тарих өдөрлөг, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах, долоо хоногийн нэг өдрийг сонгож иргэдэд мэдээлэл түгээх байдлаар идэвхжүүлж байна.
- **Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд саад болж буй хүчин зүйлс:** Иргэдийн оролцоо бага, иргэдийн саналыг цагийг нь тулгаж авдаг учраас дараа жилийн төсөвт тусгагддаггүй олон ажлууд байдаг. Төсөв мөнгөтэй холбоотой асуудал, төсөв зарцуулалтын ил тод байдал хангагдахгүй байх, намчирхах, ядуурлын түвшин өндөр байгаа нь эргээд иргэдийн оролцоог бууруулж байна гэж үзсэн байна.

2.4. ИТХ -ын төлөөлөгчдийн талаарх иргэдийн ойлголт, хандлага, үнэлгээ


Энэ бүлэгт иргэд олон нийтийн тухайн тойргоос шат шатны ИТХ -д сонгогдон ажиллаж буй ИТХ -ын төлөөлөгчдөө нэрлэж буй байдал, сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгч нартай хэрхэн, ямар асуудлаар холбогдсон талаар, мөн ямар арга замаар холбогдсон, асуудлаа шийдвэрлэж чадсан эсэх, ИТХ -ын төлөөлөгчид ямар шалгуурыг хангах ёстой талаар тодруулна.

2.4.1. Аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчдийн талаарх нийтлэг ойлголт

Өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчийг нэрлэх байдал

Иргэд олон нийт өөрийнхөө тойргоос сонгогдсон ИТХ -ын төлөөлөгчдийг нэрлэсэн байдал дараах бүтэцтэй байна. Хөдөө орон нутгийн иргэд аймгийн ИТХ -ын төлөөлөгчийг 24 хувь, Улаанбаатар хотын иргэд НИТХ -ын төлөөлөгчийг 6 хувь зөв нэрлэсэн байна.

График 26: Аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчийг нэрлэх байдал, n=1212



Өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчийг хамгийн сүүлд харсан байдал

Судалгаанд хамрагдсан иргэд олон нийтээс тойргоос нь сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчийг хамгийн сүүлд хэзээ харсан талаар тодруулахад Улаанбаатар хотын иргэдийн 47.9 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 18.6 хувь огт хараагүй гэж хариулсан байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 17.7 хувь болон 24.8 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм. Харин хаана харснаа санахгүй байгаа хувь өсөж Улаанбаатар хотод 19.6 хувь, хөдөө орон нутагт 34.9 хувь болсон байна.

Хүснэгт 41: Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, хугацаа, n=1212

Хамгийн сүүлд харсан хугацаа	Нийт	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Аймаг	Дундговь аймаг	Завхан аймаг	Төв аймаг	Ховд аймаг	Хөвсгөл аймаг	Хэнтий аймаг
Сарын өмнө	17.4%	9.2%	23.2%	Аймаг	18.1%	35.7%	23.4%	25.7%	29.2%	15.8%
2-5 сарын өмнө	7.7%	6.2%	8.7%		5.1%	0.0%	4.3%	15.8%	8.8%	15.0%
6 сарын өмнө	2.9%	2.6%	3.1%		2.3%	0.0%	4.3%	4.0%	0.6%	8.3%
1 жилийн өмнө	2.6%	1.2%	3.5%		2.8%	0.0%	8.5%	4.0%	2.3%	5.8%
2 жилийн өмнө	1.2%	1.2%	1.1%		0.5%	0.0%	0.0%	3.0%	1.2%	1.7%
Сонгуулийн кампанит ажлын үеэр /2016 онд/	9.1%	12.2%	6.9%		5.6%	8.9%	8.5%	6.9%	8.8%	5.0%
Огт хараагүй	30.7%	47.9%	18.6%		13.9%	5.4%	19.1%	28.7%	9.9%	36.7%
Мэдэхгүй/санахгүй байна	28.5%	19.6%	34.9%		51.9%	50.0%	31.9%	11.9%	39.2%	11.7%
Нийт	100.0%	100.0%	100.0%		100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөө харсан оролцогчдоос хамгийн сүүлд хаана харсан талаар тодруулахад хөдөө орон нутгийн иргэдийн хувьд хурал уулзалтад оролцох үеэр, биечлэн/ганцаарчлан уулзахдаа харсан байдал өндөр хувьтай байна. Завхан аймгийн иргэд бусад аймагтай харьцуулахад ИТХ-ын ажлын албан дээр уулзсан хувь өндөр байна. Улаанбаатар хотын иргэдийн хувьд хурал уулзалтын үеэр болон телевиз/орон даяар цацагддаг/-ээр харсан байдал өндөр хувьтай байна.

Хүснэгт 42: Сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан хэлбэр, байршлаар, n=494


Хамгийн сүүлд харсан хэлбэр	Нийт	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг		Дундговь аймаг	Завхан аймаг	Төв аймаг	Ховд аймаг	Хөвсгөл аймаг	Хэнтий аймаг
Хурал уулзалтад оролцох үеэр	29.8%	<u>23.9%</u>	<u>32.6%</u>	Аймаг	36.5%	<u>8.0%</u>	43.5%	38.3%	25.3%	38.7%
Биечлэн/ганцаарчлан уулзахдаа	10.9%	4.9%	<u>13.9%</u>		29.7%	<u>4.0%</u>	21.7%	10.0%	5.7%	11.3%
Телевиз /орон даяар цацагддаг/	7.5%	<u>15.3%</u>	3.6%		0.0%	8.0%	4.3%	5.0%	2.3%	6.5%
ИТХ-ын ажлын албан дээр	7.1%	3.7%	8.8%		8.1%	<u>28.0%</u>	4.3%	3.3%	10.3%	6.5%
Телевиз /орон нутгийн/	4.5%	6.1%	3.6%		1.4%	4.0%	0.0%	5.0%	4.6%	4.8%
Нээлттэй өдөрлөгийн үеэр	4.0%	8.0%	2.1%		1.4%	4.0%	0.0%	6.7%	0.0%	1.6%
Цахим хуудсаар /веб хуудас/	2.4%	4.3%	1.5%		0.0%	0.0%	0.0%	3.3%	2.3%	1.6%
Хэвлэмэл материал дээрээс	2.0%	3.7%	1.2%		0.0%	8.0%	0.0%	1.7%	0.0%	1.6%
Олон нийтийн сүлжээгээр /Facebook, Twitter г.м/	1.6%	2.5%	1.2%		0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.5%
Иргэний танхимд	1.4%	0.6%	1.8%		1.4%	4.0%	0.0%	3.3%	0.0%	3.2%
Сонин/сэтгүүлээс	1.2%	1.8%	0.9%		0.0%	0.0%	0.0%	1.7%	1.1%	1.6%
Бусад	13.0%	9.8%	14.5%		1.4%	16.0%	4.3%	16.7%	29.9%	9.7%
Мэдэхгүй/санахгүй байна	14.6%	15.3%	14.2%		20.3%	16.0%	21.7%	5.0%	18.4%	6.5%
Нийт	100.0%	100.0%	100.0%		100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

2.4.2. Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдийн талаарх ойлголт

Өөрийн тойргоос сонгогдсон аймаг/нийслэлийн ИТХ -ын төлөөлөгчийг нэрлэх байдал

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг хөдөө орон нутгийн иргэдийн 25 хувь, Улаанбаатар хотын иргэдийн 8 хувь зөв нэрлэсэн байна. Хөдөө орон нутгийн иргэд Улаанбаатар хотын иргэдтэй харьцуулахад тухайн тойргийн ИТХ -ын төлөөлөгчийг зөв нэрлэх байдал 3 дахин өндөр байна.

График 27: Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг нэрлэх байдал, n=1212



Өөрийн тойргоос сонгогдсон сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан байдал

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан байдал дараах бүтэцтэй байна. Улаанбаатар хотын иргэдийн 45.9 хувь нь дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг огт хараагүй, 19.4 хувь нь хэзээ харснаа санахгүй байна. Хөдөө орон нутгийн иргэдийн 12.7 хувь нь огт хараагүй, 28.7 хувь нь хэзээ харснаа санахгүй байна. Улаанбаатар хотын иргэд гол төлөв сонгуулийн кампанит ажлын үеэр 2016 онд харсан байна. Харин хөдөө орон нутгийн иргэд сарын өмнө харсан хувь өндөр байна.

Хүснэгт 43: Сонгогдсон сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчөө хамгийн сүүлд харсан байдал, байршлаар, n=1212

	Сарын өмнө	2-5 сарын өмнө	6 сарын өмнө	1 жилийн өмнө	2 жилийн өмнө	Сонгуулийн кампанит ажлын үеэр /2016 онд/	Огт хараагүй	Мэдэхгүй/санахгүй байна
Нийт	28.7%	6.8%	2.1%	2.4%	1.1%	7.8%	26.4%	24.8%
Улаанбаатар хот	9.6%	7.8%	2.8%	2.6%	1.0%	11.0%	45.9%	19.4%
Хөдөө орон нутаг	42.2%	6.0%	1.5%	2.3%	1.1%	5.5%	12.7%	28.7%
Дүүргээр:								
Багануур	30.8%	7.7%	7.7%	0.0%	0.0%	15.4%	30.8%	7.7%
Багахангай	73.7%	0.0%	0.0%	5.3%	0.0%	5.3%	10.5%	5.3%
Баянгол	5.3%	10.5%	2.6%	0.0%	2.6%	15.8%	52.6%	10.5%
Баянзүрх	1.7%	10.2%	3.4%	3.4%	3.4%	8.5%	52.5%	16.9%
Налайх	15.6%	3.1%	9.4%	6.3%	0.0%	6.3%	43.8%	15.6%
Сонгинохайрхан	10.5%	7.9%	2.6%	3.9%	0.0%	9.2%	27.6%	38.2%
Сүхбаатар	8.2%	8.2%	2.7%	1.4%	1.4%	17.8%	47.9%	12.3%
Хан-Уул	3.5%	8.8%	0.0%	1.8%	0.0%	8.8%	70.2%	7.0%
Чингэлтэй	4.2%	6.3%	2.1%	3.1%	0.0%	8.3%	44.8%	31.3%
Сумдаар:								
Дундговь аймаг								
Адаацаг сум	47.7%	4.5%	4.5%	0.0%	0.0%	4.5%	4.5%	34.1%
Сайнцагаан сум	17.7%	3.1%	2.1%	2.1%	0.0%	1.0%	14.6%	59.4%
Өлзийт сум	40.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	7.4%	0.0%	51.9%
Эрдэнэдалай сум	39.3%	7.1%	0.0%	3.6%	3.6%	10.7%	7.1%	28.6%
Өндөршил сум	42.9%	0.0%	0.0%	0.0%	0.0%	9.5%	0.0%	47.6%

	Сарын өмнө	2-5 сарын өмнө	6 сарын өмнө	1 жилийн өмнө	2 жилийн өмнө	Сонгуулийн кампааниг ажлын үеэр /2016 онд/	Огт хараагүй	Мэдэхгүй/с анахгүй байна
Завхан аймаг								
Тэлмэн сум	76.7%	6.7%	0.0%	0.0%	0.0%	6.7%	0.0%	10.0%
Улиастай сум	7.7%	7.7%	0.0%	0.0%	0.0%	11.5%	11.5%	61.5%
Төв аймаг								
Батсүмбэр сум	68.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	9.1%	22.7%
Эрдэнэсант сум	68.0%	4.0%	8.0%	0.0%	0.0%	4.0%	4.0%	12.0%
Ховд аймаг								
Мянгад сум	56.3%	6.3%	0.0%	8.3%	0.0%	8.3%	12.5%	8.3%
Жаргалант сум	11.3%	7.5%	5.7%	7.5%	5.7%	7.5%	37.7%	17.0%
Хөвсгөл аймаг								
Арбулаг сум	66.0%	2.0%	0.0%	4.0%	0.0%	2.0%	2.0%	24.0%
Мөрөн сум	6.1%	16.7%	0.0%	1.5%	4.5%	9.1%	21.2%	40.9%
Тосонцэнгэл сум	53.1%	15.6%	0.0%	0.0%	0.0%	6.3%	6.3%	18.8%
Жаргалант сум	82.6%	4.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	13.0%
Хэнтий аймаг								
Батноров сум	83.3%	4.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	8.3%	4.2%
Баян-Адарга сум	73.3%	0.0%	0.0%	3.3%	0.0%	0.0%	6.7%	16.7%
Биндэр сум	55.6%	7.4%	0.0%	0.0%	0.0%	3.7%	18.5%	14.8%
Хэрлэн сум	28.2%	7.7%	5.1%	2.6%	2.6%	12.8%	35.9%	5.1%

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан оролцогчдоос хаана харсныг тодруулахад гол төлөв хурал уулзалтад оролцох үеэр харсан байна. Хөвсгөл аймгийн иргэдийн хувьд сумын ИТХ -ын төлөөлөгчийг биечлэн уулзахдаа харсан хувь хамгийн бага, Төв аймгийн иргэдийн хувьд хамгийн өндөр байна.

Хүснэгт 44: Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан хэлбэр, n=591

	Нийт	Улаанбаа тар хот	Хөдөө орон нутаг	Аймаг	Дундговь аймаг	Завхан аймаг	Төв аймаг	Ховд аймаг	Хөвсгөл аймаг	Хэнтий аймаг
Биечлэн/ганцаарчлан уулзахдаа	20.0%	10.3%	24.0%		37.2%	2.9%	41.7%	30.6%	1.9%	32.9%
Хурал уулзалтад оролцох үеэр	23.2%	21.8%	23.7%		35.1%	8.8%	27.8%	21.0%	16.0%	27.1%
ИТХ-ын ажлын албан дээр	9.6%	3.4%	12.2%		7.4%	29.4%	13.9%	4.8%	13.2%	14.1%
Цахим хуудсаар /веб хуудас/	2.7%	5.7%	1.4%		1.1%	0.0%	0.0%	1.6%	2.8%	1.2%
Олон нийтийн сүлжээгээр /Facebook, Twitter г.м/	1.2%	2.3%	0.7%		0.0%	0.0%	2.8%	0.0%	0.9%	1.2%
Иргэний танхимд	2.4%	1.7%	2.6%		3.2%	2.9%	0.0%	3.2%	0.9%	4.7%
Телевиз /орон даяар цацагддаг/	3.0%	6.9%	1.4%		0.0%	0.0%	2.8%	4.8%	0.9%	1.2%
Телевиз /орон нутгийн/	3.4%	4.6%	2.9%		0.0%	0.0%	0.0%	4.8%	6.6%	2.4%
Сонин/сэтгүүлээс	1.0%	1.1%	1.0%		0.0%	2.9%	0.0%	1.6%	1.9%	0.0%
Хэвлэмэл материал дээрээс	2.9%	6.3%	1.4%		0.0%	2.9%	0.0%	3.2%	1.9%	1.2%
Нээлттэй өдөрлөгийн үеэр	4.4%	8.0%	2.9%		1.1%	2.9%	5.6%	4.8%	2.8%	2.4%
Бусад	14.9%	12.6%	15.8%		1.1%	35.3%	2.8%	16.1%	32.1%	9.4%
Мэдэхгүй/санахгүй байна	11.3%	14.9%	9.8%		13.8%	11.8%	2.8%	3.2%	17.9%	2.4%

Дүүргийн ИТХ -ын төлөөлөгчийг харсан оролцогчдоос хаана харсныг дүүргээр задлан дараах хүснэгтэд харуулав.


Хүснэгт 45: Дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийг харсан хэлбэр, дүүргээр, n=174

	Багануу р дүүрэг	Багахан гай дүүрэг	Баянгол дүүрэг	Баянзүр х дүүрэг	Налайх дүүрэг	Сонгино хайрхан дүүрэг	Сүхбаат ар дүүрэг	Хан-Уул дүүрэг	Чингэлт эй дүүрэг
Биечлэн/ганцаарчлан уулзахдаа	12.5%	31.3%	0.0%	11.1%	15.4%	0.0%	17.2%	7.7%	8.7%
Хурал уулзалтад оролцох үеэр	25.0%	31.3%	17.9%	33.3%	23.1%	23.1%	10.3%	38.5%	13.0%
ИТХ-ын ажлын албан дээр	0.0%	12.5%	0.0%	5.6%	0.0%	0.0%	6.9%	0.0%	4.3%
Цахим хуудсаар /веб хуудас/	12.5%	6.3%	7.1%	0.0%	0.0%	0.0%	6.9%	15.4%	8.7%
Олон нийтийн сүлжээгээр /Facebook, Twitter г.м/	0.0%	0.0%	3.6%	0.0%	0.0%	7.7%	3.4%	0.0%	0.0%
Иргэний танхимд	12.5%	0.0%	0.0%	5.6%	0.0%	0.0%	0.0%	0.0%	4.3%
Телевиз /орон даяар цацагддаг/	0.0%	0.0%	21.4%	5.6%	7.7%	0.0%	13.8%	0.0%	0.0%
Телевиз /орон нутгийн/	12.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	19.2%	0.0%	0.0%	8.7%
Сонин/сэтгүүлээс	0.0%	0.0%	0.0%	0.0%	7.7%	0.0%	3.4%	0.0%	0.0%
Хэвлэмэл материал дээрээс	0.0%	0.0%	14.3%	0.0%	7.7%	3.8%	6.9%	15.4%	4.3%
Нээлттэй өдөрлөгийн үеэр	0.0%	0.0%	10.7%	16.7%	0.0%	19.2%	3.4%	7.7%	4.3%
Бусад	25.0%	12.5%	14.3%	5.6%	30.8%	3.8%	10.3%	0.0%	21.7%
Мэдэхгүй/санахгүй байна	0.0%	6.3%	10.7%	16.7%	7.7%	23.1%	17.2%	15.4%	21.7%

Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй уулзсан байдал

Судалгаанд оролцсон 10 хүн тутмын 2 нь 2016 оны орон нутгийн сонгуулиас хойш өөрийн тойргоос сонгогдсон сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байна. Суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал, сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй уулзсан байдал Улаанбаатар хотын хувьд 6.2 хувиар буурч, хөдөө орон нутгийн хувьд 17.1 хувиар өссөн байна.

График 28: Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон байдал, n=1212



Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдсон иргэд дунджаар 4.1 удаа холбогдсон байна. Хөдөө орон нутагт 4.5, Улаанбаатар хотод 2.3 удаа холбогдсон байна.

Улаанбаатар хотын иргэд дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй голчлон орон нутгийн дэд бүтцийн талаар, эрүүл мэндийн үйлчилгээний асуудлаар, газар өмчлөх асуудлаар уулзсан байна. Хөдөө орон нутгийн иргэд ИТХ -ын төлөөлөгчтэй голчлон ажлын байрыг дэмжих асуудлаар, хувийн асуудлаар, байгаль орчны асуудлаар уулзсан байна.

ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдсон арга замын хувьд биечлэн уулзсан хувь хамгийн өндөр байна.

Хүснэгт 46: ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон арга зам, байршлаар, n=196

	Улаанбаатар хот	Хөдөө орон нутаг	Нийт
Биечлэн/ганцаарчлан уулзсан	56.4%	66.9%	64.8%
Утсаар холбогдсон	20.5%	29.9%	28.1%
Хурал уулзалтад оролцох үеэр уулзсан	15.4%	28.7%	26.0%
Мэдэхгүй/санахгүй байна	7.7%	1.3%	2.6%
Цахим хуудсаар /веб хуудас/	5.1%	0.6%	1.5%
Цахим шуудангаар /и-мэйл/	2.6%	1.9%	2.0%
Олон нийтийн сүлжээгээр /Facebook, Twitter г.м/	2.6%	2.5%	2.6%
Бусад	2.6%	1.3%	1.5%
ИТХ-ын ажлын албаар дамжуулж холбогдсон	0.0%	7.6%	6.1%
Захидал илгээсэн	0.0%	1.9%	1.5%
Иргэний танхимаар	0.0%	4.5%	3.6%
ТВ/радио нэвтрүүлгийн шууд утсаар	0.0%	0.0%	0.0%
Нээлттэй өдөрлөгийн үеэр	0.0%	5.1%	4.1%
Хүнээр дамжуулж	0.0%	1.3%	1.0%

- Гол оролцогч талуудын үзэж буйгаар **биечлэн уулзах** нь хамгийн үр дүнтэй байдаг байна. Учир нь ИНХ -аар цөөн хэдэн хүн санал бодлоо илэрхийлээд, дийлэнх нь санал бодлоо илэрхийлэхгүй үлддэг байна. Харин айл өрх, хөдөө орон нутгаар биечлэн нэг бүрчлэн болон хэсэгчлэн уулзах үед иргэд өөрсдөдөө тулгарч буй асуудлыг илэн далангүй ярьдаг байна. Улаанбаатар хотын хувьд хорооны бүх айл өрхүүдээр орох боломжгүй учраас зорилтот бүлгийн өрхүүдтэй хэсэгчлэн уулздаг. Мөн иргэдтэй **сошиал сувгаар дамжуулан холбогдох** нь хурдан шуурхай байдаг.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Нийтийн хурал дээр бусдаасаа ичих эсвэл ярианы баялаг муутай байдаг юм уу эсвэл ярих дургүй байдаг юм уу тийм байдалтай хүмүүс өөрийгөө ойлгуулж чаддаггүй учраас нүүр тулж биечлэн уулзах нь үр дүнтэй байдаг.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, засаг даргын орлогч дарга, аймгийн ИТХ -ын төлөөлөгч

Би нэг их иргэдийг цуглуулаад уулздаггүй. Ахмадын баяр ч юм уу, найз нөхдийн журмаар л уулздаг. Албаны гэхээсээ илүү амин хувийн найз нөхдийн журмаар л уулздаг. Одоо хүмүүс нэг их ирэхээ больсон байна.

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, аймгийн ИТХ -ын төлөөлөгч


Иргэдтэй уулзаж, санал бодлыг нь сонсох хамгийн зөв арга замуудын нэг нь хэсэгчилж иргэдтэй уулзах юм. Нүүр тулж биечлэн уулзах, хэт олноор биш хэсэгчилж уулзах, байр, гудамж, СӨХ-ийн хэмжээнд гарч байгаа бэрхшээлүүдийг газар дээр нь ярилцаад шийдэх зүйлийг нь шийдээд цаашид авах арга замуудыг нь тэмдэглэж аваад хөөцөлддөг. Мөн сошиал хэлбэрээр иргэдээс мэдээлэл авдаг. Өөрийн фейсбүүк болон хорооны албан ёсны фейсбүүкийн группээр тухайн группийн нийт гишүүдэд бүх мэдээллийг нээлттэй байхаар тавих боломжтой.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

Би байнга хороон дээрээ иргэдийг орж ирэхэд нь хүлээж авч уулзах, тавьж байгаа санал хүсэлтүүдийг хүлээж авах зорилго тавьж ажилладаг. Иргэдээс гарсан санал хүсэлтийг үйл ажиллагаанд оруулах боломжтойг нь оруулаад, боломжгүйг нь дээд шатны байгууллагууддаа уламжлаад шийдэх боломж нь ямар байна гэдгийг уламжлаад ажил хэрэгтээ оруулаад ажиллахыг боддог. Иргэдтэйгээ аль болох уулзахыг бодно. Гадаа явж байсан ч уулзаж байдаг. Өрөөндөө ажилтай байсан ч уулзахыг боддог. Засгийн газраас сая онцгой нөхцөл байдал зарласантай холбоотойгоор 62-р тогтоол гарсантай холбоотойгоор шахмал түлш хэрэглэж буй талаар иргэдтэйгээ уулзаж, гэр орноор нь орж, шахмал түлшний хэрэглээ сайн, муу ямар байгаа талаар ярилцаж явна. Манай хорооны ямар ч иргэн надтай уулзъя гээд ирэхэд би хороон дээрээ байж байдаг учраас ямар ч асуудал байхгүй. Иргэд өөрсдөө ирээд уулзъя гэвэл бүгдтэй нь уулзах боломж байна. Арга хэмжээ, үйл ажиллагаа, хурал цуглаан бол цаг үеийнхээ асуудлаар байнга хийгдээд явдаг. Жишээ нь, манай дээр “Баянхошуу дэд төв гээд маш том бүтээн байгуулалт Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар хийгдэж байна. Үүний хүрээнд хийгдэх бүтээн байгуулалт, дэд бүтэц гэсэн асуудлуудтай холбоотойгоор иргэдтэй байнга уулзаж явж байна. Гадуур уулзана, орон гэрээр нь орно. Хороон дээр хийгдэж байгаа тохижилтын ажлууд, иргэдийн оролцоотой хийгдэж болох ажлууд дээр иргэдтэйгээ байнга харилцаж байгаа. Иргэдтэйгээ уулзаж, харилцаа холбоотойгоор л ажиллаж байна. Ямар ч асуудал байхгүй. Хороогоор орж ирэх шаардлага байхгүй, ажлаа хийгээд явж байгаа завгүй ажилладаг хүмүүс байдаг. Тэр хүмүүсийн хувьд надтай уулзаагүй хүмүүс байдаг байх. Тэрнээс уулзах боломжтой хүмүүстэй уулзаад л явж байгаа.

Улаанбаатар хот, СХД, хорооны засаг дарга, ИТХ -ын төлөөлөгч


График 29: ИТХ-ын төлөөлөгчтэй уулзсан шалтгаан, байршлаар, n=196



- Гол оролцогч талуудын үзэж буйгаар хөдөө орон нутгийн иргэдийн хамгийн их ханддаг асуудал нь малын бэлчээрийн хомсдол, өвөлжөө хаваржааны асуудал маргаан, ажилгүйдэл, худаг усны асуудал, нутаг орны хил заагийн асуудал, хог хаягдал, золбин нохой, муурын асуудал, гэрэлтүүлэг тавих, халамж тэтгэвэр, сургалтын төлбөр, эмчилгээний төлбөр, гэр хүсэх, сум орон нутгийн мэргэжлийн боловсон хүчний хомсдол /эмч гэх мэт/, байгаль орчны чиглэлээр, малын хулгай гэх мэт асуудлаар түгээмэл ханддаг байна. Улаанбаатар хотын иргэдийн хувьд гэр орон хүсэх, халамжид хамрагдах, ажилд орох, гэрэлтүүлэг, камержуулалт, зам дэд бүтэц, сургалтын төлбөр, цэцэрлэгт хамрагдах, амьдрах орчны тав тух, шагнал, утаа агаарын бохирдол, газрын асуудлаар, хог хаягдлын асуудлаар голчлон ханддаг байна. Иргэд ихэвчлэн биечлэн уулзах, бичгээр хүсэлт илгээх, утсаар хандах, мөн сошиалаар санал хүсэлтээ илэрхийлж байна.
- Иргэдийн оролцоог хангахын тулд олон сувгаар мэдээлэл цацахыг хичээдэг ба үүнд, хэсгийн ахлагч айл өрхөөр зар тараах, утсаар мэдээлэл хүргэх, сошиалд зар тавих, хурал цуглаан дээр зарлах, худаг, зарын самбар дээр зар тавих зэргээр мэдээллийг хүргэж байна.


Сум/дүүргийнхээ ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдоход хүндрэлтэй байсан гэж Улаанбаатар хотын иргэдийн 61.5 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 22.3 хувь хариулсан байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 40.7 хувь, 20.3 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.

График 30: Орон нутгийн ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдоход хүндрэлтэй байдал, байршлаар, n=196



Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй холбогдоод хүсэлт, асуудал, санал гомдлоо бүрэн шийдсэн байдал Улаанбаатар хотод 25.6 хувь буюу өмнөх судалгааны үр дүнгээс 4.8 хувиар өссөн, хөдөө орон нутагт 28.7 хувь бөгөөд өмнөх судалгааны үр дүнгээс 19.8 хувиар буурсан байна.

График 31: ИТХ-ын төлөөлөгчтэй холбогдсон асуудал бүрэн шийдэгдэх байдал, байрилаар, n=196



- Гол оролцогч талуудын үзэж буйгаар иргэдийн хандсан асуудлыг 50-иас дээш хувьтай шийдсэн гэж үзэж байна. Шийдэгдээгүй асуудал нь гол төлөв ИТХ -ын төлөөлөгчөөс хамаарахгүй, төсөв мөнгөтэй холбоотой, хувь хүний ашиг харсан асуудлууд байдаг байна. ИТХ -ын төлөөлөгч өөрийн хэмжээнд шийдэх боломжтой асуудлаа шийдээд, шийдээж чадахгүй асуудлаа холбогдох байгууллагад нь уламжилж өгдөг байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Иргэдийн санал бодлыг ажил хэрэг болгох тал дээр гэвэл иргэдээс ажил хэргийг төсөвт суулгах санал ирвэл тэрийг ИТХ –ын дарга дээр очно. ИТХ-ын дарга хуралдах шаардлагатай гэвэл албан бичиг төлөвлөөд, санал онолоо тусгаад дээш нь албан бичгээ явуулдаг. Монголд албан бичиг яваад таг болчихдог. Тийм болохоор ИНХ-ын тэргүүлэгчид хоорондоо ярилцаад нэгийг томилоод албан бичгийн хариу хэзээ ирэх, хариу юу гэж ирэх, шийдвэр гарах боломж нь ямар байна гээд албан бичгийнхээ араас хөөцөлдүүлдэг.

Улаанбаатар хот, ХУД, дүүргийн ИТХ -ын төлөөлөгч

Манай хороо 9700 хүн амтай. Үүний 6000 орчим нь насанд хүрсэн хүмүүс байдаг. 6000 орчим хүний ихэнх нь залуучууд, завгүй хүмүүс байна. Амьдрах орчин, өөртэй нь холбоотой асуудал үүссэн хүмүүстэй уулзаад л явж байгаа. Орон нутгийнхаа төлөө санаа тавьж юм хийлгэмээр байна, ийм ийм асуудлууд байна, та үүн дээр ингээч гэсэн надтай уулзъя гэсэн хүмүүстэй би 100% уулзаж байгаа.

Улаанбаатар хот, СХД, хорооны засаг дарга, дүүргийн ИТХ -ын төлөөлөгч

Орон нутгийн хөгжлийн сан дээр иргэдээс санал асуулга авдаг. Баг дээр ямар ямар хийх шаардлагатай ажлууд байгааг асуудаг. Ажилтай төлөөлөгч, ажилгүй төлөөлөгчийн хооронд асар их ялгаа байгаа. Миний хувьд орлогч даргынхаа хувьд бусад төлөөлөгчдөөсөө илүү түлхүү шийдүүлдэг. Яагаад гэвэл энэ албан тушаалын онцлогоос шалтгаалж өөр байна. Нөгөө төлөөлөгч нарын хувьд үнэхээр өөрийнхөө хичээл зүтгэлээр гараад ирсэн, бас баг руугаа ажил хийж байгаа ч гэсэн нөлөөлөх нөлөөлөл байхгүй. Хурлын төлөөлөгчид яг үнэндээ цалин байдаггүй. Тэгэхээр тэр хүн 4 жилдээ нэг удаа очиж уулзвал уулзана. Миний хувьд өөрийнхөө багийн иргэдээс ирсэн асуудлыг шийдэхээс гадна анх сонгогдохдоо хэлсэн байсан ажлуудаас 80-90% тай хийсэн гэж үзэж байгаа.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, сумын засаг даргын орлогч дарга, аймгийн ИТХ -ын төлөөлөгч


Бодлогын хувьд их дэмжихийг хичээдэг. Нийтийг хамарсан асуудал, худаг усны асуудал зэрэг. Хувь хүний асуудал дээр туслахад хэцүү санхүүгийн болон орох орон, гэр гэх мэт.

Дундговь аймаг, Адаацаг сум, сумын ИТХ -ын төлөөлөгч

Орон нутгийн хөгжил, дэд бүтэцтэй холбоотой асуудал гарахад хамгийн түрүүнд хандах байгууллага

Иргэдэд өөрт нь болон гэр бүлийн хэн нэгэн гишүүдэд нь орон нутгийн хөгжил, дэд бүтэц зэрэгтэй холбоотой асуудал тулгарахад хамгийн түрүүнд баг/хорооны засаг даргад хандана гэж хариулсан байна. Өмнөх жилийн үр дүнтэй харьцуулахад мэдэхгүй гэж хариулсан хувь буурсан байна.

График 32: Орон нутгийн хөгжил, дэд бүтэц зэрэгтэй холбоотой асуудал тулгарахад хандах байгууллага/албан тушаалтан, хувиар, n=1212



ФБЯ -ын тэмдэглэлээс:

Багаас суманд сонгогдсон ИТХ -ын төлөөлөгч, сумаас аймагт сонгогдсон ИТХ -ын төлөөлөгч, багийн засаг дарга нар л бидний ажил, амьдралд ямар асуудал үүсээж байгааг, ямар боломж бололцоо байгааг мэдэж байгаа.

Ховд аймаг, Мянгад сум, Иргэдийн ФБЯ

Надад асуудал тулгарвал хамгийн түрүүнд багийн даргадаа ханддаг. Ямар нэгэн асуудал тулгарахад биднийг төлөөлөөд дээд байгууллагадаа уламжилдаг.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, Иргэдийн ФБЯ

Надад асуудал тулгарвал хамгийн түрүүнд багийн засаг даргад хандана. Бүр асуудал шийдэгдэхгүй бол сумын ИТХ -ын төлөөлөгчид хандана. Түүнээс цааш гэвэл аймгийн ИТХ -д гээд шат шатны байгууллагад нь хандана.

Төв аймаг, Эрдэнэсант сум, Иргэдийн ФБЯ

Бидэнд асуудал гарвал ер нь л хороондоо ханддаг. Гэхдээ сүүлийн үед хүмүүс одоо орон нутагт, оришн суугаа газарт нь асуудал гарвал социал суваг дээр их тавьдаг болсон байна. Хэнд хандахаа мэдэхгүй, яах уу, хэнд хандах уу гэж бусдаас их асуудаг болсон байна. Миний хувьд бол хороон дээр л очдог.

Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ

Мэдээ, мэдээллийг ажлын газраас, ойр дотнын хүмүүсээс мэдээлэл авч байна. Ямар нэг асуудал тулгарвал яг хэнд хандахаа сайн мэддэггүй. Дүүргийн, нийслэлийн аль хурлын төлөөлөгчтэй уулзах гэхээр ГАДУУР АЖИЛТАЙ гэдэг. Би уулзах гэж хөөцөлдөж үзсэн. Иргэдтэй уулзах, хүлээж авах өдрөөр нь очихоор тэр үедээ байдаггүй. Эсвэл манай хүлээж авах хүний тоо дууссан гэсэн хэрнэ хүн хүлээж авсан ямар ч баримт байдаггүй. Сүүлийн үед СӨХ хорооноос илүү ажилладаг болсон. СӨХ -дөө асуудлаа хэлбэл бидний үг дүүрэгт хүрсэн байдаг. Хороон дээр олон байр, иргэд нэгддэг учраас ачаалал ихтэй л байдаг байх. Гэхдээ одоо шат шатны байгууллага журмын дагуу ажлаа хийдэг баймаар байна. Бүр зайлшгүй том асуудал тулгарсан бол зөвхөн ИХТ -ыг сахиж байгаад уулзахаас өөр аргагүй.

Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдөд өгөх үнэлгээ

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдөд өгсөн үнэлгээ дараах бүтэцтэй байна. Улаанбаатар хотын иргэд дүүргийн ИТХ -ын төлөөлөгчөө “маш сайн” болон “зарим талаар сайн” гэж үнэлсэн байдал 18.2 хувь, хөдөө орон нутгийн иргэд сумын ИТХ -ын төлөөлөгчөө “маш сайн” болон “зарим талаар сайн” гэж үнэлсэн байдал 30 хувь байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулбал Улаанбаатар хотын иргэдийн үнэлгээ 3.2 хувиар өсөж, хөдөө орон нутгийн иргэдийн үнэлгээ 2.7 хувиар буурсан байна.

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдөд өгсөн дундаж үнэлгээгээр хөдөө орон нутгийн иргэд Улаанбаатар хотын иргэдээс 0.63 оноогоор өндөр үнэлсэн байна. Хэнтий аймгийн Батноров сумын иргэд хамгийн өндөр үнэлгээ өгсөн байна. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэд ИТХ -ын төлөөлөгчдөө хамгийн бага үнэлгээ өгсөн байна. Дүүргүүдээс Налайх дүүргийн иргэд хамгийн өндөр, Баянзүрх дүүргийн иргэд хамгийн бага үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 47: Сум/дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөд өгсөн үнэлгээ, байршлаар, n=1212

	Маш сайн	Зарим талаар сайн	Дунд	Зарим талаар муу	Маш муу	Мэдэхгүй/санахгүй байна	Хариулахаас татгалзсан	Дундаж үнэлгээ /1-5 оноогоор/
Нийт	10.7%	14.4%	33.8%	5.0%	14.6%	20.4%	1.1%	2.37
Улаанбаатар хот	6.4%	11.8%	31.5%	5.4%	16.0%	27.7%	1.2%	2.00
Хөдөө орон нутаг	13.8%	16.2%	35.4%	4.8%	13.6%	15.2%	1.0%	2.63
Дүүрэг:								
Багануур	7.7%	23.1%	46.2%	7.7%	7.7%	7.7%	0.0%	2.92
Багахангай	21.1%	15.8%	26.3%	5.3%	21.1%	10.5%	0.0%	2.79
Баянгол	6.6%	11.8%	30.3%	5.3%	9.2%	32.9%	3.9%	1.91
Баянзүрх	1.7%	8.5%	27.1%	3.4%	11.9%	45.8%	1.7%	1.42
Налайх	6.3%	15.6%	62.5%	6.3%	6.3%	3.1%	0.0%	3.00
Сонгинохайрхан	7.9%	15.8%	28.9%	3.9%	18.4%	23.7%	1.3%	2.16
Сүхбаатар	4.1%	8.2%	37.0%	11.0%	20.5%	19.2%	0.0%	2.07
Хан-Уул	3.5%	10.5%	19.3%	3.5%	31.6%	29.8%	1.8%	1.56
Чингэлтэй	8.3%	10.4%	29.2%	4.2%	12.5%	35.4%	0.0%	1.92
Аймаг, сумдаар:								
Дундговь аймаг	13.9%	12.0%	38.9%	5.6%	13.4%	16.2%	0.0%	2.59
Адаацаг сум	15.9%	18.2%	45.5%	0.0%	13.6%	6.8%	0.0%	3.02
Сайнцагаан сум	4.2%	5.2%	40.6%	8.3%	17.7%	24.0%	0.0%	1.98
Өлзийт сум	40.7%	18.5%	18.5%	7.4%	3.7%	11.1%	0.0%	3.52
Эрдэнэдалай сум	21.4%	14.3%	35.7%	3.6%	14.3%	10.7%	0.0%	2.93
Өндөршил сум	9.5%	19.0%	47.6%	4.8%	4.8%	14.3%	0.0%	2.81
Завхан аймаг	3.6%	21.4%	39.3%	3.6%	5.4%	25.0%	1.8%	2.34
Тэлмэн сум	3.3%	30.0%	36.7%	3.3%	6.7%	16.7%	3.3%	2.60
Улиастай сум	3.8%	11.5%	42.3%	3.8%	3.8%	34.6%	0.0%	2.04
Төв аймаг	27.7%	17.0%	31.9%	4.3%	14.9%	4.3%	0.0%	3.26
Батсүмбэр сум	22.7%	22.7%	31.8%	4.5%	18.2%	0.0%	0.0%	3.27
Эрдэнэсант сум	32.0%	12.0%	32.0%	4.0%	12.0%	8.0%	0.0%	3.24
Ховд аймаг	11.9%	17.8%	36.6%	5.0%	16.8%	10.9%	1.0%	2.67
Мянгад сум	20.8%	18.8%	43.8%	2.1%	8.3%	4.2%	2.1%	3.23
Жаргалант сум	3.8%	17.0%	30.2%	7.5%	24.5%	17.0%	0.0%	2.17
Хөвсгөл аймаг	7.0%	12.3%	34.5%	2.9%	21.6%	19.3%	2.3%	2.15
Арбулаг сум	14.0%	12.0%	42.0%	0.0%	6.0%	22.0%	4.0%	2.50
Мөрөн сум	1.5%	10.6%	30.3%	3.0%	28.8%	25.8%	0.0%	1.76
Тосонцэнгэл сум	3.1%	18.8%	28.1%	6.3%	31.3%	9.4%	3.1%	2.19
Жаргалант сум	13.0%	8.7%	39.1%	4.3%	21.7%	8.7%	4.3%	2.48
Хэнтий аймаг	24.2%	25.0%	29.2%	6.7%	3.3%	10.8%	0.8%	3.25
Батноров сум	41.7%	25.0%	20.8%	8.3%	0.0%	4.2%	0.0%	3.88
Баян-Адарга сум	30.0%	23.3%	30.0%	3.3%	3.3%	10.0%	0.0%	3.43
Биндэр сум	14.8%	22.2%	29.6%	3.7%	11.1%	18.5%	0.0%	2.70
Хэрлэн сум	15.4%	28.2%	33.3%	10.3%	0.0%	10.3%	2.6%	3.10

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Сайжруулах зүйл байлгүй яах вэ. Хорооны ИНХ өөрийн гэсэн төсөв санхүүгүй, сайн дурын шинжтэй байгууллага. Манай хорооны ИНХ 5 тэргүүлэгчтэй. Дарга нь тухайн засаг даргын цалингийн 30%-иар сар бүр урамшуулагдаж явдаг. Тэгэхээр цалин хөлс, үүрэг хариуцлагын хувьд хязгаарлагдмал учраас иргэдийг оролцуулахад хязгаарлагдмал байдаг. Сонирхлыг бага татаж байна гэсэн үг. Тиймээс хороодын ИНХ тогтсон орон тоотой цалинтай болгож, тухайн хорооны иргэд рүү чиглэсэн, иргэдийн санал бодлыг тусгасан үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгаа тал дээр анхаарал хандуулбал зүгээр санагддаг.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

Сум/дүүргийн ИТХ -ын төлөөлөгчөө “маш сайн” болон “зарим талаар сайн” гэж үнэлсэн шалтгааныг тодруулбал, мэдээлэл сайн өгч, асуудлыг нь шийдэж өгдөг бол сайн гэж үнэлдэг. Эсрэгээрээ мэдээлэл муутай, юу хийснээ иргэдэд хүргэж чаддаггүй, эсвэл иргэдийн санал, хүсэлтийг шийдвэрлэж өгч чадахгүй бол муу гэж үнэлдэг.

Хүснэгт 48: Сумын ИТХ -ын төлөөлөгч нарыг үнэлэх байдал, аймгаар, n=711


Аймаг	“Маш сайн” болон “Зарим талаараа сайн” гэж үнэлсэн шалтгаан	“Маш муу” болон “Зарим талаараа муу” гэж үнэлсэн шалтгаан
 Дундговь аймаг	Маш сайн болон зарим талаараа сайн гэж үнэлсэн 25.9 хувь: ✓ Ажлаа сайн хийдэг ✓ Гаргасан шийдвэрээ хэрэгжүүлдэг ✓ Иргэдэд хүрч ажилладаг ✓ Мэдээллээ сайн өгдөг ✓ Үйл ажиллагаа нь нээлттэй	“Маш муу” болон “зарим талаараа муу” гэж үнэлсэн 19.0 хувь: ○ Тайлан төсөв зарцуулалтаа бүрэн гүйцэт тайлагнадаггүй, уулзалтын давтамж хол ○ Ажлаа хийдэггүй ○ Ажлаа муу хийдэг ○ Мэдээлэл дутмаг ○ Сонгууль дөхөхөөр харагддаг ○ Иргэддээ хүрч ажилладаггүй. Гаргасан хүсэлтийг шийдвэрлэж өгөөгүй ○ Үр дүнгүй, цөөн хүний шийдвэрээр ажилладаг ○ Хурал цуглаандаа ирдэггүй ○ Хяналт сул
 Завхан аймаг	“Маш сайн” болон “зарим талаараа сайн” гэж үнэлсэн 25.0 хувь: ✓ Ажлаа хийж, тайлагнадаг ✓ Зарим асуудлыг шуурхай шийдэж өгдөг ✓ Мэдээ мэдээлэл цаг тухайд нь өгдөг	“Маш муу” болон “зарим талаараа муу” гэж үнэлсэн 8.9 хувь: ○ Ажил хийдэггүй ○ Заримыг нь ойлгодоггүй ○ Санал хүсэлтийг хүлээж авсан ч шийдвэрлэж өгдөггүй
 Төв аймаг	“Маш сайн” болон “зарим талаараа сайн” гэж үнэлсэн 44.7 хувь: ✓ Мэдээлэл сайн өгдөг ✓ Ажлаа сайн идэвхтэй хийдэг ✓ Асуудлыг минь шийдэж өгсөн ✓ Төлөөлөгч нар солигдсоноос хойш сайн болсон	“Маш муу” болон “зарим талаараа муу” гэж үнэлсэн 19.1 хувь: ○ Мэдээлэл муутай ○ Ажлаа хийдэггүй ○ Ялгаварлан үздэг

Аймаг	“Маш сайн” болон “Зарим талаараа сайн” гэж үнэлсэн шалтгаан	“Маш муу” болон “Зарим талаараа муу” гэж үнэлсэн шалтгаан
 Ховд аймаг	“Маш сайн” болон “зарим талаараа сайн” гэж үнэлсэн 29.7 хувь: ✓ Ажлаа сайн хийдэг ✓ Асуудлыг хурдан шийдвэрлэж өгдөг ✓ Нүдэнд харагдахуйц ажил хийдэг ✓ Залуусаа сайн дэмждэг ✓ Өндөр настанд нүүрс түлээний хөнгөлөлт үзүүлдэг ✓ Гэрэлтүүлэг сайн хийж байгаа ✓ Хөөмийг гиннест бүртгүүлж чадсан ✓ Хурал сар бүр хийдэг ✓ Шударга, авлига хээл, хахуульд автаагүй	“Маш муу” болон “зарим талаараа муу” гэж үнэлсэн 21.8 хувь: ○ Ажлаа хийдэггүй ○ Ил тод бус ○ Ард түмэнд хүрдэггүй, цөөн хүний төлөө ажилладаг ○ Ард иргэдтэйгээ тулж ажилладаггүй, уулздаггүй ○ Мэдээлэл ирдэггүй ○ Сонгууль дөхөхөөр л гарч ирдэг ○ Иргэдийн санал хүсэлтийг хүлээж авдаггүй ○ Хурал цуглаан хийхгүй байна ○ Ямар хүмүүс байдгийг нь мэдэхгүй
 Хөвсгөл аймаг	“Маш сайн” болон “зарим талаараа сайн” гэж үнэлсэн 19.3 хувь: ✓ Ажлаа сайн хийж байгаа ✓ Иргэдээ тусалж дэмждэг ✓ Ирж уулздаг ✓ Мэдээллээ сайн өгдөг ✓ Төхижилтын ажил хийсэн ✓ Хурал зөвлөгөөнөөр ажлаа тайлагнадаг ✓ Хүмүүстэй сайн тулж ажилладаг	“Маш муу” болон “зарим талаараа муу” гэж үнэлсэн 24.6 хувь: ○ Ард иргэддээ мэдээлэл өгдөггүй ○ Иргэддээ хүрч үйлчилдэггүй ○ Ажлаа хийдэггүй ○ Хурал цуглаан хийдэггүй ○ Юу хийсэн нь мэдэгддэггүй ○ Ямар хүмүүс байдгийг ч мэдэхгүй ○ Төлөөлөгч болоод ард иргэддээ үзэгддэггүй
 Хэнтий аймаг	“Маш сайн” болон “зарим талаараа сайн” гэж үнэлсэн 49.2 хувь: ✓ Хийсэн ажил нь тодорхой харагддаг ✓ Асуудлыг сайн шийдвэрлэж өгдөг ✓ Ард иргэддээ ойр ✓ Мэдээлэл сайн түгээдэг ✓ Ил тод ✓ Багийн эмэгтэйчүүдийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг ✓ Дэмжих зүйл дээрээ сайн дэмждэг ✓ Идэвхтэй ✓ Иргэдээ бүрэн төлөөлж чаддаг ✓ Иргэдийнхээ санал хүсэлтийг хүлээн авч, хариуг тэр дор нь өгдөг ✓ Иргэдээ сонсож чаддаг ✓ Сургалтын төлбөрийн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж өгсөн ✓ Өвөлжөө, хаваржааны асуудлаар уулзахад дор нь шийдвэрлэж өгсөн	“Маш муу” болон “зарим талаараа муу” гэж үнэлсэн 10.0 хувь: ○ Мэдээлэл муу ○ Асуудлыг шийдвэрлэж өгч чадаагүй ○ Үйл ажиллагаагаа мэдээлдэггүй ○ Ямар хүн байдгийг мэдэхгүй ○ Хэзээ хурал цуглаан хийдгийг мэддэггүй ○ Тайланг нь сонсоогүй

ИТХ-ын төлөөлөгчид тавигдах шалгуур

Судалгаанд хамрагдсан иргэд олон нийтээс сонгогдсон төлөөлөгч ямар шалгуурыг хангасан, ямар хүн байх хэрэгтэй талаар тодруулахад дараах үр дүн гарав. Үүнд: Шударга, Орон нутгийнхаа нөхцөл байдлыг сайн мэддэг, Иргэдийн санал бодлыг сонсдог байх гэсэн гурван гол үзүүлэлт чухалчилж байна. Улс төрийн намын буюу намын харьяалал, хөрөнгө мөнгөтэй байх гэдгийг хамгийн бага хувьтай чухалчилсан байна.

График 33: ИТХ-ын төлөөлөгчид тавих шалгуур, чухалчилж буй хүчин зүйлс, хувиар, n=1212



ФБЯ -ын тэмдэглэлээс:

Эмэгтэй хүн бол худлаа хэлэхгүй, хулгай хийхгүй, ичих нүүртэй. Энэ нь улс төрд давуу тал болно. Мөн хүнийг сонсохдоо илүү сайн болов уу гэж бодож байна.

Миний бодлоор эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай бусдын төлөө сэтгэлтэй бол хүйс хамаагүй.


Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ

ИТХ -д залуучуудын оролцоо хамгийн чухал. Энэ нийгмийг хөдөлгөх хүчин зүйл нь залуучууд. Залуучууд илүү хурдан сэтгэдэг, ааш авир нь эвдрээгүй, асуудлаас айхгүй шинэ зүйлийг туршиж хийх зоригтой.

Улаанбаатар хот, Иргэдийн ФБЯ

ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй нийт оролцогчдын 64.1 хувь нь санал нэгдсэн байна.


График 34: ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой эсэх, n=1212



ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой гэдэгтэй санал нэгдсэн болон санал нэгдээгүй иргэдийн хүйсийн харьцааг харвал эмэгтэйчүүд илүү өндөр хувьтай дэмжиж байхад эрэгтэйчүүдийн эсэргүүцэх байдал өндөр байна. Дэмжихгүй байгаа гол шалтгаан нь ИТХ -ын төлөөлөгчийн хүйсээс илүү мэдлэг, дадлага туршлага илүү чухал гэж үзэж байгаатай холбоотой. Мөн эмэгтэй хүний дуу хоолой хүчгүй байдаг гэж зарим оролцогчид дурдаж байв.

Харин эмэгтэйчүүдийн оролцоо чухал гэж үзэж байгаа шалтгаан нь эрэгтэй хүний хардгаас өөр өнцгөөр асуудалд ханддаг, эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн төлөө илүү ажилладаг гэж үзэж байна. Зан чанарын хувьд илүү тууштай, тэвчээртэй, олон ажлыг зэрэг амжуулах чадвартай байдаг гэж харж байна.

График 35: ИТХ-д эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх ёстой эсэх, хүйсээр, n=1212



2.5. Баг/хорооны ИНХ -ын талаарх иргэдийн оролцоо

Энэ бүлэгт иргэд баг/хорооны ИНХ -д хэр зэрэг идэвхтэй оролцдог, оролцдоггүй бол түүний шалтгаан, оролцсон бол хэдэн удаа оролцсон, мэдээллийг хэрхэн олж авсан талаар, хуралд хэлэлцсэн сэдэв, цаашид ИНХ -д оролцох идэвх зэргийн талаар тодрууллаа.

2.5.1. Баг/хорооны ИНХ -д оролцсон байдал

Баг/хорооны ИНХ -д оролцож үзсэн байдал Улаанбаатар хотод 20.6 хувьтай буюу 5 хүн тутмын нэг нь, хөдөө орон нутагт 49.2 хувьтай буюу 2 хүн тутмын нэг нь оролцсон байна. Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад Улаанбаатар хотын иргэдийн ИНХ -д оролцсон байдал 7.4 хувиар, хөдөө орон нутагт 7.5 хувиар буурчээ.

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн иргэдийн 47.4 хувь ИНХ -д оролцсон нь бусад дүүргээс хамгийн өндөр үзүүлэлт юм. Хан-Уул дүүргийн иргэдийн 8.8 хувь нь ИНХ -д оролцсон байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Сумын түвшинд авч үзвэл Төв аймгийн Эрдэнэсант сумын иргэд 72 хувь буюу хамгийн өндөр оролцоотой, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэд 22.7 хувь буюу хамгийн бага оролцоотой байна.

Хүснэгт 49: Баг/хорооны ИНХ -д оролцож үзсэн байдал, байршлаар, n=1212

	Тийм	Үгүй	Хариулахаас татгалзсан
Нийт	37.4%	62.3%	0.3%
Улаанбаатар хот	20.6%	78.8%	0.6%
Хөдөө орон нутаг	49.2%	50.6%	0.1%
Дүүрэг:			
Багануур	38.5%	61.5%	0.0%
Багахангай	47.4%	52.6%	0.0%
Баянгол	14.5%	85.5%	0.0%
Баянзүрх	15.3%	84.7%	0.0%
Налайх	28.1%	71.9%	0.0%
Сонгинохайрхан	25.0%	75.0%	0.0%
Сүхбаатар	24.7%	75.3%	0.0%
Хан-Уул	8.8%	91.2%	0.0%
Чингэлтэй	18.8%	78.1%	3.1%
Аймаг, сумаар:			
Дундговь аймаг	53.2%	46.3%	0.5%
Адаацаг сум	59.1%	40.9%	0.0%
Сайнцагаан сум	46.9%	53.1%	0.0%
Өлзийт сум	59.3%	37.0%	3.7%
Эрдэнэдалай сум	57.1%	42.9%	0.0%
Өндөршил сум	57.1%	42.9%	0.0%
Завхан аймаг	55.4%	44.6%	0.0%
Тэлмэн сум	70.0%	30.0%	0.0%
Улиастай сум	38.5%	61.5%	0.0%
Төв аймаг	61.7%	38.3%	0.0%
Батсүмбэр сум	50.0%	50.0%	0.0%
Эрдэнэсант сум	72.0%	28.0%	0.0%
Ховд аймаг	39.6%	60.4%	0.0%
Мянгад сум	50.0%	50.0%	0.0%
Жаргалант сум	30.2%	69.8%	0.0%
Хөвсгөл аймаг	42.1%	57.9%	0.0%
Арбулаг сум	52.0%	48.0%	0.0%
Мөрөн сум	22.7%	77.3%	0.0%
Тосонцэнгэл сум	50.0%	50.0%	0.0%
Жаргалант сум	65.2%	34.8%	0.0%
Хэнтий аймаг	52.5%	47.5%	0.0%
Батноров сум	66.7%	33.3%	0.0%
Баян-Адарга сум	66.7%	33.3%	0.0%

Биндэр сум	44.4%	55.6%	0.0%
Хэрлэн сум	38.5%	61.5%	0.0%

Баг/хорооны ИНХ -д оролцсон байдлыг нас, хүйс, өрхийн орлогын түвшнээр задлан харвал 35-44 насны бүлгийн оролцоо хамгийн өндөр байна. Хүйсийн хувьд том ялгаа байхгүй ч эмэгтэйчүүдийн оролцоо 1 хувиар өндөр байна. Өрхийн орлого нэмэгдэх тусам баг/хорооны ИНХ -д оролцох байдал багасаж байна.

Хүснэгт 50: Баг/хорооны ИНХ-д оролцсон байдал, нас, хүйс, орлогоор, n=1212

	Баг/хорооны ИНХ -д оролцож үзсэн
Насны бүлэг:	
18-24 нас	8.8%
25-34 нас	21.6%
35-44 нас	26.9%
45-54 нас	22.1%
55-64 нас	20.5%
Хүйс:	
Эрэгтэй	49.0%
Эмэгтэй	51.0%
Өрхийн сарын дундаж орлого:	
200,000 төгрөг хүртэл	11.0%
200,001-400,000 төгрөг	24.5%
400,001-600,000 төгрөг	22.7%
600,001-800,000 төгрөг	15.7%
800,001-1,000,000 төгрөг	10.2%
1,000,001-1,500,000 төгрөг	6.8%
1,500,001-2,000,000 төгрөг	2.4%
2,000,001 төгрөг болон түүнээс дээш	2.0%
Хариулахаас татгалзсан	4.6%

Өмнө нь баг/хорооны хуралд оролцож байсан иргэдээс өнгөрсөн жил буюу 2018 онд хэдэн удаа баг/хорооны хуралд оролцсон тоог тодруулбал, Улаанбаатар хотын иргэд дунджаар 4, хөдөө орон нутгийн иргэд дунджаар 2 удаа баг/хорооны хуралд оролцсон байна.

Баг/хорооны ИНХ -д оролцоогүй гол шалтгаан нь Улаанбаатар хотын иргэдийн хувьд “Хэзээ хаана болох талаар мэдээгүй/Мэдээлэл ирээгүй” гэж 52.2 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн хувьд “Завгүй байсан” гэж 42.5 хувь хариулсан байна.


График 36: Баг/хорооны ИНХ -д оролцоогүй шалтгаан, n=755



2.5.2. Баг/хорооны хурлын талаарх мэдээлэл авсан суваг


Өнгөрсөн жил буюу 2018 онд баг/хорооны хуралд оролцсон иргэдээс мэдээллийг хэрхэн олж авсан талаар тодруулахад, Улаанбаатар хотын иргэдийн хувьд нэгдүгээрт, баг/хорооны засаг дарга, түүний биет төлөөлөгч зар хүргэсэн, хоёрдугаарт, утсаар мэдээлэл хүргэсэн, гуравдугаарт, захиргааны байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан зараас мэдээлэл авсан зэрэг багтаж байна. Хөдөө орон нутгийн хувьд нэгдүгээрт, баг/хорооны засаг дарга, түүний биет төлөөлөгч зар хүргэсэн, хоёрдугаарт, утсаар мэдээлэл хүргэсэн, гуравдугаарт, Facebook хуудаснаас харсан байна. Facebook хуудас хөдөө орон нутагт үр ашигтай байгаагийн гол шалтгаан нь иргэд орон нутгийн ИТХ, орон нутгийн зарын групп зэрэгт идэвхтэй байдагтай холбоотой. Улаанбаатар хотын иргэдийн хувьд олон төрлийн Facebook page, group -д нэгдсэн байдаг учраас ИНХ -н талаарх мэдээллийг олж харах магадлал тэр чинээгээрээ буурч байгаа хэрэг юм.

График 37: Баг/хорооны хурлын талаарх мэдээлэл авсан суваг, байрилаар, n=453




Баг/хорооны ИНХ -д оролцсон иргэдээс хурал дээр хэлэлцсэн асуудлуудыг тодруулбал, хот болон хөдөөд орон нутгийн хөгжлийн сан, тайлан хэлэлцэх тухай нийтлэг яригдаж байна. Хөдөө орон нутагт бэлчээр ашиглалттай холбоотой зохион байгуулалтын асуудал, мал тоолох асуудлуудын талаар мөн түлхүү хэлэлцсэн байна.

График 38: Баг/хорооны ИНХ-аар хэлэлцсэн асуудал, байрилаар, n=453



Нийт судалгаанд оролцогчдоос баг/хорооны хурлын урилга, мэдээлэл ирвэл оролцох эсэхийг тодруулахад, Улаанбаатар хотын иргэдийн 47.1 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 63.2 хувь нь заавал оролцоно гэж хариулсан байна. Энэхүү үзүүлэлт нь өмнөх судалгааны үр дүнгээс Улаанбаатар хотын хувьд 4.7 хувиар, хөдөө орон нутгийн хувьд 6.8 хувиар буурсан байна.

График 39: Баг/хорооны хурлын урилга авбал оролцох байдал, n=1212



БҮЛЭГ 3. ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1. ИТХ-ын төлөөлөгчид тулгардаг асуудал, бэрхшээл

Энэ бүлэгт гол оролцогч талууд болох аймаг/сумын засаг дарга, багийн засаг дарга, засаг даргын орлогч, ИТХ-ын дарга, тэргүүлэгч, төлөөлөгч нартай хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагын үр дүнгээс ИТХ -ын төлөөлөгч нарт тулгардаг асуудал, бэрхшээлийг нарийвчлан тодруулав.

3.1.1. ИТХ болон засаг дарга хоорондын эрх мэдлийн тэнцвэрийг зохистой хангах байдал

ИТХ болон засаг дарга хоорондын эрх мэдлийн тэнцвэрийг зохистой хангахад юу саад болдог талаар гол оролцогч талуудаас тодрууллаа. Гол оролцогч талуудын хувьд дараах саад бэрхшээлүүд тулгардаг байна. Үүнд:

- ИТХ -ын дарга тамгын газрын жижиг, сажиг ажилд оролцох
- Хамтарч ажиллахад хоорондоо зөрчилдөх
- Хувийн болон намын ашиг сонирхлын зөрчил гаргах
- ИТХ төсөв мөнгөгүй учраас эрх мэдэл багатай байх */ИТХ нь өөрийн зарцуулах төсөв хөрөнгө байдаггүй. Төсөв мөнгөтэй үйл ажиллагаа явуулж буй хүн нь иргэдтэй ойр байдаг. Засаг дарга нь төсөвтэй харьцдаг учраас өөрийнхөө үйл ажиллагааг чөлөөтэй аваад явчихдаг гэж үзсэн байна./*
- ИТХ -ын төлөөлөгчид нэг намаас гарсан хүмүүс байдаггүй учраас мөрийн хөтөлбөр нь өөр өөр байх хандлагатай. Энэ нь хоорондоо зөрчилдөх шалтгаан болдог.
- Иргэд хурлын эрх үүргийг ойлгодоггүй, ач холбогдол бага өгдөг
- Иргэдийн хурлын дарга нь ХАА -н талын мэдлэггүй учраас малчдын асуудал орхигддог */Зөвхөн нэг сумын хувьд гарсан кэйс/*
- ИТХ -ын төлөөлөгч нь ЗД, ЗД-ын орлогч зэрэг давхар албан тушаал эрхэлдэг бол асуудлыг шийдэх чадамж нь илүү далайцтай байж чаддаг байна. Зөвхөн төлөөлөгч хүний шийдэх асуудлын цар хүрээ, оролцоо хязгаарлагдмал байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

ИТХ бол хамгийн дээд байгууллага. Сум орон нутгийн хөгжилд иргэдийн хурлын оруулах хувь нэмэр бага юм шиг санагддаг. Төсөв бага болохоор ч юм уу ерөнхийдөө тамгын газрын нэр доор явдаг. Өөрсдөө санаачлаад хийж байгаа юм бага. Төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагатай хамтарч ажиллах ажиллагаа сайн. Олон нийтийн ажилд маш бага оролцдог. Эрх мэдлийг тэнцвэртэй байлгахад хөрөнгө мөнгө, ИТХ-ын үүрэг оролцоог сайжруулж, чадваржуулах хэрэгтэй.

Дундговь аймаг, Өлзийт сум, сумын засаг даргын орлогч

Сумын иргэдийн хурал нь сумын засаг даргаа шахааж ажиллуулж чаддаг. Тодорхой хийх ажлуудыг нь бодитой болгож чаддаг. Ийм ийм бодлого хэрэгжүүлэхэд ийм ийм арга хэмжээ ав, тэрийгээ хагас юм уу бүтэн жилээр дүгнэж чадахуйц хэмжээний тогтолцоог өөрөөр хэлбэл хариуцлагын тогтолцоотой шалгууруудыг хийж чаддаг л байх ёстой. Нэг талаасаа сумын иргэдийн хурал нь хөрөнгө мөнгөний асуудал нь сумын засаг даргаас хамааралтай, төсвийнхөө хувьд хэдийгээр бие даасан байгаа харагдаж байгаа боловч унаа тэрэгний асуудал зарим нэг талаараа засаг даргаас хамааралтай байдаг.

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, ИТХ төлөөлөгч

Засаг бол гүйцэтгэлийн байгууллага, хурал бол төлөөллийн байгууллага. Хамгийн гол нь энэ шинэ үндсэн хуулиар засаг даргыг ард түмэн сонгодог болно. Иргэдийн хурал нь сонгодог болно гэдэг ээ больсон шүү. Ер нь тэнцвэрийн хувьд төлөөллийн байгууллага хуралдаа хандаж байгаа иргэд маш цөөхөн. Иргэд бүх л үед засаг даргад ач холбогдол өгдөг. Засаг дарга ихээхэн ачаалалтай. Иргэдийн хурал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөвлөл хяналт тал дээр түлхүү ярьж байгаа. Гэхдээ ерөнхий үйл ажиллагаа дээр нь жоохон тэнцвэр өгөх юм бол аль аль талдаа тустай.

Хөвсгөл аймаг, Жаргалант сум, засаг даргын орлогч, ИТХ-ын төлөөлөгч

Хурал нь бас их эрх мэдэлтэй боловч тэрийгээ орон нутгууд яг мэддэггүй. Засаг дарга л бүх юм гүйцэтгэдэг юм шиг. Яг үнэндээ хурал нь ийм шийдвэрийг гаргах эрх мэдэлтэй байдаг. Иргэдийн харж байгаа байдал нь ийм тэрийгээ мэдэх хэмжээний хүн нь цөөхөн. Иймээс хурлын үүргийг бага хэмжээнд хардаг юм.

Завхан аймаг, Улиастай сум, ИТХ-ын тэргүүлэгч

Манай суманд бол ИТХ болон Засаг дарга хоорондоо хамтарч ажиллаад явдаг. Зарим сумдад хамтарч ажиллах талаар учир дутагдалтай. ИТХ-ийн дарга нь дээрээсээ гаргасан шийдвэрээ зөрчсөн, засаг дарга нь гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхгүй байх гэх мэт. Заримдаа тийм асуудал байдаг байх. Манай дээр бол тийм асуудал байхгүй.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

ИТХ болон Засаг дарга хоорондын эрх мэдлийн тэнцвэрийг зохистой хангахад хууль эрх зүйн хувьд гайгүй байх гэж боддог. Аль алийнх нь эрх үүргийг хуулийн хүрээнд сайн тусгаж оруулсан гэж боддог. Яг амьдрал дээр харахад улс төрийн намын дарга нь засаг дарга болдог. Дэд дарга нь юм уу тэргүүлэгчдээс нь хурлын дарга болно. Тэгэхээр манай дүүргийн хувьд яг тэнцвэртэй авч явж чадаж байна гэж хардаг. Энэ асуулттай чинь уялдаад бодоход манай дүү сумын ИТХ-н дарга хийдэг. Тэгээд тэр сумын удирдлагуудын ганц нэг хүнээс сонсож байхад яг адилхан намын дарга нь засаг дарга, доод шатны дарга/ИТХ-ийн тэргүүлэгч залуу хүн байхаар засаг дарга нь ИТХ-ийн тэргүүлэгчийнхээ үгийг хүлээж авдаггүй, намын даргынхаа зүгээс шийдвэрлэж явдаг зүйл байдаг юм билээ. Энэ бол доголдолтой зүйл. Би тэрийг өөрөө мэддэг байсан. Өөрийнхөө дүүрэг дээр болж байгаа өнцгөөс харахаар болоод байгаа юм шиг манай энэ 2 маш сайн удирдлага учраас надад тэр ялгаа харагддаггүй байсан юм байна. Гэтэл дүүгээ яг ажиллаад ирэхээр тэр нь харагдаж байна. Манай дүү сая намайг очиход хэлж байна. Би яадаг юм билээ. Бид 2 нэг намын хоёр. Аль ч намын үед ийм ялгаа маш сөрөг үр дагавартай байдаг. Нарийн бичгийн дарга нь хүртэл хэлж байсан. Надтай ярилцаж байгаад дүүргийн засаг даргаар зөвшөөрөл аваад нарийн бичиг нь ирж туршилага солилцон уулзаж байсан. Манай засаг дарга ИТХ-ийн тэргүүлэгчийн үгийг авдаггүй, үл ойшоодог. Үүнийг та нар яаж шийддэг вэ гэж асууж байсан. Тэгэхээр тэр өөр орон нутагт маш том асуудал байдаг юм байна. Бусдыг бол сайн мэдэхгүй. Миний харсан өнцөг л ийм байсан.

Үндсэн хуульд заасан төрийн удирдлагыг нутгийн өөрийн удирдлагатай хослуулж явахгүй бол болохгүй. Чиглэл нь өөр, чиг үүрэг нь ижил, зорилго зорилт нь нэг талдаа. Гэтэл эрх мэдэл эсвэл давуу эрх ашгаасаа зөрчилдөхийг үгүйсгэхгүй юм байна гэж харсан. Хууль дээрээ яаж тусгах талаар би өөрөө нухацтай харж үзээгүй учраас сайн хэлж мэдэхгүй байна.

Багануур дүүрэг, засаг дарга

3.1.2. Дээд шатны байгууллагаас дэмжлэг үзүүлэх байдал

Гол оролцогч талуудад дээд шатны байгууллагуудаас дэмжлэг үзүүлэх байдлыг тодруулахад дараах байдлаар дэмжлэг тусалцаа үзүүлдэг хэмээн дурдав. Үүнд:

- Тавьсан саналыг шийдвэрлэж өгөх
- Санал гомдол гаргахад шийдэх
- Аймаг орон нутгийн төсвөөр оруулж чадаагүй ажлуудыг улсын төсөвт оруулах
- Гаргасан бодлого шийдвэрийг дэмжих
- Алдаа дутагдалтай зүйлсэд шүүмжлэл, зөвлөмж өгөх
- Сумын засаг дарга нар хөдөө явах унаа, мөнгө санхүүгийн асуудал зэргийг шийдэж өгөх
- Тулгамдсан асуудлуудыг иргэдийн хуралд оруулах тал дээр хамтрах зэргээр тусалцаа үзүүлж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Аймгийн хурал, аймгийн удирдлага УИХ-н даргад саналууд нэлээд их тавьдаг тэр саналууд маань ерөнхийдөө сайн хэрэгжсэн. Аймгийн удирдлагуудыг явж байхад замтай холбоотой төслийг сайжруулах тал дээр иргэдийн хурлын төлөөлөгчид хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотой саналуудыг оруулж дэмжигдсэн.

Хөвсгөл аймаг, Жаргалант сум, засаг даргын орлогч, ИТХ -ын төлөөлөгч

Ер нь бол багийн дарга нарыг нэг их дэмждэггүй гэж боддог. Гол төлөв үүрэг гэдэг болохоос яг шат шатандаа уялдаа холбоотой ажиллахгүй. Хурлын төлөөлөгчөөс нэг их тийм зүйл харагддаггүй.

Завхан аймаг, Тэлмэн сум, багийн засаг дарга, ИТХ -ын төлөөлөгч

Дэмжлэг үзүүлдэггүй. Мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт бага явагддаг. Би өмнө нь ажилласан ямар ч туршилагагүй юу ч мэдэхгүй байж байгаад сургуулиа төгсөөд төрийн албанд орж ирсэн. Анх удаа төрийн албанд орж ирж байгаа хүнд төрийн алба ийм байдаг, хууль ийм байдаг, ийм ийм хуулийн хүрээнд ажлаа явуулдаг, засаг захиргааны нутаг дэвсгэрийн хүрээнд төлөөлөгч нар ингэнэ тэгнэ гэдэг анхан шатны зүйлүүдийг зааж өгөхгүй бол хуучин ажиллаж байсан хүмүүс нь тэгж сайн өлгийдөж хүлээн авахгүй. Чи ингэнэ тэгнэ гээд үндсэн чиг үүргийг нь сайн зөвлөж хэлж өгдөггүй. Юм мэдэхгүй залуу хүүхэд гэсэн өнцгөөр таагүй ханддаг. Мэдэхгүй зүйлийг нь заагаад туслаад өгдөггүй. Ядаж дээд шатны байгууллагаас судалгаа аваад энэ онд танай албан хаагч нар ямар ямар сургалт хэрэгтэй байгааг тодруулаад чадавхжуулах юм уу манлайлуулах юм уу гэдгийг хийдэггүй. НҮБ-ийн шугамаар уг нь зөндөө сургалтууд хийдэг. Гэхдээ дандаа төлөөлөгч нарыг чадавхжуулах, манлайлуулах сургалтууд байдаг. Гэтэл төлөөлөгч нар нь ихэвчлэн туршилагатай хаана юу хийхээ мэддэг хүмүүс байдаг. Төлөөлөгч нарын ар талын ажлыг авч явдаг ажлын албаны хүмүүсийг чадавхжуулах, туршилага судлуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж байх хэрэгтэй.

Багануур дүүрэг, дүүргийн ИТХ -ын төлөөлөгч

Тухайн бие төлөөлөгч үйл ажиллагаа явуулахад дээд шатны байгууллага шууд тусална гэж хэлэхгүй. Тухайн төлөөлөгчийн өөрийн оролцоо чухал жишээ нь сургуулийн өмнөх боловсролын иргэн хүүхдээ цэцэрлэгт оруулаад өгөөч гэхэд бид нар тухайн цэцэрлэгийн байгууллагатай очиж уулзана. Энэ хүүхдийн цэцэрлэгт хамруулж өгөөч гэхэд манай тойргийн хүүхэд гэж хэлээд бид нар хоорондоо уялдаа холбоотой байдаг. Бид шууд тусалж чадахгүй.

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын дарга

Мэдээж үйл ажиллагаа явуулахад техник хэрэгслээр хангаж байна. ИНХ-ийн өрөөний засвар, тоног төхөөрөмж, сандал ширээгээр хангаж байна. ИНХ-аас гарсан шийдвэрүүдийг иргэдэд таниулах иргэний танхимын ажилтан тусалж байна. Яг зөв шийдвэр гараад иргэдийн оролцоо өндөр байх юм бол дээд шатны байгууллагын аппаратууд хороон дээр ирж ажиллахад бэлэн байдаг. Миний хувьд дажгүй тусалцаа үзүүлдэг гэж хэлмээр байна.

Улаанбаатар хот, ХУД, ИТХ -ын төлөөлөгч

3.1.3. ИТХ -ын зүгээс гаргасан шийдвэр оновчтой байж чаддаг эсэх

Гол оролцогч талуудын үзэж буйгаар ИТХ -ын зүгээс гаргасан шийдвэр ихэвчлэн оновчтой байдаг гэж үзсэн байна. Шийдвэр гаргалтад иргэд болон гол оролцогч талууд оролцоод, саналаа эрэмбэлээд явдаг учраас дараа нь гарсан үр дүнтэй маргах асуудал бага байдаг байна. Мөн гаргасан шийдвэрүүд дийлэнх тохиолдолд үйл ажиллагаагаа цааш явуулахад дэмжлэг болж чаддаг гэж үзжээ.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Бид нар өөрсдөө санал хүсэлтээ оруулж ирдэг. Дээрээс нь тамгын газар болон бодлогын хороод дээр асуудлаа хэд хэдэн удаа оруулахаар шийдвэр гаргах түвшинд бидний асуудал шийдэгдэж чаддаг. ИТХ-д саналаа тавьж байсан, саналыг хүлээж аваад шийдвэрт нь тусгагдсан.

Багануур дүүрэг, засаг дарга

Оновчтой байж чаддаг. Гаргаж байгаа шийдвэрүүд дээр иргэдээс урьдчилан санал бодлыг нь авч гаргасан шийдвэр илүү бодитой болдог. Үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болж чаддаг. Жил болгон санал дэвшүүлж байгаа. Оруулж байгаа саналуудын хувьд дэмжигдэж байгаа саналууд байгаа бас дэмжигдэхгүй мартагдаж байгаа ч саналууд бий.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

Ер нь ИТХ-аас гаргаж байгаа шийдвэр төлөөлөгч нарын үйл ажиллагаанд оновчтой байхын тулд гаргадаг. Аль болох тэнцвэртэй байхын тулд. Яагаад гэвэл өөрсдөө төлөөлөгч нараас бүрдэж байгаа байгууллага учраас. Тойрог тойргийн эрх ашгийг тэнцүү барихгүй бол ялгавартай шийдвэр гаргаж болохгүй. Яг л бүх тойрогт таалагдсан шийдвэр гаргасан байх ёстой.

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын дарга

3.1.4. Иргэдийн ИНХ -д оролцох байдлыг үнэлж буй байдал

Иргэдийн оролцоо зарим газарт сайжирч, зарим газарт муудаж байна гэж гол оролцогч талуудын ярианаас дүгнэлээ. Оролцоо сайжирч байгаа шалтгаан нь ИТХ нь ажлаа идэвхтэй хийж, иргэдийн санал, санаачилгыг хүлээн авч, цааш нь шийдвэрлэх, сайн санал санаачилга гаргасан иргэдээ урамшуулах замаар идэвхтэй ажиллахад иргэд идэвхжиж, урамшин оролцоо нь сайжирдаг байна. Идэвх оролцоо сайтай бүлэг нь гол төлөв 30 -аас дээш насны, эмэгтэйчүүд байдаг байна. Залуучуудын оролцоо хангалтгүй байна гэж бүхий л орон нутагт үзэж байна.

Иргэдийн оролцоо буурч байгаа шалтгаан нь иргэдийн улс төрд итгэх итгэл багассан, ИНХ -аар эцсийн шийдвэрүүд гарахгүй байх, хурлын зохион байгуулалт хангалтгүй болох, үүргээ ухамсарлахгүй байх, ажил төрөл ихтэйн улмаас ИНХ -д ирэхгүй байх, ИНХ -ын талаар ямар ч ойлголцоггүй байх зэрэг шалтгаан хүчтэй нөлөөлж байна гэж үзжээ.

Хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын ИТХ -ын төлөөлөгч, засаг дарга нар ИТХ -ын үйл ажиллагааг ил тод байдаг гэж үзэж байна. Гэвч иргэд олон нийт тавигдаж буй мэдээллийг анхаарах, ач холбогдол өгөх нь бага байдаг гэж үзэж байна. Үйл ажиллагааны шийдвэрүүдээ голчлон албан ёсны веб хуудас болон сошиал сувагт байршуулдаг байна.

Иргэдийн оролцоог хангах нь чухал боловч бүх асуудалд оролцуулах нь буруу гэж үзэж байна. Тухайлбал, хууль тогтоомж, дүүрэгт хэрэгжүүлэх хөтөлбөр, бодлогын баримт бичиг боловсруулах зэрэгт иргэд оролцдоггүй гэж байв.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Би дээр хэлсэн. Айл гэх тохитой бол айл гэр амгалан байдаг. Багийнхаа иргэдийн дунд олон сайхан арга хэмжээ зохион байгуулдаг. Баг нь сайхан тохитой, иргэдээсээ асуудлаа сонсож харилцан ярилцаж асуудлаа шийддэг. Иргэн Батын санаачилсан ажил ингээж сумын ИТХ-өөр төсөв нь батлагдаж ажил хэрэг боллоо гээд олон түмэнд танилцуулахаар хүмүүс их баярладаг. Мэргэн зөвлөгөө өгч байдаг танд баярлалаа гэхээр бас хүмүүс ч бас талархдаг тэр хүний идэвх ч жилээ нэг даадаг. Майдар эргэдэг гэдэг шиг. Зөв ярьж хэлсэн хүмүүсийг олон түмний өмнө хэлж алдариуулах нь хүмүүс хуралдаа их идэвхтэй оролцдог юм болов уу гэж боддог. ИНХ-д харилцан адилгүй насны хүмүүс оролцдог. Хөдөөгийн баг дээр гэвэл голдуу малчид их байдаг. Ингэхдээ 35-60 насны хүмүүс байх ба хүйсийн хувьд бараг тэнцүү. Гэхдээ 55% нь эмэгтэйчүүд байдаг. Эрчүүд нь малдаа голдуу явдаг.

Хэнтий аймаг, Батноров сум, сумын засаг дарга

Иргэдийн идэвх сүүлийн жилүүдэд дээрдэж байгаа. Учир нь хүмүүсийн сэтгэлгээ, ойлголт өөр болж байгаа. Хүмүүс мэдээлэл сонсьё, хуралдаа очъё гэдэг тал дээрээ арай дээрдэж байгаа. Иргэдийн хуралд иргэдээ оролцуулахын тулд тодорхой хэмжээнд явж мэдээллийг өгдөг ч ирц бүрэн дүүрэн болгох үгүй дээ гэхэд 70-80%-д хүрэхэд асуудалтай л байдаг.

Хуралд голцуу малчид оролцдог. Насны хувьд хөгийн, дундаж болон залуу хүмүүс холимог байдаг. Хүйсийн хувьд эмэгтэй голдуу байдаг. Залуучуудын оролцоо нь хангалтгүй байгаа. Настай хүмүүс нь арай илүү идэвхтэй ирдэг. Залуучууд ажилтай төрөлтэй болоод ирдэггүй л байх. Гэхдээ хөдөө байгаа хүмүүс сумын төв дээр байгаа хүмүүсээс илүү амьдарч байгаа учраас мэдээлэл сайтай байна. Хөдөөгийн багууд аравтын системээр учраас мэдээлэл дамжуулахдаа тэгж л явж байгаа. Зарим эмхэлж чадаагүй юм бий. Төвийн багт байгаа айлууд хүүхдүүдээ сургуульд сахиж байснаа буцаад гараад явчих асуудал байдаг. Тэрнээс бусдаар бол идэвхжиж эхэлж байна.

Хэнтий аймаг, Баян-Адарга сум, багийн засаг дарга

ИНХ-д иргэд оролцдоггүй. Би 12 жилийн юмыг ярина. Иргэд идэвхгүй байдаг. Яг ИНХ дээр чухал асуудал яригддаггүй. Орон нутгийн хөгжлийн санг хасчихъя. Газар олголт байхгүй байлаа гэж бодъё. Тэгвэл тэнд юу хэлэлцэх үү хэлэлцэх ярилцах зүйл юу ч байхгүй. Засаг захиргаа, түүний нэгж нутаг дэвсгэрийн хууль дээр багийн иргэдийн нийтийн хурал дээр тухайн багийнхаа нийгэм эдийн засгийн байдлыг хэлэлцэж болно, шагнал урамшууллыг шагнуулахаар тодорхойлж болно, багийн даргаа томилох, дээд шатны байгууллагад уламжлах, чөлөөлөх гэснээс өөр зүйл байдаггүй. Гэхдээ багийн даргыг сонгох, чөлөөлөх хурал дээр иргэдийн идэвх өндөр байдаг. Хэн нь ялах, хэн нь унах нь гээд очдог. Одоо орон нутгийн хөгжлийн сан дээр ямар асуудал яригдаж ямар ажил хийгдэх гэж байна гээд арай л дээр гэхдээ санаанд хүртэл цугларч чаддаггүй. Би багийн ИНХ-ийн дарга байхдаа хурлын ирцээ хуулийн хэмжээнд заасан ирцэд хүргэж үзээгүй. Манайх 4 өрхөөс нэг хүн цуглавал болно гэдэг. Гэтэл 400 өрхөөс 100 гаруй хүн цуглуулах ёстой. Тэгэхэд 70-80 хүн ирдэг байсан ба бараг 20% нь ирдэггүй байсан. Хуралд өндөр настнууд, тухайн өдөр ээлж хийж байгаа албан хаагч нар ирнэ өөр хэн ч ирэхгүй. Насны хувьд өндөрт настнууд тухайн өдөр төрийн ажилтай байсан 25-35 насны залуучууд ирдэг.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, аймгийн ИТХ -ын төлөөлөгч

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Идэвхгүй байгаа яагаад гэвэл тухайн иргэд маань өөрийнхөө язгуур эрх ашгийн хөндсөн шийдвэрүүд гарахгүй байгаа учраас хүмүүс суух сонирхолгүй. Нөгөө л төрийн байгууллага уруу хандахаас орон нутгийн байгууллага уруу хандах шаардлага байхгүй. Татвар хөнгөлөхгүй нэмэх хасах тухай эрх мэдэл байхгүй, газрын асуудал гэх мэт. Хөнгөлөлт үзүүлж орон нутгийн түвшинд шийдэхгүй байгаа учраас ирэхгүй байна. Уг нь бол орлогоо бүрдүүлэх эрх мэдлийг сум мэддэг нөгөө талаасаа ямар иргэн ямар аж ахуй байгууллагыг зохих хэмжээгээр хөнгөлж болох уу гэдгийг энэ 2-н тэнцвэрт байдлыг явуулдаг байвал хүмүүс оролцоно.

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, ИТХ-ын төлөөлөгч

Иргэд ИНХ -даа оролцдог. Хөдөөгийнхөн бол газар усны асуудал шийдвэрлэхэд сайн оролцдог. Манай сумынх бас байгууллага байгууллагаараа шийдүүлэх асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд идэвхтэй оролцдог. Арай дээр болж байгаа юм болов уу гэж бодож байна. Дээр хүмүүст орчны цэвэрлэгээний талаар санал гаргахад хувь хүмүүс оролцож байсан. Хүмүүсийн ухамсар бас арай өөр болж байна. Хэн ч гэсэн аятайхан цэвэр цэмцгэр орчинд амьдрахыг л бодож байгаа байлгүй. Оролцож байгаад нь талархаж байна. Бүх насныхан суудаг. Байгууллагууд дэмжих юм аа дэмжинэ. Удирдлагуудад нь хэлээд суулгана. Зарим нь дуртай, дургүй хүмүүс байж л байдаг. Яг ажлынх нь цаг байвал хэцүү. Ажлын бус цагаараа хүрээд ирдэг. Ерөнхийдөө удирдлагаараа хэлүүлж ирнэ дээ. Хэлүүлэхгүй хурал болж байсан нь ерөнхийдөө байхгүй. Хамтраад л ажилладаг. Зарим нь ажилгүй хүмүүс мөнгөтэй ажил руу л явчихдаг. Хүмүүс мөнгө өгье мал гаргаад өг гэдэг ч юм уу тэр үед бол заавал суу гээд байж чаддаггүй. Тиймэрхүү хүмүүс юм өгнө гэвэл ирэх байх. Ерөнхийдөө зарим нь ирдэг.

Дундговь аймаг, Эрдэнэдалай сум, багийн засаг дарга

Би иргэдийн оролцоо айхтар нэмэгдэхгүй байна гэж хэлсэн. Өсөхгүй буурахгүй нэг хэвийн байна гэдэг нь төр захиргааны ажил ийм л юм байдаг юм байна гээд ТВ, сошиал орчноос мэдээллээ авчхаж байгаа учраас заавал тэр хурал суух хэрэг байна уу гэсэн хандлага байдаг юм болов уу гэж би хөндлөнгөөс хардаг. Гэхдээ манайх ахмадууд голдуу учраас хүрэлцээд ирдэг. Залуучуудын ирц идэвх сул байна гэж хардаг. Хуралд ирж байгаа залуучуудыг ахмадуудтайгаа харьцуулбал зууны 40% нь байдаг. Арай бага учраас би нэг удаа идэвхжүүлэх зорилгоор залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж үзсэн. Залуучуудаа уулзуулахын тулд УИХ-ийн гишүүнтэйгээ хамтраад дэвтэр бал авах жаахан санхүүгийн дэмжлэг аваад залуучуудаа уулзуулж үзсэн. Бүх хүнд урилга тараагаад явсан. Ирц 60%- тай байсан. Сүүлийн үед иргэдийн идэвх бага байна. Мөн идэвхийг нь сайжруулахын тулд залуучуудын уулзалтаас гадна залуучуудын зөвлөл гэж байгуулсан. Хороон дээрээ байгаа залуучуудаа нийгмийн идэвхтэй болгох гээд үзэхээр тэд нарын хувьд уралдаан тэмцээн гээд хөгжсөөнт тал руугаа илүү сонирхолтой байсан. Голдуу настай хүмүүс иргэдийн дуу хоолой болж байна. Фейсбүүкээр гучин хэдэн насны залуучууд харьцангуй орж ирж байна. 20-30 насны залуучууд ховорхон байдаг.

Багануур дүүрэг, засаг дарга

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Иргэдийн ИНХ-д оролцох идэвх сулрах талдаа хандаж байна. Энэ нь иргэдийн төрд итгэх итгэл суларсантай холбоотой. Яагаад сулраад байна гэхээр төр гэсэн байгууллага маань анх гарч ирэхдээ сонгуулиар бий болдог. Сонгуулиар амласан амлалт, мөрийн хөтөлбөрөө биелүүлэхгүй байгаагаар холбоотой. Иргэд энэ дээр нь эргээд хариуцлага тооцох дээр тааруу болсон. ИНХ иргэний амьдралд нөлөөлөх шууд шийдвэрийг гаргадаггүй учраас тэдний оролцоо сул байгаа.

Идэвхтэй байх талаас нь хуульд байгаа хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхийг хичээдэг. Иргэн Та оролцсоноор төсөв яаж өөрчлөгдөж болох юм, бид нар өөрийн орчныг сайжруулах тал дээр тухайн жилийн төсөвт ямар ямар ажлуудыг суулгаж өгч болох юм, бусад орон нутгийн хэмжээний албан тушаалын томилгоог хийхэд засаг дарга миний бие гэсэн албан тушаалтныг томилоход иргэдийн оролцоо байснаар яаж оновчтой хүнийг сонгон томилж гаргаснаар удирдлагыг сайжруулах нутгийн өөрөө удирдах байгууллагын анхан шатны үйл ажиллагааг чанартай байлгах, идэвхтэй байлгах, мэдээж үйлчилгээг нь илэн далангүй нээлттэй байлгах тал дээр аль болох иргэдийн оролцоо сайн байвал энэ бүхэн өөрсдийнх төлөө хийж байгаа үйл ажиллагаа гэдгийг ойлгуулахыг хичээдэг.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

Иргэдийн оролцоо сайн. Өмнөх жилүүдээ бодвол оролцоо нэмэгдэж байгаа. Яагаад нэмэгдэж байна гэхээр хороон дээр хийгдэж байгаа ажлууд их байдаг учраас иргэд их ирдэг. Хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл авахыг хүсдэг. Энэ ажил хийгдсэнээр цаашид ямар ямар үйл ажиллагаанууд хийгдэх талаар иргэд сонирхож их ирдэг болсон. Манайх бүтээн байгуулалт их хийж байгаа учраас иргэдийн оролцох сонирхол их болоод байгаа. Хорооноос асууж тодруулах зүйл их болоод байгаа. Ер нь хурал зөвлөгөөн гэхгүйгээр байнгын ажил дээр ирж “Би тэр хэсгийн тийм хүн байна. Надад хороогоор орж ирэх цаг зав байдаггүй. Би ажил төрөлтэй хүн. Таны тавьж байгаа мэдээллийг хэвлэл мэдээллээр, фейсбүүкээс хараад явж байна, хэсгийн ахлагч нараас сонсоод явж байна. Яг үүн дээр би өөрөөс тань мэдээлэл авч өөртөө бүрэн итгэлтэй болмоор байна.” гэж орж ирдэг. Харин сүүлийн үед ихсэж байгаа. Тэр хүмүүс маань мэдээллээ аваад цаашидаа яах талаараа шийдвэрээ гаргаад явж байгаа. Сүүлийн үед миний өрөө хурлын өрөө шиг хүмүүс их цуглардаг болсон. Хүмүүсийн гол цугларч байгаа гол шалтгаан нь дэд төвийн бүтээн байгуулалттай холбоотой. Иргэдийн их ирээд байгаа, хурал зөвлөгөөнд ороод байгаа шалтгаан нь энэ. Энэ төслийг би өөрөө санаачилсан бөгөөд санаачилсан хүнээс юм асуух гэж их ирдэг. 2010 оноос судалгаа нь хийгдээд 2017 оноос бүтээн байгуулалт нь эрчимтэй хийгдэж байна. 2010 оноос судалгаа нь нэлээн удсан, 2012-2016 онд гацсан. 2017 оноос эрчимжээд ажил нь явагдаж байна. Дэд бүтцүүд нь бүрэн тавигдаад дуусах гэж байна. энэ том бүтээн байгуулалт явж байгаагаар холбогдуулан манай энэ хавь ямар болох вэ гээд мэдээлэл авах гэж нэлээн ирж байгаа.

Улаанбаатар хот, СХД, хорооны засаг дарга, дүүргийн ИТХ -ын төлөөлөгч

3.1.5. ИНХ -д бүх насны, нийгмийн бүх түвшний хүмүүсийн төлөөллийг оролцуулахын тулд хийгддэг ажлууд

Гол оролцогч талуудын хувьд ИНХ -д бүх насны, нийгмийн бүх түвшний хүмүүсийг оролцуулна гэдэг тун төвөгтэй асуудал байна. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах, 10 -тын системээр ажиллах, залуучуудын өдөрлөг зохион байгуулах, эмнэлгийн үзлэг зохион байгуулах гэх мэт арга хэрэгслийг ашигладаг талаар өмнө нь дурдсан. Гэсэн хэдий ч ажил эрхэлдэг, залуу насны бүлэг хуралд оролцохгүй орхигдоод байгаа нь ИТХ -д тулгамдаж буй том бэрхшээлийн нэг билээ.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

ИТХ хурал яг үнэндээ ахмадууд их оролцдог залуус байхгүй. Иргэн болгонд бүх мэдээлэл очдог хүрдэг хүмүүсийн сонирхлын хандлага байна. ИТХ, хороог залуус нь юу гэж хардаг вэ гэхээр тэтгэврийн байгууллага, тэтгэвэрт гарсан хөгшичүүл орж гардаг байгууллага, хороон дарга гэж тодорхойлолт бичиж өгдөг гэдэг ойлголттой байдаг. Ер нь ажилд орохын тулд шаардлагатай бол хороон дээр очиж тодорхойлолт авч байна. Өөр бол ИТХ гэдэг нь ийм байна гээд сонирхож байгаа залуу хүмүүс огт байхгүй.

Залуучуудад ойлгуулахын тулд хороон даргын нэрэмжит спорт урлагийн наадам залуучуудын дунд зугаалга, явган аяллын клуб эдгээр ажлуудыг хороо дүүргийн төлөөлөгч гээд иргэдийн дунд хийж байгаа. Тэдгээрт оролцож байгаа хэсэг залуучууд хороо ийм байдаг юм байна, хурал ийм юм байдаг гэдэг жосоохон ойлголттой болоод гарна. Эргээд хуралд залуучууд нь байхгүй. Яагаад гэвэл өөрийн өдөр тутамд хэрэг болох ажилдаа анхаарлаа тавьдаг.

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын дарга

Залуучуудын оролцоо тааруу учраас зарим учир дутагдалтай байдаг. Ахмадууд өөрсдөө хэлдэг залуучуудын дуу хоолой байхгүй учраас тулгаа тойрсон гэрэлтүүлэг, зам харгүй гэсэн асуудлууд л орж ирээд байгаа болохоос залуучууд талаасаа юу дутагдаад байгаа гэсэн зүйл орж ирдэггүй. Бид нар залуучуудын байгууллагатай харьцаад залуучууд яг юу хүсээд байна, ямар хүлээлт байна гээд санал гомдлыг нь асуудаг. Аймаг орон нутгаас залуучуудад чиглэсэн дэд хөтөлбөр байдаг. үүнд залуучуудын байгууллагыг аль болох дэмжсэн, санхүү мөнгийг нь ахиу тусгаж өгье, тэндээсээ залуучуудад зориулсан уралдаан тэмцээний хөтөлбөрийг гаргаад санхүүжилтийг нь шийдэх зарчмаар явахыг боддог. Залуучуудын идэвх үнэндээ сул байдаг.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, сумын засаг даргын орлогч дарга, аймгийн ИТХ -ын төлөөлөгч

2015 оны 4 сард бүх иргэддээ сугалаа тарааж нэг хурал хийсэн. Тэгэхэд хөгшин залуугүй бүгд оролцсон. Үр дүнтэй байсан гэж бодож байна.

Хөвсгөл аймаг, Арбулаг сум, ИТХ -ын төлөөлөгч

3.1.6. ИТХ -ын 2019 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талуудаас ИТХ -ын 2019 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодрууллаа. ИТХ -ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг салбар, салбараараа нь гаргадаг байна. Тухайлбал, МАА -г тоо толгойн өсөлтөд биш, чанар дээр нь анхаарах, боловсролыг дэмжих жил, сумын засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлтийг хангах, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, өрхийн хөгжлийг дэмжих, хүүхэд хамгааллын чиглэл, байгаль орчны чиглэл, иргэдийн амьдрах орчныг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, орчны аюулгүй байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх жил, гэмт хэрэг, хүчирхийллийг бууруулах зэрэг жишээг дурдаж байна. Төлөвлөгөөг боловсруулахдаа иргэдийн саналыг дийлэнх нь тусгасан боловч зарим тохиолдолд тэргүүлэгч, төлөөлөгчид шууд шийдвэрээ гаргах тохиолдол мөн байна. Мөн зарим төлөөлөгч, тэргүүлэгч нарын хувьд ямар үндсэн чиглэл барьж ажилласнаа мэдэхгүй байх тохиолдол ажиглагдав.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

ХУД-ийн ИТХ-аас Эко гэсэн мөрийн хөтөлбөр дэвшүүлээд манай дүүргийн засаг дарга 2016 оноос хойш ажиллаад явж байгаа. Эко дэд хөтөлбөрүүд гэж байдаг. Дэд хөтөлбөрүүд дунд нь аз жаргалтай гэр бүл. ИТХ-аас архигүй орчин гэсэн аян явах гэж байна. 2019 онд ХУД-ийн ИТХ-аас 1-р хороонд цэцэрлэгт хүрээлэн байгуулагдсан. Иргэд өөрсдөө салхилаад үр хүүхдүүдээ тоглуулаад явдаг талбайтай болчихсон учраас Яармаг Нисэхийн хороолол руу цэцэрлэгт хүрээлэн, хүүхдүүдээ тоглуулаад явдаг цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчинтой больё гээд цэцэрлэгт хүрээлэн барьж байгаа. Тэр нь 2020 онд дамжиж хэрэгжээд дуусна. Эко гэдэг утгаараа хогоо хуванцар, шил, лааз, цаас, гялгаруут гээд ангилж хаяад хэвшчих юм бол хог боловсруулах үйлдвэр байгуулахад илүү дөхөмтэй. Хогоо дахин боловсруулаад байна гэдэг чинь дахин хог үүсэхгүй, хог бага болно. Тиймээс дүүрэгт үүсэх хог хаягдал хийсэх нь багасаад орчныг бохирдуулах нь багасна. 2016-2020 он хүртэл ийм зорилт дэвшүүлээд дүүргийн засаг дарга ажиллаж байна.

Улаанбаатар хот, ХУД, ИТХ -ын төлөөлөгч

Энэ жилийн зорилго нь гэмт хэргийг бууруулах. Гэмт хэрэг энэ цаг мөчид их гарч байна. Ялангуяа хүүхдийн хүчирхийлэл. Өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхэд хөгшид, залуу гэхгүйгээр хүчирхийлэлд өртөж байгаа учраас хүчирхийллийн эсрэг хамтдаа ажиллаж байгаа. Хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхийн тулд архидан согтуурч байгаа айлуудаараа орж байна, байнга архаг архичдаараа орж байна, архи уухаараа хүүхдүүдээ хаяад явчихдаг айлуудаараа орж байна. Бид нар хурал хийж иргэдийнхээ саналыг аваад, тэрийгээ төлөвлөгөөндөө тусгадаг. Тийм учраас иргэдийн санал гомдол дээр үндэслэж ажлаа хийнэ. Мөн дүүргээс ирсэн төлөвлөгөө дээр үндэслэж, аль алиныг нь уялдуулан ажлаа хийдэг.

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын дарга

ИТХ-ын энэ жилийн /2019 он/ үйл ажиллагааны үндсэн чиглэл нь МАА-г тоо толгойн өсөлтөд дээр биш чанар дээр нь анхааръя гэсэн зорилттой байгаа. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргаад иргэдээр хэлэлцүүлж батлуулдаг. Энэ жил ийм ийм ажлууд хийгдэнэ гээд танилцуулдаг. Тэрийг батлуулдаг. Жилийн эцэст тайлангаа ИНХ-аар танилцуулж үр дүнгээ батлуулдаг.

Хэнтий аймаг, Батноров сум, ИТХ -ын дарга

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

2019 онд СХД-ээс иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа болгож зарласан. Энэ бол ЗГ, нийслэлээс зарласан жил байгаа юм. ЗГ-аас дэвшүүлсэн зорилтыг шат шатны байгууллагууд дэвшүүлэн ажиллах ёстой. Уг дэвшүүлсэн зорилтын дагуу иргэдийн оролцоог дэмжих жил болгон зарласан.

Дүүргийн ИТХ-аас иргэдийн оролцоог дэмжих жилийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаад батлаад явуулсан. Тэрэн дээр ямар төлөвлөгөө гарсан гэхээр хороод дээр иргэдийн бүлгүүдийг байгуулъя гэж орсон. Иргэдийн бүлгээр дамжуулан иргэдийг идэвхжүүлбэ, бүлгийн зохион байгуулалтад байгаа иргэдийн санал хүсэлт, зорилго зорилтуудыг дэмжээд дүүргийнхээ үйл ажиллагаатай нь уялдуулаад дэмжиж ажиллахыг хичээж байгаа. Манай хороон дээр 40-өөд иргэдийн бүлэгтэй. Иргэдийн бүлэг хороон дээр хийгдэж байгаа бүтээн байгуулалттай холбогдож байгуулагдсан. 2011, 2012 оноос эхлэн байгуулагдсан. Тэр хүмүүсийн санаа оноог авч энэ бүтээн байгуулалтаа төлөвлөж байгаа. Иргэдийнхээ саналыг авч байж энэ ажлыг хийхгүй бол болохгүй. Зөвхөн айлын хаус бариад болчих ажил биш нийгмийн үйлчилгээний байгууллагуудыг барина. Эмнэлэг, цэцэрлэг, соёлын үйлчилгээ явуулдаг кино театр барина. Заавал хотын төв орж музей үзнэ гэхгүйгээр хүмүүсийн санаачилгаар музей ч байгуулж болно. Манай Баянхошуу төв дээр Бизнес инкубатор төв байгуулагдлаа. Одоо ашиглалтад орох гэж байна. 240 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг байгуулагдаад ашиглалтад орсон. Цаашаагаа олон ажлуудыг хийнэ. Манай дүүрэг дээр иргэдэд үйлчлэх 3-р амбулатори гэж байсан. Энд зөвхөн нийслэлийн ахмадууд хэвтдэг бусад нь зөвхөн үзүүлдэг байсан. Азийн Хөгжлийн Банкны тусламжтайгаар энэ эмнэлгийг иргэдийг хэвтэн эмчлүүлдэг болгож өөрчлөх гээд өргөтгөлийн барилга баригдахаар бэлэн болоод удахгүй ажил нь эхлэх гэж байна. Хуучин барилгыг нь мөн засаж шинэчлэх ажил хийгдэх гэж байна. Нэлээн ажил манай дээр хийгдэнэ. Эдгээр нь дандаа иргэдийн хүсэл санаачилгын дагуу хийгдэж байгаа юм. Энэ эмнэлгийг ингэмээр байна, энд ийм зүйл хиймээр байна үүнийг цааш нь уламжлаад явах боломж байна уу гэдэг. Тэрийг нь бид нар хөөцөлдөж явж байгаад улсын төсвөөр шийдэж чадахгүй байсан ажлаа Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр шийдэж байх жишээтэй. Энд тэнд ийм төслийн боломжууд гардаг юм билээ. Гэхдээ иргэдээс ийм санал санаачилгууд гарахгүй бол бид нар тэр болгоныг олж харахгүй. Би тэр нь ийм байх ёстой тэр нь тийм байх ёстой гэж хардаг үзмэрч биш. Тийм учраас энэ бүхний суурь нь иргэдээс гарч байгаа санааг улам сайн төгөлдөржүүлэн ажил болгох ёстой. Хол явж байхаар энэ эмнэлэгтээ хэвтээд эмчлүүлдэг эмнэлэг болгох юмсан гэсэн иргэдээс гарч байгаа санааг л биежүүлэн хэрэгжүүлж байгаа нь бид нар юм.

Улаанбаатар хот, СХД, хорооны засаг дарга, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч

3.1.7. ИТХ -ын талаарх иргэдийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхийн тулд хийгддэг ажил

Иргэдийн ИТХ -ын талаарх ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхийн тулд айл өрхүүдээр орж биечлэн уулзах, ИНХ -аас гарч буй шийдвэр нь иргэддээ чиглэсэн, оновчтой, иргэдийн сэтгэлд нийцсэн байх, сургалт зохион байгуулах, мэдээлэл сурталчилгаа хийх, иргэддээ хүрч ажиллая аян зохион байгуулах, судалгаа хийх, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах зэрэг ажлуудыг дурдаж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Үйл ажиллагааны дэд хөтөлбөрүүд, үндсэн чиглэлд тусгасан дэд хөтөлбөрүүд нь иргэдийн оролцоог хангахад оролцооны үйл ажиллагааны хөтөлбөрүүд гэж харж байна. Бусдаар тухайлсан оролцооны ингэж оролцоог дээшлүүлнэ ийм учраас иргэдийн оролцоог тайлбарлана таниулна гэсэн зүйл байхгүй.

Улаанбаатар хот, СХД, ИТХ -ын дарга

Иргэд төлөөлөгчтэйгөө уулзана, төлөөлөгчтэйгөө уулзаад хэлсэн үг биелдэг байвал иргэдийн хурлын нэр хүнд улам л өснө шүү дээ. Энэ биелдэг байхын тулд ихэнх иргэд маань дандаа санхүүтэй холбоотой, эдийн засаг, санхүүгийн эх үүсвэр шаардлагатай тийм зүйлүүдийг хүсэж байгаа. Одоо нийслэлийн хэмжээнд төлөөлөгчид нэлээн төсвийн эрх мэдэлтэй болчихлоо. Сүүлийн хэдэн жилүүдэд бараг тойрог тойрогтоо жилд одоо хэд байдгийн мөнгө зарцуулаад байна. Миний харж байгаагаар 200 сая гээд, УИХ-ын гишүүд чинь бараг тойрог болгон дээрээ тодорхой хэмжээний мөнгө зарцуулаад байна. Миний санаж байгаагаар 8 тэрбум ч билүү дээ. Дүүрэг дээр бол тийм боломж маш бага. Тийм учраас төлөөлөгчид маань дандаа жижижсэн асуудлууд, тэгээд дээр нь нэмээд иргэдийн нэг жижиж асуудлуудыг л шийдэх төсөв байдаг. Өмнө нь болохоор СХД-ийн хөрөнгө оруулалт, мөнгө нь бага тавигддаг, төсвийн орлого муутай учраас тэрийг тэр болгон биелүүлэх боломж их багатай. Ийм л байгаад байвал иргэд төлөөлөгчдөд асуудлаа тавихаа больчихно, шийдэхгүй байгаад байвал, гэхдээ сүүлийн үед харьцангуй төлөөлөгч нарын өөрсдийнх нь хүсэл эрмэлзэл, иргэдийн амьдралыг ойлгох нь СХД дээр харьцангуй сайн байгаа гэж бодож байгаа. Тийм учраас өрх болгонтой уулзаж, жижиж ч гэсэн төсвийнхөө хүрээнд шийдчих асуудлуудыг нүдийг нь олж шийдэж байгаа төлөөлөгч нар олон байгаа. Энэ нь бол хурлын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө. Хоёрдугаарт дүүргийн иргэдийн хурал бүх дүүргүүд дээр 2001 онд чинь дүүргийн иргэдийн хурал 3, 4 хүнтэй л байдаг байсан. Одоо 17 жилийн дараа дүүргийн иргэдийн хурал 30, 40 ажилтантай болж байна. Ажлын алба ийм томтой болсноос хамаараад үйл ажиллагаа нь бас идэвхжиж байгаа гэж би харж байна. Төсөв нь ч гэсэн нэмэгдэж байна шүү.

Улаанбаатар хот, СХД, засаг дарга

Төлөвлөсөн ажил бол байгаа. Бид бүхнийг хурлын байгууллага гэдгийг ойлгодоггүй. Иргэдээ төлөөлж байгаа гэдгийг бас ойлгохгүй байх шиг байна. Яг ялгаварласан шийдвэр бол гардаггүй. Тэрийг хүмүүс бас ойлгохгүй байна. Тэр тал дээр мэдээлэл сурталчилгааг бол хийх төлөвлөсөн юм байна.

Хөвсгөл аймаг, Арбулаг сум, ИТХ -ын төлөөлөгч

3.2. ИТХ-ын талаарх бодлогын шинэчлэлтэй холбоотой санал хүсэлт

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талуудаас ИТХ -ын талаарх бодлогын шинэчлэлтэй холбоотой санаа бодлыг гүнзгийрүүлсэн ярилцлагаар тодруулав.

3.2.1. ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, түүний шалгуур үзүүлэлт

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талууд ИТХ-ын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх ёстой гэж үзэж байна. Гол оролцогч талууд дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

- ИТХ -ын төлөөлөгчдийн өөрсдийн хамаарах хороодынхоо ажлыг хийсэн байдал
- Баг дээр орж ажилласан өрхийн тоо
- Иргэдийн тавьсан санал, хүсэлтийг биелүүлсэн хувь
- Дэвшүүлсэн саналын тоо, түүний бодитой байдал
- Ажил хэрэг болгосон саналын тоо
- Хурлын ирц
- Идэвх, оролцооны байдал
- Шударга, нөлөөнд автахгүй байдал
- Гаргасан санал санаачилгаа иргэддээ тайлагнах байдал
- Хуулийн дагуу ажиллах байдал
- Өөрийгөө илэрхийлэх байдал
- Хурлын шийдвэрт нөлөөлсөн байдал
- Хэдий хэмжээний төсвөөр иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн
- Иргэд, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд хэр зэрэг хүчин чармайлт гаргасан зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж болно гэж үзсэн байна.

Мөн зарим сум, дүүрэгт ИТХ -ын төлөөлөгчдийг үнэлдэг бөгөөд тухайн жилдээ хамгийн сайн ажилласан төлөөлөгч нарыг шалгаруулж, урамшуулдаг байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Манай дүүргийн иргэдийн хуралд дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн ажлыг дүгнэх ийм үзүүлэлтүүд байгаа. Тэр үзүүлэлтийн дагуу дүүргийн төлөөлөгчийн ажлыг дүгнэж, үнэлдэг. Үнэлээд дүгнээд шууд арга хэмжээ авах боломж байхгүй. Яагаад гэвэл иргэдийн хурлын төлөөлөгчдийг халж солино гэх биш, гэхдээ тодорхой хэмжээний тайлантай, тодорхой хэмжээний төсвийг үр ашигтай зарцуулахын тулд, хамгийн үр нөлөөтэй байлгахын тулд төлөөлөгчдийн ажлыг үнэлж дүгнэх л ёстой. Тэгээд шалгуур үзүүлэлтэд нь хамгийн түрүүнд иргэдтэйгээ хэдэн удаа уулзсан, хэдий хэмжээний төсвөөр төрийн болон бусад эх үүсвэрээр хороондоо, тойрогтоо тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн, хэдэн хүний өргөдөл гомдлыг хүлээж авсан гэх мэт үзүүлэлтүүд ерөөсөө иргэдийн төлөөлөгч гэдэг бол тийм, Тэгээд Тэр сонссон зүйлээ хэн ямар ямар ажлыг бүтээхийн тулд, иргэдийн саналыг хэрэгжүүлэхийн тулд аль төвишинд яаж хамтарч ажилласан, өөрт хөрөнгө байхгүй байлаа гэхэд тэрийг нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчтэйгөө ярьсан юм уу, нийслэлийн засаг даргатай, дүүргийн засаг даргатай яаж ярьсан, УИХ-ын төвишийн шийдвэрлэх зүйлийг яаж хөөцөлдөж, яаж бүтээсэн, бусад ТББ-тай үүнийг биелүүлэхийн төлөө яаж ажилласан гээд энэ зүйлүүдийг гарцаагүй үнэлж дүгнэж, энэ чинь өөрөө өөртөө үнэлэлт дүгнэлт өгөх процессыг явуулах ёстой. Түүнд нь хурлын ажлын албатууд нь тусална. Тамгын газраас тэрийг дүгнэхгүй. хурлын ажлын алба нь төлөөлөгчдийгөө үзүүлэлтийн дагуу ямар байна гэдгийг үнэлж дүгнэнэ. Тэдэнд өөрсдөө үнэлэлт дүгнэлт өгнө шүү дээ. өөрөө өөрсдөдөө үнэлэлт дүгнэлт өгөхгүй бол хаана байгаагаа мэдэхгүй. Тэгэхээр энэ процесс бол заавал байх ёстой.

Улаанбаатар хот, СХД, засаг дарга

Дүгнүүлж байх ёстой. Асуудал оруулдаг юм уу. Ямар үүрэг манлайлалтай байсан юм. Ард иргэдээс гарсан саналаа хэр дамжуулж, хэдийг нь шийдвэрлүүлж чадсан зэргээр нь дүгнэвэл зүгээр. Одоо бол яг тийм юм байхгүй. Төлөөлөгч нар ажлын хэсэг хороо болж ажилладаг. Тэр хороондоо хэр хяналт шинжилгээ хийсэн, хөндлөнгийн хяналт хийсэн байна уу гэдгээр нь дүгнэж болох байх.

Дундговь аймаг, Өлзийт сум, багийн засаг дарга

Төлөөлөгчийн үйл ажиллагааг үр дүнгээр үнэлбэл зүгээр гэж бодоод байна. Тойрогт нэр дэвшинэ ах дүү олонтой хүн ч юм уу гараад ирдэг. Тэр хүмүүс жилдээ ганц удаа хуралд оролчихоод яваад байдаг. Тийм асуудлууд байна. Жаахан чанаржуулж тэр хүнийхээ тайланг сонсдог, яг юу хийснийг нь шийдвэрлэсэн асуудлыг нь сонсож байсан нь зөв байх. Хэдэн удаа хурал хийв. Иргэдтэйгээ хэдэн удаа уулзав. Хурлаас гарч байгаа шийдвэрүүдийг хэдэн удаа иргэддээ танилцуулсан гэдэг ч юм уу.

Хөвсгөл аймаг, Арбулаг сум, ИТХ-ын төлөөлөгч

3.2.2. Сумын ИТХ -ын тогтоох боломжтой гэж үзэж буй татварын төрөл

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талуудын үзэж буйгаар сумын ИТХ дараах төрлийн татваруудын хувь хэмжээг тогтоох боломжтой гэж харж байна. Үүнд:

- Малын хөлийн татвар
- Хог хаягдлын хураамж
- Нохойны албан татвар
- Хороо, бууцны татвар
- Газрын татвар
- Уул уурхай, ашигт малтмалын татвар
- Бэлчээр ашиглалтын татвар
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр
- Ойгоос мод бэлтгэсний татвар
- Тээвэр ашиглалтын татвар зэрэг байж болно гэж үзсэн байна.

Сумын ИТХ өөрөө татварын хувь хэмжээг тогтоодог болсноор тухайн суманд үлдэх орлого нэмэгдэх, хяналтын систем сайжрах боломжтой бөгөөд татварын хувь хэмжээг тогтоохдоо иргэдээс санал авч хэдэн хувь байхыг тогтоох нь зүйтэй гэж үзсэн байна. Нөгөө талаас зарим оролцогчдын хувьд аймаг нэгдсэн журмаар татварын хувь хэмжээг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь суманд тухайн эрхийг олговол харилцан адилгүй өөр өөр хувь тогтоох магадлалтай гэж үзжээ.

3.2.3. Сум, дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдийн сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэхгүй тохиолдолд эрхийг шилжүүлэх боломжтой субъект

Гол оролцогч талууд нам нэр дэвшүүлэхгүй бол **бие даагч** нэр дэвших ёстой гэж үзэж байна. Мөн төрийн бус байгууллага, салбар чиглэлд шилжүүлэх боломжтой гэсэн санал гарч байна. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн төлөөлөл, ахмадын төлөөлөл гэх мэт. Сум, дүүргийн ИТХ -ын төлөөлөгчдийн сонгуульд улс төрийн нам нэр дэвшүүлэх эрхийг шилжүүлэх нь зөв буруу тал дээр оролцогчид өөр өөр байр суурьтай байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Бие даагч нарын асуудал яригдана. Бие даагч нар сонгуулийн хороонд бүртгүүлдэг иргэдийн дэмжсэн гарын үсэгтэй босго байдаг. Намын статус байхгүй болчихоор бие даагч нар өөрсдөө явж судалгаа хийж таарна. За би чамд мандат өгье гээд ийм болчих гээд байна. Сонгуулийн хороо тэр олон хүнийг хийж чадах болов уу хэцүү л байх даа. Бие даагч нарыг эхний ээлжид хуульд заасан шүүлтүүрээр филтердэх байх. Яалт ч үгүй төрийн захиргаа, дүүрэг дээр байгаа эрх бүхий албан тушаалтан, хэлтэс байж л бүртгэлтэй хаягтай байна. Түүнээс бүгдийг нь сонгуулийн хороо бүртгэнэ гэвэл бүтэл муутай болох болов уу. Одоо ч бие даагч нар байгаа. Дор хаяж 800 хүний гарын үсэгтэй байж сонгуулийн хороонд бүртгүүлдэг шиг санагдаж байна. Буруу ч байж магадгүй. Тухайн оршин сууж байгаа газрын иргэдээс ИНХ, ИТХ-д энэ хүнийг нэр дэвшихийг зөвшөөрч дэмжиж байна гэсэн хуурамч биш гарын үсгүүд байх ёстой. Мөн бусад шалгуур байдаг. Хуулийн хариуцлага хүлээж ял эдэлж байгаагүй, өр төлбөр байхгүй ёс зүйн талаар байхгүй байх тийм л бие даагч нар сонгуулийн хороонд очно. Хүн өөрийнхөө хэрийг мэддэг байлгүй гэж би бодож байна. Түүнээс огт танихгүй Дорж, Дулмаа үзээд явахгүй. Одоогийн энэ сонгууль ийм болчих гээд байгаа хандлага ажиглагдаад л байгаа.

Улаанбаатар хот, ХУД, хорооны засаг дарга

Би улс төрийн өнцгөөс харахад ард иргэд намаа биш хүнээ харж сонгодог болох юм байна гэж харж байгаа. Тэгэхээр хүн намгүйгээр бие даан нэр дэвилээ гэхэд хурлаар тухайн хүний санал ганцаараа болохоор дэмжигдэж чаддаггүй унаад байдаг. Нам болохоор дэмжигдээд байдаг. Тийм болохоор бие дааж гарсан бол баг дээр ямар ч асуудлыг шийдүүлэхэд хэцүү шахагдаад байдаг. Одоогийн хууль журмын хүрээнд бие дааж суманд нэр дэвших бол хэцүү. Бие даагаад гараад ирж болно гэхдээ ажиллахад хэцүү.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, сумын засаг даргын орлогч дарга, аймгийн ИТХ-ын

3.2.4. Хот тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын эзэмших боломжтой эрх

Хот тосгоны өөрийн удирдлагад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим эрхийг шилжүүлэх боломжтой бол ямар эрхийг шилжүүлэх нь зөв талаар гол оролцогч талуудаас тодрууллаа.

Оролцогчдын үзэж буйгаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зарим эрхийг шилжүүлэх нь зөв гэж үзэж байна. Тухайлбал, төлөвлөсөн татвараа сумандаа өөрсдөө зарцуулах, төсөвтэй холбоотой асуудлаа өөрсдөө бие даан шийдэх, баг өөрийн төсөвтэй болох, төсвийн хуваарилалтаа хурлаараа хийдэг байх, бодлого боловсруулж хэрэгжилтийг өөрсдөө хянах, газар зохион байгуулахтай холбоотой зарим асуудлын эрх мэдлийг олгох, орон нутгийн татвартай холбоотой асуудлыг шилжүүлэх боломжтой гэж үзжээ.

3.2.5. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангахын тулд нэмэх шаардлагатай эрх

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талуудын үзэж буйгаар НӨУБ-ын бие даасан байдлыг хангахын тулд дараах эрх, хэмжээг нэмэх шаардлагатай гэж үзжээ. Үүнд:

- Санхүүгийн эрх
- Уул уурхай, газар нутагтай холбоотой асуудлыг шийдвэрлэх эрх

- Эдийн засгийн эрх чөлөөг нэмэгдүүлэх /Зарим давсан орлогоо өөрсдөө сум орон нутагтаа зарцуулах/
- Боловсон хүчний томилгоо хэвтээ зарчмаар явагдах /Сумандаа ажиллах боловсон хүчнээ сумын засаг дарга нь мэддэг байх/
- Сумаас олж байгаа ашиг орлогыг буцаагаад суманд нь төвлөрүүлдэг байх
- Сум худалдан авах ажлаа өөрсдөө зарлах
- Шашин, сүмийн үйл ажиллагаа явуулах эрхийг сум, дүүрэг олгодог байх зэрэг саналуудыг дурдаж байна.

3.2.6. Сумын өөрийн удирдлагад төсвийн талаар бие даах асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх боломж

Гол оролцогч талуудын үзэж буйгаар сумын өөрийн удирдлагад төсвийн талаар бие даах асуудлыг ямар үе шаттайгаар хэрэгжүүлж болох талаар тодруулахад хамгийн нэгдүгээрт иргэдээсээ санал авах, дараа нь саналыг эрэмбэлээд төсвийн хуваарилалтыг хийх, иргэдийн хурал татвар ногдуулах, татвар чөлөөлөх эрхтэй болох зэрэг саналыг дурдав. Зарим оролцогчдын хувьд тус асуудлыг талаар сайн мэдэхгүй байна гэсэн байр суурьтай байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Иргэдээсээ хийх ажлынхаа саналыг аваад чухлаар нь эрэмбэлээд тэрэндээ төсвийг нь хуваарилаад хийдэг бол зүгээр. Тийм зүйл байхгүй болохоор манайх дүүргээсээ заавал нийслэл рүү явуулна. Нийслэл рүү төсвийн төслөө явуулахаар энэ жил энэ чинь болохгүй гээд хасаад хасаад явуулчихдаг. 10 ажил явууллаа гэхэд хасагдаад 4 -5 ажлын төсөв ирдэг.

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч

Өөрсдөө бие даасан төсөвтэй болохын тулд анхан шатны авсан арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгдсөн үйл ажиллагаа гэж хардаг. Үүнийг шат дараатай арга хэмжээ аваад сайжруулбал хороон дээр төвлөрүүлж өгвөл иргэдийн оролцоо сайжрах болов уу гэж харж байна.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

Сум, дүүрэг хоёр газар, ашигт малтмалын хувьд өөр байгаад байдаг. Дүүрэг дээр газрын татвар хураамжийг дүүргийн хэмжээнд бүрэн шилжүүлэх ёстой. Газрынхаа татварыг өөрөө аваад тэрэн дээрээ байрлаж байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж гэж заачхаад өөрөө газар нутагтай, засаг захиргаатай ийм нэгж чинь дүүрэг байхгүй юу. Тэгээд тэр нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниудаас газрын төлбөр мөнгөнүүд өгөх зэрэг асуудлыг дүүрэг шийдчихмээр юм байгаа шүү дээ. Өөртөө байж байх ёстой. Хамгийн түрүүнд ийм зүйлүүдээс л эхэлмээр байгаа юм. Иргэдэд үзүүлж байгаа зардал, боловсролын салбарын чиглэлийн зардлууд байна. Үүнийг эхний ээлжид шийдчихмээр байгаа. Орон нутагт өөрийн төрийн албан хаагчдын тоо, түүнд тохирох цалин урсгал зардлыг дүүрэгт өгчихмөөр байгаа юм. Яагаад гэхээр дүүрэг дээр аль ч салбар дээр хэдэн хүн ажиллуулахаа дээрээс шийдэж байгаа. Тэгэхээр энд тэр салбарынхан илүү их дараалалтай, хүмүүс хүлээгээд байхад бүгдэд нь заасан тоогоор л ажиллуулна. Өөр тийшээ хөдөлгөх боломж байхгүй гэхээр учир дутагдалтай байгаа.

Улаанбаатар хот, СХД, засаг дарга

Эхлээд сум иргэдийн хурал нь татвар оногдуулах, татвар чөлөөлүүлэх эрхүүд орж ирнэ эндээс аль нь оновчтойг нь тодруулах ёстой байх.

Хөвсгөл аймаг, Мөрөн сум, ИТХ-ын төлөөлөгч

3.2.7. Багийг 10 өрхийн, хороог хэсгийн зохион байгуулалтад оруулахын эерэг ба сөрөг үр дагавар

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талууд багийг 10 өрхийн, хороог хэсгийн зохион байгуулалтад оруулах нь зөв бөгөөд эерэг үр дагавар нь давамгайлна гэж үзэж байна. Тухайлбал, төрийн үйлчилгээ иргэдэд сайн хүрнэ, өрх бүртэй тулж ажиллахад дөхөм болно, гэр хорооллыг аравтын системээр зохион байгуулан мэдээлэл хүргэх, хоорондоо туслах, бие биеэ байхгүйд гэрийг нь харах /сайн хөрш төсөл/ буюу хөршийн холбоо сайжирна гэх мэт эерэг үр дагавар гарна гэж үзжээ. Хамгийн гол нь мэдээлэл хүргэхэд дөхөм болно. Сөрөг үр дагаврын хувьд хороог хэсгийн зохион байгуулалтад оруулахад байшин хороолол төвөгтэй, сонгуульд буруугаар ашиглах аюултай, бэлчээрийн маргаан үүсэх магадлалтай хэмээн дурджээ. Хэсэгт хамаарах өрхийн тоо хөдөө орон нутагт 10-20, хот суурин газарт орон сууц, байраар нь, гэр хороолол бол гудмаар нь тогтоох нь зүйтэй гэсэн санал дэвшүүлжээ. Өрхийн тоо цөөн байх тусам хэсгийн ахлагч ачаалал багатай, хүмүүс нягтрахад дөхөм байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Нэг хороонд 200-300 өрх оногддог. Хэсгийн ахлагчийн цалинг бодоод үзье. Он гараад 480000 төгрөг болно. 1-р хороон дээр 9 хэсгийн ахлагчтай. Үүний 8 нь өрх хариуцдаг, нэг нь аж ахуйн нэгжийг хариуцдаг. Манайх 10000 гаруй иргэнтэй, 8 хэсгийн ахлагч нь өрхүүдээр явдаг. Тэгэхээр нэг хэсгийн ахлагчид 200-250 өрх ноогддог. Сард 200-250 айл болгонд хүрэх ёстой. Ингэхдээ сард 3 удаа мэдээлэл гарлаа гэвэл сардаа давхардсан тоогоор 600-750 өрхөд хүрч мэдээлэл хүргэж байна гэсэн үг. 21 хоногт тоо өдөрт 20 айл гэхээр 50%-иар багасгавал хүртээмж нь илүү сайн болно. Яг тулгамдаж байгаа асуудал хэсгийн ахлагчийн цалин бага учраас залуу хүн хийдэггүй. Настай хүн болохоор айллуудаар явж чаддаггүй, Лифтгүй орон сууцанд хэцүү. Нөгөө хүн маань гудамжаар алхаад явж байдаг. Монголын өвлийн нөхцөл ямар билээ гэмтдэг бэртдэг асуудал их гардаг. Хороог хэсгийн зохион байгуулалтад оруулснаар эерэг үр дагавар гарах нь илүү, сөрөг үр дагавар байхгүй. Хэсгийн зохион байгуулалтад орвол иргэдэд хүрэх нь илүү болно, мэдээ мэдээлэл хүрэх нь илүү болно, тухайн хэсгийн иргэдийн оролцоог тухайн хэсгийн ахлагч хариуцаж байгаа учраас өөрийнхөө ажлын статусын өндөр байлгахын тулд иргэдийнхээ оролцоог өндөр байлгах дээр анхаарч ажилладаг. Тиймээс эерэг талдаа учраас мэдээ мэдээлэл дамжих хурд, чанар нь нэмэгдэнэ.

Улаанбаатар хот, ХУД, ИТХ-ын төлөөлөгч

3.2.8. Аймгийн төвийн сумыг хот болгон өөрчилснөөр уг хотын захирагчийн үүргийг аймгийн засаг дарга гүйцэтгэхийг дэмжиж буй байдал

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талуудын хувьд аймгийн төвийн сумыг хот болгон өөрчилснөөр уг хотын захирагчийн үүргийг аймгийн засаг дарга гүйцэтгэхийг дэмжихгүй байх хандлага ажиглагдлаа. Аймгийн дарга тусдаа байх ёстой, хэрэв давхар үүрэг гүйцэтгэвэл аймгийн засаг даргын ачаалал өснө, хууль эрхзүйн хувьд орчин бүрдээгүй зэрэг бэрхшээлүүдийг дурдаж байв.

3.2.9. Шат шатны хурлын тэргүүлэгчид үндсэн хуулийн бус эрх хэмжээтэй болох тохиолдолд хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтад орох өөрчлөлтийн талаарх төсөөлөл

Гол оролцогч талууд шат шатны хурлын тэргүүлэгчид үндсэн хуулийн бус эрх хэмжээтэй болох асуудлыг дэмжихгүй байна. Үндсэн хуулийн бус эрх хэмжээтэй болох цаг нь ирээгүй гэж харж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Тодорхой хэмжээнд хурлын тэргүүлэгчдийн эрх, үүргийг тусгайлан заасан эрх зүйн үндэстэй байж л энэ асуудлыг гүйцэтгэх байх. Түүнээс биш үндсэн хуулийн биш өөрчлөлтүүд гээд хурлын төлөөлөгчид ороод ирэхээр мэдэх мэдэхгүй, болох болохгүй сөрөг үр дагаврууд гарч ирэх боломж байж магадгүй.

Хэнтий аймаг, Баян-Адарга сум, багийн засаг дарга

Зохион байгуулалтын ажилд нэлээн давамгайлж магадгүй юм. Сөрөг юм гарч ирж байна. Эрх мэдлээ хэтрүүлнэ. Жоохон шударгаар хэлэхээр ад болчихно. Авлигад өртөх магадлал өндөр болно. Хөрөнгөжих гээд үзнэ.

Дундговь аймаг, Эрдэнэдалай сум, засаг даргын орлогч

Үндсэн хуулийн бус эрх хэмжээ гэхээр нээх санаанд буухгүй байна. Үндсэн хууль чинь гол эцэг хууль.

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, засаг дарга

Үндсэн хуулийн бус эрх гэхээр өөр хуулиар шийдэж өгөх юм уу. Хэрвээ тэгвэл том том зүйл хийнэ. ИТХ-ийн тэргүүлэгчдийн заасан хэдхэн заалтаар шагнал өгдөг юм уу эсвэл төлөөлөгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаа өмнө хэлэлцэж оруулъя оруулахгүй гэдэг ёс төдий байдлаар явдаг. Гарын арван хуруунд багтахгаар л асуудлыг шийддэг.

Улаанбаатар хот, Багануур дүүрэг, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч

Тийм том эрх мэдэлтэй болох нь одоохондоо дэмий байх. Тухайн шатны иргэдийн хурлын байдлыг хангаж байгаа байгууллага бусдаар учиргүй шийдвэр гаргаад үндсэн хуульд олгогдоод шийдвэр аваад байх тийм эрх шаардлага байхгүй. Хамгийн гол нь үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсон нэгжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орох нь зүйтэй өөр бусдаар тийм бүтэц дэмий байх. Гарч байгаа байгууллага нь өөрөө том эрх мэдэл авбал хэцүү.

Улаанбаатар хот, СХД, ИТХ-ын дарга

3.2.10. Орон нутгийн төсөвт татварын орлогыг нэмэгдүүлэхэд дутагдаж буй эрх зүйн зохицуулалт

Гол оролцогч талуудын санал болгож буй орон нутгийн төсөвт татварын орлогыг нэмэгдүүлэхэд дутагдаж буй эрх зүйн зохицуулалтыг дурдвал:

- Орон нутгийн онцлогоос шалтгаалсан орлогуудыг орон нутагт нь төвлөрүүлэх
- Нийтийн тээвэр, байгаль орчны асуудлууд дээр орон нутагт эрх зүйн хэмжээг өгөх
- Татварын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах
- Татварын байгууллагын ажилтны орон тоог нэмэгдүүлэх
- Татвараас гадуур үлдэж буй нийтийн ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй анхан шатны байгууллага, жижиг үйлдвэрлэл эрхлэгч, жижиг үйлчилгээний байгууллагыг тодруулж татвар тооцдог болох
- Жижиг, жижиг татваруудын хувь хэмжээг өөрчлөх
- Дүүрэг, орон нутгийн онцлогийг харгалзан татварын тогтолцоог өөр өөрөөр тогтоох
- Орон нутагт тендерээр ажиллаж буй гаднын компанийн татварыг тухайн орон нутагт төвлөрүүлдэг байх
- Малын татвар тогтоох
- Татварыг оновчтой тодорхойлох
- Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, түүнээс орох татварын орлогыг нэмэгдүүлэх
- Уул уурхай, байгалийн баялгийн татварыг нэмэгдүүлэх
- Иргэдэд татварын талаар мэдээлэл өгөх зэрэг саналуудыг дэвшүүлэв.

Орон нутагт татвар бүрдүүлэх сонирхлыг дээшлүүлэхийн тулд:

- Иргэдээс ямар ямар татвар авч болох талаар иргэдийн дунд санал асуулга явуулах
- Хууль зүйн талаар ойлголт өгөх
- Иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан урамшууллын үйл ажиллагаа явуулах
- Ажлын байрыг нэмэгдүүлэх хөнгөлөлттэй зээлийг бизнес эрхлэгч нарт өгөх
- Хамгийн сайн татвар төлөгч аж ахуйн нэгжийг урамшуулах
- Татвар төлснөөр гарах үр ашгийг иргэд болон аж ахуйн нэгжид таниулах
- Татварын өргүй бол ямар нэгэн хөнгөлөлт эдэлдэг байх нь зүйтэй хэмээн дурдаж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Жижиг, жижиг татваруудын хувь хэмжээг өөрчлөх энэ бол их дутагдаж байна. Тэгээд орон нутагт татварын хууль хэтэрхий дүүрэг болон орон нутгийн ямар ч онцлогийг харгалзахгүйгээр нэгдсэн татварын том тогтолцоотой учраас үүгээр шийдчихээр зарим дүүрэгт энэ татварын тогтолцоогоор иргэдийн асуудлыг боломжийн хэмжээнд шийдэж болоод байна. Гэтэл зарим дүүрэгт, манай дүүрэгт жишээ нь асуудлыг шийдэж чадахгүй байна. 20 жил болохоор ийм алдаатай бодлогыг хийж ирсэн. Сүүлийн хэдэн жил янз бүрийн тэмцлийн арга хэрэглээд арай гайгүй болж байна. Гэхдээ л энэ чинь хэн нэгэн төлөөлөгч юм уу тэргүүлэгч юм уу, нийслэлийн хэн нэгэн төлөөлөгч, хэн нэгэн УИХ-ын гишүүний хувийн шинж чанараас хамаарч дүүргийн амьдрал шийдэгддэг байж болохгүй. Улсын бодлогоор зарим дүүрэгт их мөнгөтэй зарим дүүрэгт бага мөнгөтэй зохион байгуулагдах ёстой. Тэрийг улсын бодлого зохион байгуулах ёстой. Гэтэл хэдхэн хуулийн хүрээнд ингэж хийнэ гээд энд амьдрал ямар байгааг огт хамаарахгүйгээр яг татварын тухай хууль зөвхөн дүүрэг ийм байна гээд заачихсан заалтын дагуу бүгдийг шийдээд 20 жил болчихоор дүүрэг дүүргийн онцлогтой асуудлыг шийдэхэд төвөгтэй болно. Одоо жишээлбэл энэ татварын хуулиар СХД мөд хөгжихгүй. Мөд дэд бүтцийн асуудал шийдэгдэхгүй. Тэгэхээр СХД-ийн нөхцөлд өөр байлгадаг. Бусад дүүрэгт өөр өөр байдаг байх хэрэгтэй. Одоо нэгэнт амьдралын нөхцөл байдал их өөр болчихсон энэ тохиолдолд тодорхой зохицуулалтуудыг нийслэлийн хэмжээнд татварын зохицуулалт хийдэг эрх мэдэл байж байх ёстой. Гэхдээ хэн ч гарсан хамаагүй тодорхой бодлогоор төлөөлөгчийн идэвхтэй идэвхгүй байдлаас хамаарахгүйгээр шийдвэрлэх нь зүйтэй.

Улаанбаатар хот, СХД, засаг дарга

Би өөрөө хувийн аж ахуйтай үүднээсээ харахад орон нутгийн татварт яг орох ёстой зүйл бол жишээ нь 10 тэрбумын ажил дээр тендер зарлахад хотын компани орж ирдэг. Аливаа нэг компани орон нутаг дээр тендер авсан бол харьяалал нь хотод байсан ч гэсэн тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа учраас тухайн орон нутагт нь татвараа төлөх нь илүү гэж хардаг. Тэгэх юм бол орон нутагт орж ирэх төсөв нь нэлээн сайн нэмэгдэнэ. Энэ жил манай дээр 100 орчим тэрбум төгрөгийн ажил хийгдсэн гэсэн. Тэрнээс манай дээр нэг ч татвар орж ирээгүй.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, сумын засаг даргын орлогч дарга, аймгийн ИТХ төлөөлөгч

Орон нутагт ажлын байрыг маш их бий болгох жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх тийм байвал орон нутаг тэрийгээ өөрөө орлого олоод эхэлнэ. Хэдий жижиг дунд хөгжүүлнэ, айл өрхийн хөдөлмөрийг хөгжүүлнэ гэж яриад байдаг аль ч нам гарсан ярьж байдаг ч хөгжүүлсэн зүйл байдаггүй. Жижиглэнгийн худалдаа л нэмэгдсэн байх. Одоо 10 бүрэлдэхүүнтэй хүний гутлын үйлдвэр гэж байхгүй. 5 хүний оёдлын үйлдвэр гэж бас байхгүй ер нь үйлдвэрлэл дагаад орон нутгийн амьжиргаа сайжирна.

Завхан аймаг, Тэлмэн сум, багийн засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Энд малын хөлийн татвар, бэлчээр ашиглалтын татварыг ярих хэрэгтэй. Жишээ нь тэрэнтэй адил ямар татвар байж болохоор байна. Хэн нэгэн гомдохооргүй ийм татварын эх үүсвэр юу байна гэдгийг иргэдийн дунд ярилцаж гаргаж ирэх хэрэгтэй. Зарим малчид бид нар татвар төлөх ёстой гэдэг, татвараа өгмөөр байна гэсэн малчидтай тааралдаж байдаг. Ялангуяа их малтай болчихсон хүмүүс үнэгүй бэлчээр, ямар нэгэн ашигийн татвар төлөхгүй энэ олон мал байгаль экологид сөрөг нөлөө үзүүлээд байгаа учраас Монголын малчид татвар төлөх нь зүйтэй гэж үзэх хүмүүс байдаг. Иймэрхүү татварын өөр ямар нөөц байгааг иргэдийн дунд НӨУБ ярилцлага сайн зохион байгуулж гаргаж ирэх хэрэгтэй.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, аймгийн ИТХ-ын төлөөлөгч

Албадан чиглэлээр бол хүндрэлтэй болно. Тэгэхээр урамшууллын чиглэлээр иргэд болон жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан үйл ажиллагаа явуулах нь зүгээр. Хөнгөлөлттэй зээл, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын байрыг томсгоход зориулсан зээл гэх мэт ажилд татварын байгууллага хамгийн сайн татвар төлөгчдөө тодорхойлж өгснөөр тухайн аж ахуйн нэгж нь нэн тэргүүнд хөнгөлөлттэй зээл авах эрх нь үүсдэг гэх мэтчилэн урамшууллын хөшүүрэг байвал татвар төлөлт ихсэж, би татвараа төлснөөр хөнгөлөлттэй зээл авах, хүүгүй зээл авах боломж үүсэх нь гэж үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүс т эгж боддог болбол төрөөс үзүүлэх том хөшүүрэг болно.

Улаанбаатар хот, БЗД, хорооны засаг дарга

3.2.11. Төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн тодорхой хэсгийг санхүүгийн дэмжлэгт оруулахад шаардагдаж буй эрх зүйн зохицуулалт

Судалгаанд хамрагдсан гол оролцогч талуудаас төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн тодорхой хэсгийг санхүүгийн дэмжлэгт оруулахад ямар эрх зүйн зохицуулалт хэрэгтэй байгаа талаар тодрууллаа. Оролцогчид энэ талын хууль эрх зүйн ойлголт багатай байгаа нь харагдлаа. Иймд дорвитой санал гаргасан оролцогч цөөн байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлагын тэмдэглэлээс:

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулаасай гэж боддог. Энэ хууль 2013 онд батлагдаад 2014 онд тодотгосон. Аливаа хууль журам ард иргэдийн хээ дунд цаг хугацаанд шалгагдаж байж өөрчлөлт орсноороо илүү хүчтэй хууль болдог. Тэгэхээр энэ тал дээр төсвийн хуульд өөрчлөлт орж байна төсвийг өөрчлөх нэмэх асуудлыг хангана гэж бодож байна.

Хэнтий аймаг, Батноров сум, сумын засаг дарга

Нэг юм хийе гэхэд төсөвт баригдаад юм уу захиран зарцуулах эрх нь байдаггүй. Төсвөө захиран зарцуулах эрхтэй болбол зүгээр.

Дундговь аймаг, Өлзийт сум, засаг даргын орлогч

Суманд байгаа төсвийн зориулалтыг нь шийдэхэд иргэдийн хурлаар баталгаажуулж шийдэж байгаа юм. Энийг шийдэхэд санхүү албаны дарга, засаг дарга, хурлын дарга сайн хяналт тавьж ажиллах хэрэгтэй. Жишээ нь 12 сард шийдсэн тендерийн асуудал нэг сандал ширээ авна гэсэн асуудал нь дараа жилийн 12 сард болтол шийдэгдээгүй байх жишээтэй. Тэгээд энэ мөнгө нь угаагдаад яваад байх магадлал байж болно. Тэгэхээр энэ дээр хяналтаа сайн тавих ёстой нь дээр байх.

Завхан аймаг, Улиастай сум, ИТХ-ын тэргүүлэгч

Зардлыг нь зөвөөр дотор нь хөдөлгөж болдоггүй. Гэхдээ нэг талын сөрөг үр дагавартай байх. Гэвч тодорхой хүрээнд зүйл, заалтыг өөрчлөх эрх нь дүүргийн төсөв дээр асуудлууд нь шийдэгдэж байвал болох л юм. Зүйл, заалтуудыг нь дүүрэг өөрөө хуралдаад шийдчихдэг байх ёстой юм шиг байгаа юм. Магадгүй жижигхэн салбар хооронд зарим тохиолдолд гүйдэг ч байхыг үгүйсгэхгүй. Тийм байдаг бол доод төвшинд зохицуулалт хийж болох юм.

Улаанбаатар хот, СХД, засаг дарга

Төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн тухай



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨСВИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.23. “тусгай зориулалтын шилжүүлэг” гэж энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу аймаг, нийслэлийн төсөвт улсын төсвөөс олгох хөрөнгийг;

61 дүгээр зүйл. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх

61.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ:

- 61.1.1. сургуулийн өмнөх боловсрол;
- 61.1.2. ерөнхий боловсрол;
- 61.1.3. соёлын үйлчилгээ;
- 61.1.4. эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ;
- 61.1.5. газрын харилцаа, кадастр;
- 61.1.6. хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ;
- 61.1.7. нийтийн биеийн тамир.

61.2. Энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн [39 дүгээр зүйлд](#) заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ.

61.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр санхүүжилтийн хуваарилалт хийх саналаа орон нутгийн төсвийн төслийн хамт бэлтгэж, хуульд заасан хугацааны дотор зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

61.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээ, Засаг даргын өргөн мэдүүлсэн саналд үндэслэн төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүрээр хуваарилсан санхүүжилтийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээгээр шилжүүлсэн нийт хэмжээнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсвийн нэг хэсэг болгож батална.

61.5. Тусгай зориулалтын шилжүүлгийг энэ хуульд заасан сар, улирлын хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төрийн санд шилжүүлнэ.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа-2019” - ны үр дүнг 2015 оны судалгааны үр дүнтэй харьцуулан, чанарын судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлт, зөвлөмжүүдийг боловсруулав. Үүнд:

Иргэдийн ИТХ -ын талаарх ойлголт

- **ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ИТХ-ЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ НЭМЭГДСЭН БАЙНА.** ИТХ -ын талаарх иргэдийн ерөнхий ойлголт хөдөө орон нутагт 22.8 хувиар өсөж, Улаанбаатар хотод 24.8 хувиар буурсан байна. Үүнийг аймаг/нийслэл, сум/дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах болон мэдээлэх байдалтай холбоотой гэж үзэж байна.
- **ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ИТХ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ БАЙДАЛ САЙЖИРСАН БАЙНА.** Аймаг, сумын ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал хөдөө орон нутагт өссөн байна. Нийслэлийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал 0.9 хувиар өсөж, дүүргийн ИТХ иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнах байдал 4.5 хувиар буурсан байна.
- **ХӨДӨӨ ОРОН НУТАГТ ИТХ ГАРГАСАН ШИЙДВЭРЭЭ ИРГЭДЭД МЭДЭЭЛЭХ БАЙДАЛ САЙЖИРСАН БАЙНА.** Аймаг, сумын ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдал хөдөө орон нутагт өссөн. Нийслэлийн ИТХ гаргасан шийдвэрүүдээ иргэдэд мэдээлэх байдал 3.1 хувиар буурсан, дүүргийн ИТХ гаргасан шийдвэрээ иргэдэд мэдээлэх байдал 5.7 хувиар өссөн гэж иргэд үнэлж байна.

Иргэдийн мэдээлэл авахыг хүсэж буй суваг

- **ИРГЭД ИТХ -ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ СОШИАЛ СУВГААР АВАХ ХҮСЭЛТЭЙ БАЙНА.** ИТХ -ын талаарх мэдээллийг Улаанбаатар хотын иргэдийн 47.5 хувь нь орон даяар цацагддаг телевизийн сувгаар авч байна. Хөдөө орон нутагт орон нутгийн телевизийн сувгаар авдаг хувь илүү өндөр байна. Иймд хөдөө орон нутагт орон нутгийн телевизийн сувгаар мэдээллээ цацвал илүү үр дүнтэй байна. Мөн телевизээр гадна интернэт суваг, тэр дундаа сошиал сувгийг ашиглах нь маш үр дүнтэй байна. Учир нь цаашид ИТХ -ын талаарх мэдээллийг сошиал сувгаар авах хүсэлтэй иргэд хамгийн өндөр хувь эзэлж байна. Тодруулбал, Улаанбаатар хотын иргэдийн 41.3 хувь, хөдөө орон нутгийн иргэдийн 33.1 хувь ИТХ -ын талаарх мэдээллийг сошиал сувгаар авах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ.
- **ИРГЭД WWW.KHURAL.MN САЙТААС МЭДЭЭЛЭЛ АВАХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.** Иргэд www.khural.mn сайтаас мэдээлэл авах байдал 1 хувьтай байна. Тухайн сайтыг ИТХ -ын төлөөлөгч нар л ашиглаж байна. Иргэдийн хувьд тус сайтаас илүүтэй сум орон нутгийн нэгдсэн групп /сошиал/-ыг илүү идэвхтэй ашиглаж, мэдэхгүй зүйлээ асуух, тухайн орон нутагт болж буй асуудлыг мэдээлэх, өөрийн санал бодлоо илэрхийлэхэд ашиглаж байна.

Иргэдийн санал бодлоо илэрхийлэхийг хүсэж буй суваг

- **ИРГЭД ӨӨРСДИЙН САНАЛ БОДЛОО СОШИАЛААР БОЛОН ХУРАЛ ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮЕЭР ХҮРГЭХ ХҮСЭЛТЭЙ БАЙНА.** Мэдээлэл авах сувгаас гадна иргэдийн санаа бодлоо илэрхийлэхийг хүсэж буй сувгийг авч үзье. Орон сууц хорооллын болон залуучууд, ажил хөдөлмөр эрхэлдэг бүлгийн иргэд сошиалаар дамжуулан өөрийн санаа бодлыг илэрхийлэх сонирхол өндөр байна. Интернэт ашиглах байдал багатай гэр хорооллын иргэд болон ахимаг насны иргэд хурал зөвлөгөөний үеэр өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх сонирхолтой байна.

Иргэдийн оролцохыг хүсэж буй асуудал

- **ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИРГЭД АЖЛЫН БАЙРТАЙ БОЛОХЫГ ХАМГИЙН ИХЭЭР ХҮСЭЖ БАЙНА.** Хөдөө орон нутгийн иргэд ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд оролцох, санал бодлоо илэрхийлэх сонирхол хамгийн өндөр байна. Хөдөө орон нутагт ажилгүйдэл гол тулгамдаж буй асуудал болоод байгааг гол оролцогч талууд мөн адил дурдав. Ажлын байртай холбоотой үүсдэг бэрхшээл нь ажлын байр байсан хэдий ч иргэдийн ажиллах байдал бага байгааг дурдаж байв. Түүний шалтгааныг тодруулбал, иргэд цалингаа голдог, ажилд орсон үед туршилтын хугацаанд цалингүй ажиллах болдог. Тэр үед ар гэрт хоол хүнсний гачигдалд орох, унааны мөнгөгүй зэргээс болж тогтвортой ажиллаж чаддаггүй байна. Мөн ажлын байрны тавигдаж буй шаардлагыг хангаж чаддаггүй, боловсрол, мэдлэг чадвар, туршлага хангалтгүй байдаг учраас иргэд ажлын байраар хангагдаж чаддаггүй байна.
- **УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ХУВЬД ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ НЬ НЭН ЧУХАЛ БАЙНА.** Улаанбаатар хотын иргэдийн хувьд эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлийн шийдвэр гаргалтад оролцох сонирхол хамгийн өндөр байна.

ИТХ -ын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ

- **ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ИТХ -ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ БАЙДАЛ БУУРЧ БАЙНА.** Аймгийн ИТХ -ын үйл ажиллагааг “маш сайн”, “зарим талаараа сайн” гэж үнэлсэн байдал 3 хувиар буурсан. Сумын ИТХ -ын үйл ажиллагааг “маш сайн”, “зарим талаараа сайн” гэж үнэлсэн байдал 1.1 хувиар буурсан байна. Аймаг, сумын ИТХ -ын үйл ажиллагааг сайнаар үнэлэх байдал буурсан гол шалтгаан нь ИТХ -ын төлөөлөгчтэй уулзахад хүндрэлтэй байдаг (*ИТХ -ын төлөөлөгчтэй уулзахад хүндрэлтэй байдал, +20.3%*), илэрхийлсэн хүсэлт, асуудал, санал гомдол үр дүнтэй шийдэгдэж чаддаггүй (*Асуудлыг маш үр дүнтэй шийдэх байдал, -19.8%*) зэрэг шалтгаанууд хүчтэй нөлөөлсөн байна.
- **УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ИЛЭРХИЙЛСЭН ХҮСЭЛТ, АСУУДАЛ, САНАЛ ГОМДОЛ ҮР ДҮНТЭЙ ШИЙДЭГДСЭН БАЙДАЛ ӨСЖЭЭ.** Улаанбаатар хотын иргэдийн хувьд нийслэлийн ИТХ -ын үйл ажиллагааг “маш сайн”, “зарим талаараа сайн” гэж үнэлсэн байдал 1.8 хувиар буурсан, дүүргийн ИТХ -ын үйл ажиллагааг “маш сайн”, “зарим талаараа сайн” гэж үнэлсэн байдал 1 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын иргэдийн хувьд дүүргийн ИТХ -ын төлөөлөгчтэй уулзахад хүндрэлтэй байдал 61.5 хувьтай буюу өмнөх судалгааны үр дүнгээс 40.7 хувиар өссөн байна. Гэсэн хэдий ч илэрхийлсэн хүсэлт асуудал, санал гомдол маш үр дүнтэй шийдэгдсэн гэж 25.6 хувь үзсэн бөгөөд энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 4.8 хувиар өссөн үр дүн юм.

ИНХ -д оролцох цаашидын хандлага

- **ИРГЭДИЙН БАГ/ХОРООНЫ ИНХ -Д ОРОЛЦСОН БАЙДАЛ, ЦААШИД ОРОЛЦОХ ХАНДЛАГА БУУРЧ БАЙНА.** Баг/хорооны ИНХ -д оролцсон байдал өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад Улаанбаатар хот (20.6%) болон хөдөө орон нутагт (49.2%) 7.5 орчим хувиар буурсан байна. Баг/хорооны хурлын урилга, мэдээлэл ирсэн ч оролцох хандлага Улаанбаатар хотод (47.1%) 4.7 хувиар, хөдөө орон нутагт (63.2%) 6.8 хувиар буурчээ. Энэ нь иргэдийн ИНХ -д биечлэн очих сонирхол буурч байгааг харуулж байна. Иймд ИНХ -ын үеэр цахим байдлаар иргэдийн санал хүсэлтийг давхар авдаг болох арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.
- **ИРГЭД ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЭЦТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ ГАРАХАД БАГ/ХОРООНЫ ЗАСАГ ДАРГАДАА ХАМГИЙН ТҮРҮҮНД ХАНДДАГ.** Иргэд орон нутгийн хөгжил, дэд бүтэцтэй холбоотой асуудал гарахад хамгийн түрүүнд

баг/хорооны засаг даргадаа, дараа нь дүүрэг/сумын засаг даргадаа, гуравдугаарт, баг/хорооны ИНХ -д хандана гэж хариулсан байна. Үүнээс харахад иргэд засаг даргатайгаа илүү ойр харилцаатай байдаг нь харагдаж байна. ИТХ -ын төлөөлөгч нартай холбогдоход хүндрэлтэй байдал өссөнийг дээр дурдсан. Учир нь ИТХ -ын төлөөлөгч нар долоо хоногийн нэг өдөр, зарим тохиолдолд сард нэг өдөр иргэдийн санал бодлыг сонсож, хүлээж авдаг. Түүний дараагаар холбогдох байгууллага/албан тушаалтанд дамжуулж өгдөг. Энэ нь иргэдэд шат дамжлага ихтэй, хүсэлт авах хугацаа нь хангалтгүй байдаг учраас засаг даргатайгаа холбогдох нь илүү үр дүнтэй байдаг гэж үзсэн байна. Мөн иргэд хөрөнгө мөнгө шаардсан асуудал ихээр дэвшүүлдэг учраас ИТХ -ын шийдвэрлэх боломж хязгаарлагдмал болдог байна.

Эмэгтэй төлөөлөгчдийг дэмжих байдал

- **ЭМЭГТЭЙ ИТХ -ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ЗӨВ ГЭЖ ЭМЭГТЭЙЧҮҮД ИЛҮҮ ДЭМЖИЖ БАЙНА.** Эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй гэдэгтэй нийт судалгаанд оролцогчдын 64 хувь санал нийлсэн бөгөөд дэмжсэн иргэдийн 56.7 хувь нь эмэгтэй оролцогчид байна. Эмэгтэй төлөөлөгчийн тоог нэмэгдүүлэхийг эсэргүүцсэн байдал 24 хувьтай бөгөөд үүний 60.9 хувийг эрэгтэй оролцогчид эзэлж байна.

ЗӨВЛӨМЖ

- **Иргэдийн санал авах шугамыг илүү хялбар дөхөм болгож, эргээд хариу өгөх процессыг хурдасгах хэрэгтэй**

Иргэд санал орон нутгийн хөгжил, дэд бүтэцтэй холбоотой асуудал гарахад голчлон засаг даргадаа ханддаг. Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай биечлэн уулзаж асуудлаа илэрхийлэх байдал өндөр байна. Гэвч дийлэнх хувь нь биечлэн уулзах боломжгүй, өөрийн санал хүсэлтээ хэрхэн илэрхийлэхээ мэдэхгүй байх тохиолдол өндөр байна. Иймд цахимаар болон утсаар мэдээлэл авах сувгийг түлхүү ашиглах, сурталчлах хэрэгтэй. Иргэдийн саналыг хүлээж аваад хариу өгөхгүй удах нь дахин ИТХ -д хандах сонирхлыг бууруулж байна. Иймд иргэдийн саналд хариу өгөх нэгдсэн процесс, журамтай болох хэрэгтэй.

- **Иргэд ИТХ-ын үйл ажиллагаа, шийдвэртэй холбоотой тайлан, мэдээлэл сайн авбал үнэлэмж нь нэмэгдэнэ**

Судалгаанаас ИТХ -ын талаарх мэдээлэл авсан байдал болон ИТХ -ыг үнэлэх байдал эерэг хамааралтай байгааг өмнө нь дурдсан. ИТХ өөрийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэртэй холбоотой мэдээллийг гол төлөв ИНХ дээр танилцуулж байна. Энэ нь иргэдэд хангалттай хүрч чадахгүй бөгөөд нийт иргэдийг хамруулж чадахгүй. Зөвхөн хөгшин настай хүмүүст л хүрж байна. ИНХ -аас гадна khural.mn сайт дээр мэдээллээ тавьдаг бөгөөд тус сайт руу иргэд орох байдал маш бага хувьтай байгаа юм. Иймээс үйл ажиллагааны тайлан, гаргасан шийдвэрийн талаарх мэдээллийг орон нутгийн болон үндэсний телевизээр, видео хэлбэрээр фэйсбүүкээр цацах нь иргэдэд сайн хүрнэ гэж үзэж байна.

- **Ажил эрхлэгч болон залуучуудын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх, санал хүсэлтийг авах боломжтой**

Ажил эрхлэгч болон залуучуудын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр цахим мэдээллийн сувгийг ашиглах нь хамгийн үр дүнтэй. Тус бүлгийн иргэд нь өөрийн санал хүсэлтээ facebook, twitter зэргээр хамгийн их илэрхийлдэг. Аймаг, дүүрэгтээ болж буй асуудлын талаар, сайжруулах шаардлагатай гэж үзсэн асуудлаа орон нутгийн нэгдсэн групп дээр постлох, зургийг авч тавих хандлага өндөр байдаг байна. Иймд тус сувгаар дамжуулан эдгээр хүмүүст хүрч болно. “Эм Эм Си Жи” ХХК -ын 2020 оны үндэсний медиа хэрэглээний судалгаагаар 20-24 насны залуучуудын 71.9 хувь, 25-35 насны ажил эрхлэгч бүлгийн 74.4 хувь facebook, twitter, youtube зэрэг сошиал сувгийг тогтмол ашиглаж байна. Интернетээс Монголд өрнөж буй үйл явдал, цаг үеийн шуурхай мэдээллийн талаар авч буй байдал 20-24 нас бүлэгт 38.3 хувь, 25-34 насны бүлэгт 44.3 хувьтай байна.

- **Иргэдийг хэсгийн, бүлгийн, нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах нь мэдээлэл хүргэх, ИНХ-д хамруулах, идэвхжүүлэхэд эерэг нөлөөтэй байна.**

Зарим аймаг, сумын сайн туршлагаар иргэдийн хэсгийн, бүлгийн, нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулж, мэдээлэл хүргэх, ИНХ -д хамруулах, идэвхжүүлэхэд маш үр дүнтэй арга болсон байна. Иргэдэд мэдээлэл хүргэхдээ биечлэн уулзах нь хамгийн үр дүнтэй байдаг боловч бүх хүмүүсийг хамруулж чадахгүй. Иймд хэсэг, бүлэг болгон ажиллавал илүү хялбар байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн бүлэг, залуучуудын бүлэг, 10-тын систем, малчдын бүлэг, ойн нөхөрлөл гэх мэт жишээг дурдаж болж байна. Ийнхүү хүмүүсийг бүлэгт хуваах нь тэдгээр бүлгийн тулгамдаж буй асуудалд илүү ойртох бөгөөд иргэдийн ач холбогдол өгөх байдал мөн нэмэгдэнэ.

- **Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарыг идэвхжүүлэх, урамшуулах, ажлыг нь үнэлэх бодлогыг сайжруулах**

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарын ажилдаа хандах байдал харилцан адилгүй байна. ИТХ -ын төлөөлөгч нар нь идэвхтэй ажилладаг баг/хорооны иргэдийн ИТХ -ын талаарх ойлголт, сэтгэгдэл, мэдээлэл авсан, үйл ажиллагааны тайлантай танилцсан байдал маш өндөр байна. Мөн

түүнчлэн иргэдийн санал хүсэлтээ илэрхийлэх, хуралд оролцох идэвх өндөр байдаг байна. Иймд ИТХ -ын төлөөлөгч нарын хандлагыг нэмэгдүүлэх нь иргэдийн хандлагад эергээр нөлөөлнө гэж үзэж байна. ИТХ -ын төлөөлөгч нар ажилдаа идэвх муутай байгаа гол шалтгаан нь цалингүй, хөрөнгө санхүүгийн эх үүсвэргүй, шийдвэр гаргалтад нөлөөлөх чадвар бага зэрэг нөлөөлж байна. Иймд үүнийг бодлогын түвшинд хэлэлцэж, сайжруулах арга замыг олох нь зүйтэй.

➤ ***Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарын хууль эрхзүйн мэдлэгийг сайжруулах нэгдсэн сургалт орох хэрэгтэй.***

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нарын боловсрол, эрхэлдэг ажил, мэргэжил, амьдарч буй орчин харилцан адилгүй байдаг. Үүнтэй холбоотойгоор төлөөлөгч нарын мэдлэгийн түвшин харилцан өөр байна. Иймд төлөөлөгч нарын заавал мэдэх ёстой хууль эрхзүйн мэдлэгийн талаар суурь ойлголтыг нэгдсэн байдлаар сургах, ИТХ -ын төлөөлөгчийн эрх үүргийг таниулах шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.



**Mongolian Marketing
Consulting Group**

YOUR
RESEARCH
PARTNER



- 📞 976 77000188
- ✉ info@mmcg.mn
- 🌐 www.mmcg.mn
- 🏢 Mongolian Marketing Consulting Group

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
Зүүн хүрээ хотхон, 203-р барилга, 4 давхарт